



**СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2022 ОНЫ  
ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

*Тайланг хянасан:*

***Төсвийн Ерөнхийлөн захирагч***

Засаг дарга .....Н.Алтаншагай  
(албан тушаал) (гарын үсэг) (огноо) .....

*Тэмдэг*

*Төлөвлөгөөг тайлагнасан:*

***Төсвийн Шууд захирагч***

Засаг даргын Тамгын газрын дарга.....Д.Төмөрбаатар  
(албан тушаал) (гарын үсэг) (огноо) .....

*Тэмдэг*

**СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
2022 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

**НЭГДҮГЭЭР ХЭСЭГ.**

**БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ**

№	Дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 2022 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
<b>ЗОРИЛГО 1. ҮНДЭСНИЙ БОЛОН ДЭД ХӨТӨЛБӨРҮҮДИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХҮРЭЭНД:</b>							
<b>Зорилт 1.1 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, 40-өөс дээш насны 1000 иргэний ажлын байрыг нэмэгдүүлэн, иргэдийн амьдралын түвшинг дээшлүүлнэ.</b>							
1	1.1.1 "Боловсрол" төслийг хэрэгжүүлэх	30,0 Дүүргийн төсөв	Хамрагдсан суралцагчдын тоо	"BOOM", "IELTS-600" зэрэг төслүүд хэрэгжсэн.	Сурагчдын сурлагын хоцрогдол арилсан байх	"Боловсрол" төслийн 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 6 зорилтын хүрээнд 30 ажлын хэрэгжилтийг ханган ажиллаж, биелэлт 89.7%-тай байна. Ерөнхий боловсролын төгсөх ангийн суралцагчдыг элсэлтийн ерөнхий шалгалтад бэлтгэх, багш нарыг чадавхжуулах зорилгоор "BOOM" төсөл, суралцагч, багш нарын гадаад хэлний мэдлэгийг дээшлүүлэх, олон улсын тэтгэлэгт хөтөлбөрт хамруулах зорилгоор "IELTS-600" зэрэг томоохон төсөл арга хэмжээнүүдийг зохион байгуулан ажиллаж байна. Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдыг элсэлтийн ерөнхий шалгалтад бэлтгэх, багш нарын мэдлэг ур чадварыг нэмэгдүүлэх, боловсролын үйлчилгээний чанарыг сайжруулах зорилгоор "BOOM" төслийг 2021-2022 оны хичээлийн жилд 2040 суралцагч, багш, сургуулийн удирдлагуудыг хамруулсан. Төслийн хүрээнд Боловсролын үнэлгээний төв, "Цахим сорилго" ХХК-тай хамтран "Цахим сорилго-2022" шалгалтыг зохион байгуулж, анализ хийн үр дүнг тооцож ажилласан. Элсэлтийн ерөнхий шалгалт өгөх сурагчдын судалгааг судлагдахуун тус бүрээр гаргаж, элсэлтийн ерөнхий	100%

						<p>шалгалтын цахим санд тулгалт хийн баталгаажуулж, сар тутамд сургуулиудаас ажлын тайланг авч, үр дүнг тооцон үүрэг чиглэл өгч ажилласан. Багш нарын ур чадварыг дээшлүүлэх, заах арга барилыг сайжруулах зорилгоор сар тутам заах аргын нэгдлийн багш нарын дунд туршлага судлах уулзалтуудыг бүсчлэн зохион байгуулсан.</p> <p>“BOOM” төслийн 2021-2022 оны хичээлийн жилийн үйл ажиллагааг дүгнэн, элсэлтийн ерөнхий шалгалтад 800 оноо авсан 5 суралцагч, суралцагчдаа амжилттай бэлтгэсэн 5 багш, амжилт үзүүлсэн Ирээдүй цогцолбор, 106, Хөгжил цогцолбор, 65, 151, Номуун сургуулиудыг Засаг даргын өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаж урамшуулсан. Ерөнхий боловсролын сургуулийн гадаад хэлний багш нарын ур чадварыг нэмэгдүүлэх, 11 дүгээр ангийн суралцагчдыг гадаадын их, дээд сургуулийн тэтгэлэгт хөтөлбөрт хамруулах зорилгоор “IELTS-600” төслийг 2 дахь жилдээ “Сантис” гадаад хэлний сургалтын төвтэй хамтран хэрэгжүүлж байна. 2022 онд дүүргийн Засаг даргатай байгуулсан Санамж бичгийн хүрээнд тус төслийг өргөжүүлэн гадаад хэлний 26 багш, ерөнхий боловсролын 23 суралцагчид хамруулан сургасан.</p>	
2	1.1.2 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, төслийг хэрэгжүүлэх	80.0 Дүүргийн төсөв	Хэрэгжсэн төслийн тоо	21 төсөлд 251.5 сая төгрөгийн санхүүжилт олгосон.	Шаардлага хангасан 20 төслийг шалгаруулж, санхүүжүүлэх	<p>“Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл”-ийг 2022-2024 онд хэрэгжүүлэхээр боловсруулж, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2022 оны 9/03 дугаар тогтоолоор батлуулан хэрэгжилтийг ханган ажиллалаа. Төслийг 3 зорилт, 15 арга хэмжээтэйгээр төлөвлөсөн ба хэрэгжилтийн явц 94.5%-тай байна. Ажил олоход хүндрэлтэй 4000 гаруй иргэдийн суурь судалгааг гарган, хөдөлмөр эрхлэлтийн эрэлт хэрэгцээг тодорхойллоо. Ажил олоход хүндрэлтэй иргэнд зөвлөгөө, мэдээлэл өгөх өдөрлөг, арга хэмжээг 4 удаа зохион байгуулж 1142 иргэнийг хамруулсан. “Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр”-ийн мэргэжил олгох 59 чиглэлийн сургалтад үсчин, гоо сайхан, гагнуур, гар утас засвар, машин механизм, оёдол эсгүүр, касс хатгамал, эсгий урлал, тогооч мэргэжлээр 71 иргэн суралцаж, “Чадамжийн гэрчилгээ” авсан. Бичил бизнес эрхлэгч 165 иргэнд аж ахуй эрхлэлтийн сургалт, захиалгат болон мэргэжлийн ур чадвар олгох, хөгжүүлэх, туршлага судлах 47 удаагийн сургалтад танхимаар 861, цахимаар 90, нийт 951</p>	90%

						<p>үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчийг хамруулсан. Азийн хөгжлийн банк, Иргэний нийгэм концерциум-аас тоног төхөөрөмжийн буцалтгүй дэмжлэгт 41 оёдлын үйлдвэр эрхлэгч 181,2 сая төгрөгийн тусламжид хамрагдаад байна. Хөгжлийн төвүүдийг түшиглэн бизнес инкубацийн үйлчилгээг явуулж тогтмолжуулан 407 иргэнд зөвлөн туслах үйлчилгээг үзүүлээд байна. “хамтдаа хөдөлмөрлөө-хамтдаа хөгжье”, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний борлуулалтын дэмжлэгийн арга хэмжээ”, “Сонгинохайрхан гоёл 2022” өдөрлөг арга хэмжээ зохион байгуулж, дүүргийн жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн бүтээгдэхүүнийг сурталчлан борлуулалтын дэмжлэг үзүүллээ. “Эс Пи Ар Райсинг” ХХК-ий “Surprise shop” салбар дэлгүүрт борлуулалтын шимтгэлгүй, талбайн түрээсгүйгээр худалдааны талбай гаргуулан 10 үйлдвэр эрхлэгчийн бүтээгдэхүүний борлуулалтад дэмжлэг үзүүлж, 26.8 сая төгрөгийн худалдаа хийгдлээ. Үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнээ олон тоогоор нийлүүлэх боломжтой 26 үйлдвэр эрхлэгчийн товч танилцуулгыг товхимол хэлбэрээр бэлтгэн хэвлэж, бараа бүтээгдэхүүний жагсаалтыг, үнийн саналтай нь боловсруулан төрийн болон төрийн бус байгууллага, төрөл бүрийн арга хэмжээнүүдийн худалдан авалтад санал болгон, танилцуулах ажлыг хийж нийт 88.1 сая төгрөгийн борлуулалт хийгээд байна.</p>	
3	1.1.3. “Авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	Хэрэгжилт 90 хувь	<p>“Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хангах төлөвлөгөө биелэсэн байх</p>	<p>“Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг дүүргийн хэмжээнд хэрэгжүүлэх 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 6 бүлэг, хэрэгжүүлэх 20 ажлын хүрээнд боловсруулан батлуулж хэрэгжилтийг 90.0 хувьтай тайлагнаад байна. Төлөвлөгөөний хүрээнд дараах ажлуудыг зохион байгуулан ажилласан. Үүнд:          Ёс зүйн зөрчилгүй хамт олон аяныг дүүргийн нутгийн захиргааны 158 байгууллагын дунд 1 сарын хугацаатай зарлаж, үр дүнг тооцон ажилласан; Төрийн албан хаагчийг авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, авлигыг үл тэвчих үзэл, авлигын эсрэг боловсролыг дээшлүүлэх зорилгоор сургалт, сурталчилгааны ажлуудыг зохион байгуулсан. 2022 онд Хууль зүй, дотоод хэргийн яам, Авлигатай тэмцэх газар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, дүүргийн</p>	90%

						Прокурорын газар, дүүргийн Цагдаагийн газар, төрийн бус байгууллагуудтай хамтран 4 удаагийн сургалтыг зохион байгуулсан. Сургалтад нийт 562 төрийн албан хаагч, хэсгийн ахлагч хамрагдсан. Авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, иргэдэд зөвлөгөө, мэдээлэл өгөх, сурталчлах зорилгоор АТГ-аас бэлтгэн гаргасан зураг хуудас, тараах материалыг иргэдэд хүргэж ажилласан. Энэ ажлын хүрээнд 15 төрлийн 2385 сурталчилгааны материалыг хувилж тараасан. “Авлигатай тэмцэх газар”, “АТГ-Олон нийтийн төв” пэйж хуудсуудад төрийн өмчийн 159 байгууллагын төрийн албан хаагчид нэгдэж, мэдээ, мэдээллээр хангагдах боломжийг бүрдүүлсэн.	
4	1.1.4. “Гэр хорооллын 10,000 айл өрхийн ариун цэврийн байгууламжийг сайжруулах” төсөл хэрэгжүүлэх	5,0 сая Дүүргийн төсөв	Хамрагдсан өрхийн тоо	Гэр хорооллын 25 хорооны 350 өрхийн ариун цэврийн байгууламжийг шинээр суурилуулсан.	350 өрхийн ариун цэврийн байгууламж шинэчлэх	Агаар, хөрсний бохирдлыг бууруулах чиглэлээр “Гэр хорооллын 10,000 айл өрхийн ариун цэврийн байгууламжийг сайжруулах” төслийг боловсруулан дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын А/26 дугаар тогтоолоор батлуулсан. Дүүргийн төсвийн 5.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар гэр хорооллын 31 хорооны 3000 айл өрхийн нүхэн жорлонг шинээр солих ажлыг хийж гүйцэтгэхээр төлөвлөсөн. Төлөвлөгөөний дагуу 1, 2, 3, 4, 5, 6, 7, 8, 9, 10, 11, 20, 21, 22, 23, 24, 25, 26, 28, 30, 31, 32, 33, 34, 35, 36, 39, 40, 41, 42, 43 дугаар хороодын нийт 3000 айл өрхийн нүхэн жорлонг шинээр суурилуулж, сайжруулсан ариун цэврийн байгууламжийг 7,1 хувиар нэмэгдүүлсэн. Гэр хорооллын 31 хорооны 3000 айл өрхийн 5600 иргэнд ариун цэврийн байгууламжийн зохистой хэрэглээний хандлагыг бий болгох талаар сургалт зохион байгуулж, 3000 ширхэг гарын авлага тарааж, төсөл хэрэгжүүлсэн айл өрхүүдийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор 30000 ширхэг нарс модыг тарих ажлыг зохион байгуулж ажилласан.	100%
5	1.1.5. “Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх” төсөл хэрэгжүүлэх	30.0 Дүүргийн төсөв	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	Танхимаар 80, цахимаар 254 удаагийн сургалтыг зохион байгуулж 7500 иргэнийг хамруулсан	ӨЭМТ-дэд дархлаажуулалтын цэгийг нэмэгдүүлэх	“Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх” төслийн 2022 оны төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Төслийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд цахимаар 1694, танхимаар 851 удаагийн сургалтыг зохион байгуулж, нийт 187,352 иргэнийг хамруулсан. Төслийн зорилтуудын хүрээнд: Дүүргийн хэмжээнд 42 өрхийн эрүүл мэндийн төв тусдаа байранд үйл ажиллагаа явуулж 80.5% буюу 33 төвийн байранд товллын дархлаажуулалтын үйл ажиллагаа явагдаж байна. 2022 онд 3 хорооны ӨЭМТ-д	100%

						шинээр дархлаажуулалтын нэгж нээн ажиллуулж байна. Тайлант хугацаанд 2.5 тэрбум төгрөгийн үнэ бүхий 204,044 хүн тун вакциныг дагалдах хэрэгслийн хамт 33 дархлаажуулалтын нэгжид хүргэлээ. В вируст гепатитын эсрэг вакцинаар дархлаажуулах ажлын хүрээнд явуулын багаар 26 байгуулагын ажилтан, 3 их, дээд сургуулийн оюутан 1259 иргэнийг I тунд, 1224 иргэнийг II тунд, 673 иргэнийг III тунд хамрагдуулсан. 2022 оны байдлаар сүрьеэгийн амбулаторийн үзлэг 4408, диспансерийн үзлэг 2864, урьдчилан сэргийлэх үзлэгт 25,204 иргэнийг хамруулж, 363 иргэнийг эмчилгээнд оруулж 62 иргэн бүрэн эдгэрээд байна. “Сүрьеэгүй дүүрэг-Хамтын ажиллагаа” дүүргийн зөвлөгөөнийг зохион байгуулж 105 хүнийг хамрууллаа. “Хүүхэд, өсвөр насанд тохиолдох сүрьеэгээс сэргийлэх, оношлох, эмчилгээний менежмент” сэдэвт 2 өдрийн сургалтыг зохион байгуулж 58 эмчийг чадавхжууллаа. Дүүргийн ерөнхий боловсролын сургуулийн нийгмийн ажилтнуудтай “Өглөөний уулзалт” арга хэмжээг зохион байгуулж өсвөр насныхны дундах БЗДХӨ, жирэмслэлтийн талаар мэдээлэл олгож, санал солилцлоо. Өсвөр үе, нөхөн үржихүйн кабинет байгуулах “Ворлд шэйр” Олон улсын байгууллагатай хамтран хэрэгжүүлэхээр 2 удаагийн уулзалтыг зохион байгуулж, хамтран ажиллах санамж бичиг үзэглэж, 2023 онд төслийг хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Тайлант хугацаанд Ковид-19 халдварын эсрэг дархлаажуулалтад 25,315 иргэн хамрагдсан.	
<b>Хэсгийн дундаж хувь</b>						<b>96%</b>	
<b>ЗОРИЛГО 2. НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН 2016-2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ДҮҮРЭГТЭЙ ХАМААРАЛТАЙ ЗААЛТУУДЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХҮРЭЭНД:</b>							
<b>Зорилт 2.1 Ковид-19 цар тахлаас үүдэлтэй нийгэм, эдийн засгийн хүндрэлийг даван туулах онцгой бодлого</b>							
1	2.1.1. Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбоотой харьяалах нутаг дэвсгэрийн	-	Зохион байгуулсан арга хэмжээ, тоо	Нийслэлийн хэмжээнд 2 голomt, 53 тохиолдлыг илрүүлэн хяналтад авсан.	Цар тахлын голomt, ойрын болон дам хавьтагчдыг илрүүлж, шинжилгээнд бүрэн хамруулах	Цаг үеийн нөхцөл байдал, халдварын дэгдэлттэй уялдуулан 2022 оны А/02 дугаар захирамжаар шуурхай штабын үйл ажиллагааны хугацааг сунгаж, А/03, А/14 дүгээр захирамжаар эрүүл мэндийн байгууллагуудын бэлэн байдал, шуурхай штабын бэлэн байдлыг хангах ажилд (бие бүрэлдэхүүний хоол, байрны түрээс, урсгал зардал гэх мэт) 40.6 сая төгрөгийг зарцуулсан. Дүүргийн Онцгой комиссын Шуурхай штабын үйл ажиллагааг дүүргийн Засаг даргын	100%

	хэмжээнд хорио цээр, хязгаарлалтын дэглэм тогтоож, хүндрэлийг даван туулах арга хэмжээ авна.					А/129 дүгээр захирамжаар 2022 оны 4 дүгээр сарын 01-ний өдрөөс эмнэлгийн бүлгийн зохион байгуулалтад шилжүүлсэн ба коронавируст халдвар (Ковид-19)-ыг эсрэг хариу арга хэмжээний багийг дүүргийн Засаг даргын А/206, "Шуурхай хариу арга хэмжээний штаб"-ыг А/601 дүгээр захирамжаар батлан ажиллаж байна. Шуурхай штаб 5 хүний бүрэлдэхүүнтэй, "Эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн төлөвлөлт"-ийг 3 бүлэг, 13 арга хэмжээтэйгээр төлөвлөн, хэрэгжилтийг ханган ажиллаж, 2022 оны байдлаар шинээр батлагдсан 24,971 тохиолдлыг бүртгэж, 2221 иргэнийг эмнэлэгт зөөвөрлөж, ойрын хавьтал-32,026 хүнийг тусгаарлан эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлсэн байна. Дүүргийн Онцгой комисс, шуурхай штабын бие бүрэлдэхүүнийг чадавхжуулах сургалт, дадлагыг 6 удаа зохион байгуулж, нийслэлийн хэмжээний үзүүлэх ажил, сургалтуудад 2 удаа хамрагдаж, "Гамшгийн эрсдэлийн үнэлгээ", "Гамшгийн үеийн хариу арга хэмжээ"-нд суралцлаа.	
--	--	--	--	--	--	--	--

**Зорилт 2.2** Хүний хөгжлийн бодлого:

2	2.2.1. Багшийг хөгжүүлж, ур чадварыг нь сайжруулах "Чадвартай багш-Чанартай боловсрол" төслийг хэрэгжүүлж, мэргэжлийн багшийн эзлэх хувийг нэмэгдүүлнэ.	-	Хэрэгжүүлсэн төсөл, хамрагдсан багш нарын тоо	Нийт багшийн 12 хувийг мэргэшүүлэх болон давтан сургалтад хамруулсан.	Мэргэшүүлэх болон давтан сургалтад хамрагдсан багшийн эзлэх хувийг 15 хувьд хүргэх	Нийслэлийн тэргүүний сургууль, цэцэрлэгийн 2021-2022 оны хичээлийн жилийн шалгаруулалтад ерөнхий боловсролын 1 сургууль, 6 цэцэрлэг шалгарч, 81,0 сая төгрөгийн мөнгөн урамшуулал олгосон байна. Багшийн мэргэжил дээшлүүлэх институтээс жил бүр зохион байгуулагддаг 1, 5, 10 дахь жилийн үндсэн сургалтад ЕБС-ийн 721, СӨБ-ын 335 багш хамрагдсан. Боловсролын хэлтэс, БМТТ-ийн ээлжит хичээлийн контентын ахлах, зөвлөх багш нартай хамтран цахим хэлбэрээр явуулсан сургалтад бага боловсролын сургалтын 39 менежер, бага ангийн 130 багш, Нийслэлийн Боловсролын газрын Зөвлөлдөх багаас зохион байгуулсан "Суурь боловсролын чанарыг сайжруулахад МТХ-ийг оновчтой ашиглах нь" төслийн хүрээнд багшид зориулсан сургалтын цахим хэрэглэгдэхүүнийг хэлэлцэх сургалтад төрийн өмчийн 26 сургуулийн 90 багш тус тус хамрагдсан. Боловсролын Үнэлгээний төв, БШУЯ-аас хамтран зохион байгуулсан сургуульд бэлтгэгдсэн байдлыг үнэлэх судалгааны арга зүйн сургалтад ерөнхий боловсролын сургуулийн 1 дүгээр ангийн 180 гаруй бага ангийн багш, бага	100%
---	---	---	---	---	--	---	------

						<p>боловсролын 35 сургалтын менежер хамрагдсан. "Боловсролын чанарын шинэчлэл" төслөөс зохион байгуулсан "Бага ангийн сурагчдын математик чадварыг хөгжүүлэх арга зүй" цахим сургалтад бага ангийн 800 гаруй багш хамрагдсан. "Удирдлагын манлайлал" сэдэвт сургалтыг ерөнхий боловсролын сургуулийн 70 багш, удирдах ажилтнуудыг хамруулан зохион байгуулсан. Дүүргийн ЗДТГ-аас сургуулийн өмнөх боловсролын байгууллагын багш нарын дунд "Бүтээлч багш-Шилдэг бүтээл" арга хэмжээг зохион байгуулж, сургуулийн өмнөх боловсролын 60 байгууллагын нийт 400 багш, арга зүйч, эрхлэгч нар хамрагдсан.</p>	
3	<p>2.2.2. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн сургалтын хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмжийг сайжруулж, хүүхдэд ээлтэй эрүүл, аюулгүй орчин бүрдүүлнэ.</p>	-	<p>Төсөлд хамрагдсан ЕБС-иудын тоо</p>	<p>Их засвар, дулаан техникийн шинэчлэлийн төсөлд хамруулсан 69.</p>	<p>85 ЕБС-ийг их, засвар, дулаан техникийн шинэчлэлийн төсөлд хамруулах</p>	<p>2021-2022 оны хичээлийн жилд сургууль, цэцэрлэгийн барилгын дулаан алдагдлыг бууруулах, эрчим хүчний үр ашгийг нэмэгдүүлэх, засвар шинэчлэлт хийх төслийн хүрээнд нийслэлийн төсвийн 1.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Ирээдүй цогцолбор сургуулийн дээврийн их засвар, 107 дугаар цэцэрлэгийн сантехникийн засвар, "Хөгжил" цогцолбор сургуулийн дээврийн засвар, 42 дугаар сургуулийн хичээлийн 2, 3-р байрны барилгын гадна фасад, цонх, дээврийн дулаалгын их засвар, "Цэвэр агаар сан" төслийн 640.0 сая төгрөгийн санхүүжилтээр 42 дугаар сургууль, 81 дүгээр цэцэрлэгийн цэвэр, халуун ус, төвийн дулаан шугамд холбох ажил хийгдсэн. 2022 онд өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын хүрээнд боловсролын салбарт нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгөөр нийт 1,7 тэрбум төгрөгийн их засварын 14 ажил хийгдээд байна. Дүүргийн хэмжээнд цэцэрлэгийн хүртээмж багатай хороодын нутаг дэвсгэрт байрлах цэцэрлэгийн анги бүлгийг шинээр нэмэгдүүлсэнтэй холбогдуулан 79, 148, 156, 158, 188, 227, 253, 260, 263, 269, 271, 273, 244 дүгээр цэцэрлэгүүдийг зөөлөн эдлэлээр хангах ажлыг зохион байгуулсан.</p>	90%
4	<p>2.2.3. Ерөнхий боловсролын сургуулийн хоол, үйлдвэрлэл, үйлчилгээнд хүнс ханган нийлүүлэх</p>	-	<p>Нийтлэг шаардлагыг хангаж ажиллах</p>	<p>151-р сургуульд хоол үйлдвэрлэлийн загвар гал тогоо</p>	<p>Нийт сургуулийн 25 хувийг хүнс ханган нийлүүлэх нэгдсэн</p>	<p>Боловсролын мэдээллийн технологийн төвийн /esis.edu.mn/ программын кодыг төрийн өмчийн 54 цэцэрлэг, төрийн бус өмчийн 53 цэцэрлэгт хүргүүлж, хоол үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд цахим захиалгын систем нэвтрүүлсэн. Сургууль, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний мэдээллийг /esis.edu.mn/ цахим хэлбэрт шилжүүлсэнтэй</p>	100%



	нэгдсэн тогтолцоог нэвтрүүлж, хүүхдийг эрүүл баталгаат хоол хүнсээр хангана.			байгуулах ажил хийгдсэн.	тогтолцоонд шилжүүлэх.	холбогдуулан төрийн ба төрийн бус өмчийн 35 сургуулийн 151 аргазүйч, эмч, тогооч нарт хүүхдийн хоолны илчлэг тооцох аргачлал, хоол үйлдвэрлэлийн цахим системийн талаар цахим болон танхимаар сургалт зохион байгууллаа.	
5	2.2.4. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн цахим бүртгэл элсэлтийг үргэлжлүүлэх, мэдээллийн болон удирдлагын системийг боловсронгуй болгох, цахим контент хөгжүүлэх замаар бүх шатны боловсролын байгууллагын цахим хэрэглээ, үйлчилгээг нэмэгдүүлнэ.	-	Бүх шатны боловсролын байгууллагын цахим хэрэглээ, үйлчилгээг нэмэгдүүлэх	Нийт сургууль, цэцэрлэгийн 70 хувь цахим системээр элсэлт бүртгэлийн үйл ажиллагаагаа зохион байгуулсан.	Бүх сургууль, цэцэрлэгийн элсэлтийн үйл ажиллагааг цахимаар зохион байгуулах	Дүүргийн Засаг даргын А/178 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг 2022-2023 оны хичээлийн хамтран сургах тойргийг тогтоон, 1 дүгээр ангид элсэн орох 6 настнууд, багшийн нөөцийн судалгааг гаргаж, Нийслэлийн Боловсролын Газарт хүргүүлээ. БШУСайдын 2021 оны "Цахим контентын сан бүрдүүлэх арга хэмжээний тухай" А/397 дугаар тушаалын дагуу Боловсролын мэдээллийн технологийн төвийн "Контент боловсруулах лаборатори байгуулах" төслийн хүрээнд 12, Ирээдүй цогцолбор, 151 дүгээр сургуулиудыг 57,0 сая төгрөгийн өртөгтэй компьютер, видео бичлэгийн камерын иж бүрдлээр хангасан. БШУСайдын 2021 оны "Ээлжит хичээлийн сан бүрдүүлэх тухай" А/237 тушаалын хүрээнд контентыг бэлтгэх арга зүйд суралцаж, цахим контентын сан бүрдүүлэх сонгон шалгаруулалтад оролцох зорилгоор зайн хэлбэрээр явуулсан сургалтад бага боловсролын сургалтын 169 менежер, бага ангийн багш нар хамрагдсан. 2021-2022 оны хичээлийн жилд www.econtent.edu.mn цахим сайтаар дамжуулан ерөнхий боловсролын 1-12 дугаар ангийн сурах бичиг болон теле хичээл, интерактив хичээлүүдийг сурагчдад хүргэсэн.	100%
6	2.2.5. Зорилтот бүлгийн өрх, иргэдийг нийгмийн хамгааллын суурь үйлчилгээнд хамруулна.	-	Хамрагдах өрх, иргэний тоо	Өрхийн амьжиргааг дэмжих төсөлд 138 өрхийн 524 хүн ам, эх, хүүхдийн эрүүл мэндийн төсөлд 339 өрхийн 1891 иргэн сонгогдсон.	Нийгмийн хамгааллын суурь үйлчилгээнд 300 иргэнийг хамруулах	Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэнд Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээг давхардсан тоогоор 51,983 өрхийн 139,555 том хүн, 149,734 хүүхэд, нийт 289,289 иргэнд 3,440,244,000 төгрөгийн үйлчилгээ үзүүлсэн. Дэлхийн зөн Монгол Олон Улсын байгууллагатай хамтран хэрэгжүүлэх "Хамтдаа даван тууль" төслийн ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг дүүргийн Засаг даргын А/16 дугаар захирамжаар батлан төслийн танилцуулга уулзалтыг зохион байгуулж, хамтран ажиллах гэрээ хийсэн. Төслийн үйл ажиллагааны хүрээнд өрхийн амьжиргааг дэмжих 500 өрхийг 35, 40 дүгээр хорооноос, эх, хүүхдийн эрүүл мэндийн төсөлд хамрагдах 750 өрхийг 1, 2, 6, 7, 9, 22, 31 дүгээр	100%

						хорооноос сонгон судалгааг сонгон шалгаруулах багт хүргүүлснээр өрхийн амьжиргааг дэмжих төсөлд 138 өрхийн 524 хүн ам, эх, хүүхдийн эрүүл мэндийн төсөлд 339 өрхийн 1891 иргэн сонгогдоод байна. Төслийн үйл ажиллагаанд оролцох төрийн бус байгууллагын ажилтан, сайн дурын идэвхтэн 20 хүнийг “Эх хүүхдийн эрүүл мэнд” 5 удаагийн сургалтад хамруулж чадавхжууллаа. “Эх хүүхдийн эрүүл мэнд” төсөлд сонгогдсон 2 төрийн бус байгууллага 150 ээжийг “Хүүхдийн хоол”, “Хүүхдийн асаргаа”, “Хүүхэд хамгаалал” чиглэлээр сургаж, өрх бүрт хүнсний тусламжийн багцийг олголоо. Багцад 88,700 төгрөгийн үнэ бүхий 6 төрлийн хүнсний бүтээгдэхүүн багтсан. “Өрхийн амьжиргааг дэмжих” төслийн хүрээнд “Харааны бэрхшээлтэй хүүхэд, залуучуудын холбоо”, “Шинэ зууны гэр хороолол” төрийн бус байгууллагууд сонгогдон бичил бизнесийн 2 төслийг сонгогдсон хороодод хэрэгжүүлж байна. Тус ТББ-ууг ДЗОУБ-аас 48.0 сая төгрөгийн санхүүжилт авсан ба хүлэмжийн аж ахуй, тахианы аж ахуй эрхлэх бичил төслүүдийг 100 өрхөд хэрэгжүүлж байна.	
7	2.2.6. Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжин цагаар ажиллах боломж, нөхцөлийг бүрдүүлнэ.	-	Хамрагдах иргэн, тоо	Аж ахуй эрхлэлтийн сургалтад 50 иргэнийг хамруулж 2 багт 20.0 сая төгрөгийн буцалтгүй дэмжлэг олгосон.	80 залуучуудын бүлэгт дэмжлэг үзүүлэх.	Дүүргийн хэмжээнд 18-34 насны 243 иргэнд хөдөлмөр эрхлэх ур чадварын үнэлгээ хийж 110 иргэнд хувийн төлөвлөгөө боловсруулж 90 иргэнийг сургалтад хамруулсан. Тайлант хугацаанд ажил хайж хандсан 112 иргэнийг ажилд зуучилсан. Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газраас зохион байгуулсан “Старт-ап” залуучуудад санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд 47 иргэнийг бүртгүүлж сонгон шалгаруулалтад оролцуулж “Зеропластик” баг шилдэг 13-т үлдэж амжилттай оролцсон. Мөн дүүргийн хэмжээнд залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн “Старт-ап” залуучуудад санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээг Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газартай хамтран зохион байгуулж 12 багаас сонгон шалгаруулалт хийж тэргүүн байр эзэлсэн “BEELOG” болон “ANON” брэнд багийн төсөлд 20,0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгосон. 18-34 насны ажил хайгч залуучуудад ажил хайх, хөдөлмөрийн гараагаа эхлүүлэх чиг баримжаа олгох	100%

						сургалт зохион байгуулж дүүргийн хэмжээнд 900 иргэн хамруулж чадавхжуулсан.	
8	2.2.7. Зохистой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ.	-	Хамрагдах иргэн, тоо	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тохирсон түр болон цагийн 320 ажлын байр	Хөгжлийн бэрхшээлтэй 100 иргэнийг ажлын байраар хангасан байна.	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 15.1.4.хөгжлийн бэрхшээлтэй иргэн, 6 сараас дээш хугацаагаар ажилгүй байгаа иргэнийг ажилд авч, 12 сараас доошгүй хугацаагаар ажлын байраар хангасан ажил олгогчид хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 12 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний урамшууллыг нэг удаа олгох, заалтын хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Тус арга хэмжээний хүрээнд -2021 онд Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажлын байраар ханган ажиллаж байгаа Баян хүдэр” ХХК, “Хөх тэнгэр констракшн” ХХК-тай ажил олгогчийн урамшуулал олгох гэрээ байгуулсан. 2022 оны гэрээний дүгнэлтийг үндэслэн ажил олгогчийн урамшуулал 10,800,000 төгрөг олгосон. 2022 онд хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг байнгын ажлын байраар ханган ажиллаж байгаа 17 аж ахуй нэгж байгууллагатай ажил олгогчийн урамшуулал олгох гэрээ байгуулан ажиллаж байна. 2022 онд “Алаг тараг” ХХК, Хаппи чойс, ХХК, “Ховор угалз” ХХК, Хос эрхэм ХХК, Гал дөш ХХК, Сод эрдэм эрхэм ХХК, Илэгү баян ХХК, Норд роуд ХХК, Чиглэл ХХК, Эндлэс энерги ХХК, Номгон түшиг ХХК, Универсаль дизайн ХХК, Эко гифт ХХК, Хутугун охид ХХК аж ахуй нэгж байгууллагатай ажил олгогчийн урамшуулал олгох гэрээ байгуулан ажиллаж байна. Хөдөлмөрийн зах зээлийн LMIS программд Хөгжлийн бэрхшээлтэй 34 иргэнийг ажил хайгчаар бүртгэн зөвлөгөө мэдээлэл өгснөөс 25 иргэн ажлын байранд зуучлагдан орлоо.	30%
<b>Зорилт 2.3</b> Ногоон хөгжлийн бодлого:							
9	Нийслэлийн ногоон байгууламжийг сайжруулах оновчтой менежментийг хэрэгжүүлэн, дүүрэг бүрд цэцэрлэгт хүрээлэн	-	Ногоон байгууламжийн хэмжээ, хувь	18 цэцэрлэгт хүрээлэнг байгуулсан. Нэг хүнд ногдох ногоон байгууламжийн хэмжээ 4.8 м2	1 цэцэрлэгт хүрээлэн байгуулж, нэг хүнд ногдох ногоон байгууламжийн хэмжээг 0.64 м2-аар нэмэгдүүлсэн байна.	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр төслийн захиалгаар Баянхошуу дэд төвийн бүтээн байгуулалтын хүрээнд 9, 24 дүгээр хорооны нутаг дэвсгэр Баянхошуу хайрханы энгэр бэлд цэцэрлэгт хүрээлэн байгуулах ажлын гүйцэтгэгчээр “Дүүрэн трейд” ХХК шалгарсан. Нийт 2 га талбайд 8336 м <sup>2</sup> ногоон байгууламж нийтийн бие засах газар, хөлбөмбөг, сагсан бөмбөгийн талбай, хүүхдийн тоглоомын талбай, эргүүлийн пост, авто машины зогсоол хийгдэхээр төлөвлөгдсөн. Цэцэрлэгт	100%

	<p>байгуулж, нэг хүнд ногдох ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлнэ.</p>				<p>хүрээлэнгийн бүтээн байгуулалтын ажлын нөлөөлөлд өртсөн 1 иргэнд 70,6 сая төгрөгийн нөхөн олговрыг олгосон. Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 39 дүгээр хорооны нутаг дэвсгэрт Хамбын овооны цэцэрлэгт хүрээлэнгийн ажил 2022-2023 онд хийгдэхээр төлөвлөгдөн зураг төсөв боловсруулагдах шатандаа байна. “Тэрбум” мод үндэсний хөдөлгөөний хүрээнд бичил цэцэрлэгт хүрээлэн байгуулах байршлын судалгааг гаргаж 8 байршилд цэцэрлэгт хүрээлэн байгуулахаар төлөвлөсөн. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>-14, 15, 16 дугаар хороо буюу нэгдүгээр хорооллын арын зам дагуух нийтийн эдэлбэр газарт байсан 477 гарааш, контейнерыг бүрэн чөлөөлж, 3.5 га талбайд хийгдэх тохижилт, бүтээн байгуулалтын зураг төсөлд оршин суугчдын санал хүсэлтийг тусган ажилласан. Гарааш чөлөөлсөн талбайд зураг төслийн дагуу авто зам пандус, спорт талбай, тоглоомын талбай, тайз, далан, 800 м явган хүний зам, 800 м дугуй зам, 600 м<sup>2</sup> эко хавтан, 4000м<sup>2</sup> талбайд зүлэг, явган замыг дугуй замнаас тусгаарласан зурваст 2000 ш мод сөөг тарьсан, ногоон байгууламжийн усалгааны систем, гүний худгийг хийж гүйцэтгэсэн. Тохижилт, бүтээн байгуулалтын ажлын ерөнхий гүйцэтгэгчээр нийслэлийн Хот тохижилтын газар ОНӨААТҮГ, туслан гүйцэтгэгчээр “Дабель констрашкн” ХХК нь гэрээ байгуулан ажиллаж байна. Ажлын гүйцэтгэл 80%-тай.</li> <li>-17 дугаар хороонд Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 32, 33 дугаар байрны дунд байрлах хүүхдийн тоглоомын талбай, ногоон байгууламж, авто зогсоол, хөл бөмбөгийн талбай, хороолол дундах авто замын засвар болон нийтийн эзэмшлийн зам талбайн тохижилтын ажлыг “Ганбүрд” ХХК болон “Тэнгэрийн модон багана” ХХК хамтран гүйцэтгэн хүлээлгэж өгсөн.</li> <li>-6, 18 дугаар хороонд хийгдэх бичил цэцэрлэгт хүрээлэнгийн төсвийн тооцоо, зураг төслийг боловсруулагдсан боловч зориулалт өөрчлөгдөж авто машины зогсоолын ажил хийгдсэн.</li> <li>-19 дүгээр хорооны 62 сургуулийн ард гараашийг чөлөөлсөн талбайд нийслэлийн хөрөнгө оруулалтаар амрах модон сүүдрэвч 3, модон сандал 12, хогийн сав 7, явган зам 631.34</li> </ul>	
--	--	--	--	--	---	--

						<p>мкв, авто машины зогсоол, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн авто машины зогсоол, зам талбайн гэрэлтүүлэг, 774,87 мкв талбайд ногоон байгууламж, хүүхдийн тоглоомын талбайг зэрэг ажлуудыг хийж хүлээлгэн өгсөн.</p> <p>-12 дугаар хороонд Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар “Тэнгэрийн модон багана” ХХКомпани Хүүхдийн тоглоомын талбайн шинэчлэх ажлыг багцаар хийсэн.</p> <p>Мөн дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр нийтийн эзэмшлийн талбайн тохижилт ажлыг 39,9 сая төгрөгөөр “Голден Ийгл Стар” ХХК хийж гүйцэтгэсэн.</p>	
10	Хотын тоосжилтыг бууруулж, иргэдэд ээлтэй орчныг бүрдүүлнэ.	-	Бүтээн байгуулалтын тоо, хэмжээ	Стандартад нийцсэн амралт, спорт, хүүхдийн тоглоомын талбай 23	Стандартад нийцсэн амралт, спорт, хүүхдийн тоглоомын талбайг 9-өөр нэмэгдүүлэх	<p>Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 3 дугаар хороонд Хөл бөмбөгийн талбай бүхий спортын цогцолбор барих ажлын гүйцэтгэгчээр “Аглут” ХХК шалгарсан.Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө 2 дугаар хороонд гудамжны тохижилтын ажлыг “Гидро тех” ХХК 59,990,000 төгрөгөөр, 12 дугаар хороо мини хөл бөмбөгийн талбайг “Тэнгэрийн модон багана” ХХК 198,326,000 сая төгрөгөөр, 15 дугаар хороонд хүүхдийн тоглоомын талбайг “Ньюсиндкат” ХХК 50,0 сая төгрөгөөр, 27 дугаар хороонд Чийрэгжүүлэлтийн тоног төхөөрөмж бүхий тоглоомын талбай байгуулах ажлыг “Би Жи Роял” ХХК 76,5 сая төгрөгөөр, 37 дугаар хороонд Хүүхэд залуучуудын чөлөөт цагаа өнгөрөөх талбайг “ЭТ” ХХК 9,990,000 төгрөгөөр тус тус хийж гүйцэтгэн комисст хүлээлгэн өгсөн. Мөн 16 дугаар хороо хөл бөмбөг, сагсан бөмбөгийн талбайн цутгалт, хашаа хийгдсэн, 17 дугаар хороо сагсны болон хөл бөмбөгийн талбай засварын ажлыг “Ньюсиндкат” ХХК гүйцэтгэсэн.</p> <p>Нийслэлийн төсвийн хөрөнгө, хот тохижилтын хөрөнгө оруулалтын 32,0 сая төгрөгөөр 31 дүгээр хорооны хайрхан 8 дугаар гудамжинд Сагсан бөмбөгийн талбай байгуулах ажлыг “Юу Би Жи” ХХК гүйцэтгэсэн. Нийслэлийн Засаг даргын А/306 дугаар захирамж, дүүргийн Засаг даргын 2022 оны А/306 дугаар захирамжийн хүрээнд 1, 2, 4, 5, 6, 18, 19, 27, 35 дугаар хороодын нутаг дэвсгэрт байрлах 17 тоглоомын талбайн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангуулан засварлах ажлыг “Дэд бүтцийн хөгжлийн алба” ОНӨААТҮГ хийж гүйцэтгэсэн. Мөн Нийслэлийн орон нутгийн</p>	70%

					хөгжлийн сангийн хөрөнгөөр “Прогресс интермедишн” ХХК нь 15 дугаар хороонд 46,6 сая, 20 дугаар хороонд 68,6 сая, 29 дүгээр хороонд 42,6 сая төгрөгний, нийт 157,8 сая төгрөгийн санхүүжилтээр авто зогсоол, явган хүний замын ажил, Монгол туургатны зам ХХК нь 18 дугаар хороонд 66,0 сая төгрөгний авто машины зогсоолын ажил, “Ихрийн бууц” ХХК нь 27 дугаар хорооны 3 байршилд зам талбайн эвдрэлийг засаж, зөвшөөрөлгүй газар эзэмшиж байсан гарааш, чингэлэг чөлөөлсөн талбайд нийтийн эзэмшлийн зам, тохижилт авто зогсоол болгон өөрчлөлт хийж тохижуулах ажлыг 55,6 сая төгрөгөөр, “Мега титан” ХХК нь 30 дугаар хороонд чулуун авто зам тавих ажлыг 77,6 сая төгрөгөөр, “Этүгэн жим” ХХК нь 36 дугаар хороонд 43,6 сая төгрөгөөр, 40 дүгээр хороонд 49,4 сая төгрөгөөр шороон замын нөхцөл сайжруулах ажилд хийж гүйцэтгэн, байнгын ашиглалтад оруулсан.		
11	Бохирдож доройтсон, үржил шимээ алдсан хөрсийг нөхөн сэргээх хүн амын эрүүл мэндийг хамгаалах, салбар дундын уялдааг хангасан нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх “Хөрсний бохирдолгүй хот” арга хэмжээг хэрэгжүүлнэ.	-	Стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийн тоо	3,710 өрх стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламж ашиглаж байна.	Нийт 13 хорооны 350 айл, өрхийг цэврийн байгууламжтай болгосон байна.	Дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт агаар, хөрсний бохирдлыг бууруулах чиглэлээр “Гэр хорооллын 10,000 айл өрхийн ариун цэврийн байгууламжийг сайжруулах” төслийг боловсруулан дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын А/26 дугаар тогтоолоор батлуулсан. Дүүргийн төсвийн 5.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар гэр хорооллын 31 хорооны 3000 айл өрхийн нүхэн жорлонг шинээр солих ажлыг хийж гүйцэтгэхээр төлөвлөсөн. Төлөвлөгөөний дагуу 1, 2, 3, 4, 5, 6, 7, 8, 9, 10, 11, 20, 21, 22, 23, 24, 25, 26, 28, 30, 31, 32, 33, 34, 35, 36, 39, 40, 41, 42, 43 дугаар хороодын нийт 3000 айл өрхийн нүхэн жорлонг шинээр суурилуулж, сайжруулсан ариун цэврийн байгууламжийг 7,1 хувиар нэмэгдүүлсэн. Гэр хорооллын 31 хорооны 3000 айл өрхийн 5600 иргэнд ариун цэврийн байгууламжийн зохистой хэрэглээний хандлагыг бий болгох талаар сургалт зохион байгуулж, 3000 ширхэг гарын авлага тарааж, төсөл хэрэгжүүлсэн айл өрхүүдийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор 30000 ширхэг нарс модыг тарих ажлыг зохион байгуулж ажилласан.	100%
<b>Хэсгийн дундаж хувь</b>						<b>90%</b>	
<b>ЗОРИЛГО 3. ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ 2022 ОНЫ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХҮРЭЭНД:</b>							

**Зорилт 3.1 Хүн бүр чанартай боловсролыг тэгш хүртээмжтэй, эзэмших нөхцөлийг бүрдүүлэх, насан турш сурч боловсрох боломжийг дэмжинэ.**

1	3.1.1. 4, 7, 10, 20, 24, 28, 31, 32 дугаар хороонд баригдаж байгаа сургуулийн барилгыг ашиглалтад оруулж, 30 дугаар хороонд сургуулийн барилгын ажлыг эхлүүлэх	10,495.9 Улсын төсөв 3000.0 Нийслэлийн төсөв	Ашиглалтад орох сургууль, тоо	0	8	Улсын төсвийн хөрөнгөөр баригдаж байгаа нийт 8 /4, 7, 10, 20, 24, 28, 31, 32/-н хорооны сургуулийн барилгын ажил 40-100%-ийн гүйцэтгэлтэй байна. Үүнд: -4 дүгээр хорооны 640 хүүхдийн суудалтай 162 дугаар сургуулийн барилга 9 дүгээр сард ашиглалтад орж, сургалтын үйл ажиллагаа эхэлсэн. -7 дугаар хорооны 640 хүүхдийн суудалтай сургуулийн барилгын зураг төсвийн ажил дахин шинээр хийгдэж, үйл ажиллагаа эхлээгүй байна. -8 дугаар хорооны 280 хүүхдийн суудалтай бага сургууль, цэцэрлэгийн барилгын ажил 40%-н гүйцэтгэлтэй байна. -10 дугаар хорооны 320 хүүхдийн суудалтай сургуулийн барилгын ажил 90%-н гүйцэтгэлтэй байна. -20 дугаар хорооны 480 хүүхдийн суудалтай сургуулийн барилгын ажил 70%-н гүйцэтгэлтэй байна. -24 дүгээр хорооны 160 хүүхдийн суудалтай бага сургуулийн барилга 60%-н гүйцэтгэлтэй байна. -27 дугаар хорооны 640 хүүхдийн суудалтай сургуулийн барилга 30%-н гүйцэтгэлтэй байна. -28 дугаар хорооны 640 хүүхдийн суудалтай сургуулийн барилгын ажил 70%-н гүйцэтгэлтэй байна. -31 дүгээр хорооны 320 хүүхдийн суудалтай бага сургуулийн барилгын ажил 70%-н гүйцэтгэлтэй байна. -32 дугаар хорооны 640 суудалтай 150 дугаар сургуулийн барилгын явц 90%-ийн гүйцэтгэлтэй байна. -40 дүгээр хороонд Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр 640 хүүхдийн суудалтай сургуулийн барилга 90%-ийн гүйцэтгэлтэй баригдаж, барилгын гүйцэтгэгчээр “Химон констракшн” ХХК ажиллаж байна. -30 дугаар хорооны Хилчин гудамжинд сургуулийн барилгын газар чөлөөлөлтийн ажил хийгдэж, ажлын явц 50%-тай явагдаж байна.	70%
2	3.1.2. 18 дугаар хорооны 12 дугаар сургуулийн барилгын үйл ажиллагааг үргэлжлүүлэх	6,250.0 Улсын төсөв	Барилгын ажлын явц, хувь	0	60	12 дугаар сургуулийн барилгыг дахин шинээр барих ажлын гүйцэтгэгчээр “Моринсувд” ХХК ажиллаж, барилгын А блокны суурийн ажил, Б блокны 4 давхрын өрлөгийн ажил хийгдэж, гүйцэтгэл 45%-тай явагдаж байна.	50%

3	3.1.3. 76, 62 дугаар сургуулийн өргөтгөлийн барилгыг ашиглалтад оруулах	1,988.6 Улсын төсөв	Ашиглалтад орох өргөтгөл, тоо	0	2	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 62 дугаар сургуулийн 640 хүүхдийн суудалтай өргөтгөлийн барилгын гүйцэтгэгчээр “Ган зосон” ХХК ажиллаж, 85%-ийн гүйцэтгэлтэй боловч, 2020 оноос хойш зогсонги байдалтай байна. Өргөтгөлийн барилгын асуудлаар Барилга хөгжлийн төв, гүйцэтгэгч компаний төлөөлөл болон 62 дугаар сургуулийн захиргаатай хамтарсан нэгдсэн хурлыг хийж, компаний зүгээс санхүүжилт нэмж хийгдвэл барилгын ажлыг үргэлжлүүлэх саналыг гаргасан байна. 76 дугаар сургуулийн өргөтгөлийн барилгын 3 дугаар давхрын ханын өрөлтийн ажил 50%-ийн гүйцэтгэлтэй байна. Гүйцэтгэгчээр “Голомт констракшн” ХХК ажиллаж, шинэчилсэн гэрээний дагуу ирэх оны 8 дугаар сард хүлээлгэж өгөхөөр ажиллаж байна.	50%
4	3.1.4. 7, 10, 11, 24, 25, 28, 31, 33, 34, 40 дүгээр хороодод буй цэцэрлэгийн барилгыг ашиглалтад оруулах	9,106.5 Улсын төсөв	Ашиглалтад орох цэцэрлэг, тоо	0	10	Нийт 10 хорооны цэцэрлэгийн барилгаас 3 цэцэрлэг бүрэн ашиглалтад орж, 8 цэцэрлэгийн барилгын гүйцэтгэл 30-90%-ийн гүйцэтгэлтэй байна. -Улсын төсвийн 1.2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 7 дугаар хорооны 150 хүүхдийн ортой цэцэрлэг барих 8 айлын газар чөлөөлөлт хийгдэж, барилгын гүйцэтгэгчээр "Инерци" ХХК ажиллан, барилгын суурийн ажил 10%-ийн гүйцэтгэлтэй байна. -10 дугаар хорооны 150 хүүхдийн ортой 286 дугаар цэцэрлэгийн явц 95%-тай байна. -11 дүгээр хороонд улсын төсвийн хөрөнгөөр 150 хүүхдийн ортой цэцэрлэгийн барилгын ажлын явц 80%-тай явагдаж байна. Барилгын үндсэн хийц бүтээцийн ажлууд хийгдэж дуусан, дотор заслын болон гадна тохижилтын ажлууд хийгдэж байна. -22 дугаар хорооны 150 ортой цэцэрлэгийн барилга 75%-н гүйцэтгэлтэй явагдаж байна. -24 дүгээр хорооны 150 хүүхдийн ортой 270 дугаар цэцэрлэгийн барилга ашиглалтад орж, 10 дугаар сарын 13-нд сургалтын үйл ажиллагаагаа эхлүүлсэн. -25 дугаар хороонд Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр олон улсын стандартад нийцсэн жишиг цэцэрлэг баригдаж, барилгын гүйцэтгэл 60%-тай явагдаж байна. -28 дугаар хорооны 150 хүүхдийн ортой цэцэрлэгийн барилгын ажил 85%-ийн гүйцэтгэлтэй байна. Барилгын үндсэн хийц	70%



						<p>бүтээцийн ажлууд хийгдэж дуусан, дотор засал, гадна металл фасад, тохижилтын ажил хийгдэж байна.</p> <p>-31 дүгээр хороонд улсын төсвийн хөрөнгөөр баригдаж буй 250 хүүхдийн ортой 306 дугаар цэцэрлэгийн барилгын ажил дуусаж, үйл ажиллагаа эхлүүлэхэд бэлэн болоод байна.</p> <p>-33 дугаар хороонд улсын төсвийн 1.4 тэрбум төгрөгийн хөрөнгөөр 150 хүүхдийн ортой 271 дүгээр цэцэрлэгийн барилга ашиглалтад орж, сургалтын үйл ажиллагаа эхлэсэн.</p> <p>-34 дүгээр хорооны 200 ортой цэцэрлэгийн барилга 85%-н гүйцэтгэлтэйгээр барилгын ажил явагдаж байна. Барилгын үндсэн хийц бүтээцийн ажлууд хийгдэж дууссан бөгөөд дулааны шугам, гадна тохижилт, дотор заслын ажлууд хийгдэж байна.</p> <p>-40 дүгээр хорооны 240 хүүхдийн ортой цэцэрлэгийн барилгын гүйцэтгэгчээр “Цаст констракшн” ХХК ажиллаж, барилгын зоорийн давхрын цутгалт хийгдэж, 30%-ийн гүйцэтгэлтэй явагдаж байна.</p>	
5	3.1.5. 26, 110, 119 дүгээр цэцэрлэгийн өргөтгөлийн барилгыг ашиглалтад оруулах	2,023.9 Улсын төсөв	Ашиглалтад орох өргөтгөл, тоо	0	3	Улсын төсвийн хөрөнгөөр 19 дүгээр хорооны 26 дугаар цэцэрлэгийн 150 хүүхдийн ортой өргөтгөлийн барилгын ажлын гүйцэтгэл 90%-тай, 15 дугаар хорооны 150 хүүхдийн 110 дугаар цэцэрлэгийн өргөтгөлийн барилгын ажил 70%-тай явагдаж байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 16 дугаар хорооны 119 дүгээр цэцэрлэгийн өргөтгөлийн барилга ашиглалтад орж, үйл ажиллагаагаа эхлүүлэхэд бэлэн болоод байна.	70%
6	3.1.6. 21, 33 дугаар хороодод бага сургууль цэцэрлэгийн цогцолборын барилгын ажлыг эхлүүлэх	2,400.0 Улсын төсөв	Барилгын ажлын явц, хувь	0	30	21 дүгээр хороонд улсын төсвийн 4.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 280 хүүхдийн бага сургууль, цэцэрлэгийн цогцолборын барилгын гүйцэтгэгчээр “Алтайн буйлааст” ХХК ажиллаж, гүйцэтгэл 30%-тай байна. 33 дугаар хорооны Тахилтын эцэст улсын төсвийн 4.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 280 хүүхдийн бага сургууль, цэцэрлэгийн цогцолборын барилгын суурийн ажил хийгдэж байна.	30%
7	3.1.7. 23, 29, 33, 40, 42, 43 дугаар хороодод цэцэрлэгийн барилгын ажлыг эхлүүлж, 37 дугаар хороонд цэцэрлэгийн	9,882.8 Улсын төсөв 2870.0 Нийслэлийн төсөв	Барилгын ажлын явц, хувь	0	30	Дүүргийн 37 дугаар хороонд 4.6 тэрбум төгрөгийн санхүүжилттэй 240 хүүхдийн ортой цэцэрлэгийн барилга худалдан авах ажил хийгдэж, сургалтын үйл ажиллагаа эхлүүлэхэд бэлэн болсон. 23 дугаар хорооны 150 хүүхдийн цэцэрлэгийн 6 айлын газар чөлөөлөлтийн ажил дууссан, барилгын ажил эхлээгүй. 29 дүгээр хорооны 150 хүүхдийн ортой цэцэрлэгийн газар чөлөөлөлтийн ажил хийгдэж байна.	30%

	барилга худалдан авах					33 дугаар хорооны 240 хүүхдийн ортой цэцэрлэгийн барилгын зураг төсвийн ажил хийгдэж байна. 40 дүгээр хороонд 150 хүүхдийн ортой цэцэрлэгийн барилгын газар чөлөөлөлтийн ажил хийгдэж байна. 42 дугаар хорооны 240 хүүхдийн ортой цэцэрлэгийн барилгын суурийн ажил хийгдэж, 30%-ийн гүйцэтгэлтэй байна. 43 дугаар хороонд 2.8 тэрбум төгрөгийн санхүүжилттэй 150 ортой цэцэрлэгийн барилгын газар чөлөөлөлтийн ажил хийгдэж, барилгын ажил эхлээгүй.	
8	3.1.8. Багш нарын дунд ур чадварын уралдаан, эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах	10.0 Дүүргийн төсөв	Зохион байгуулах уралдаан, тоо	0	2	Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын багш нарын тасралтгүй хөгжих, бие даан суралцах нөхцөлийг бүрдүүлэх, туршлага солилцох, түгээн дэлгэрүүлэх зорилгоор “Бүтээлч багш-Шилдэг бүтээл” арга хэмжээг 3 үе шаттайгаар зохион байгуулан нэгдсэн арга хэмжээг “Баянхошуу Бизнес инкубатор хөгжлийн төв”-д явуулж, сургуулийн өмнөх боловсролын 60 байгууллагын нийт 400 орчим багш, арга зүйч, эрхлэгч нарыг хамрууллаа. Нэгдсэн арга хэмжээнд цэцэрлэг бүрээс шалгарсан багш нарын бүтээлийн үзэсгэлэнг гаргаж, бүтээлч багшаар шалгарсан шилдэг 60 багш, бүсийн хэмжээнд тэргүүлсэн 6 цэцэрлэг Засаг даргын өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнагдсан. Дүүрэг үүсэн байгуулагдсаны 30 жилийн ойг угтаж, дүүргийн үүсэл хөгжил, түүхэн замнал, өнөөгийн байдлын талаар ерөнхий боловсролын сургуулийн багшийн судалгаа шинжилгээний ажил хийх, тухайн сэдвийн хүрээн дэх асуудал, шийдлийн талаар өөрийн санал бодлыг илэрхийлэх, бусдаас суралцах, туршлага хуваалцах, хамтран ажиллах, илтгэх чадвар, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх зорилгоор түүх, нийгмийн ухааны багш нарын дунд эрдэм шинжилгээний бага хурлыг сарын хугацаанд зохион байгуулан, шалгаруулалтын үйл ажиллагааг 67 дугаар сургууль дээр зохион байгууллаа. Эцсийн шатны шалгаруулалтад 8 багшийн илтгэл оролцсоноос эхний 3 байрт Өнөр цогцолбор, 62, 104 дүгээр сургуулийн түүх, нийгмийн багш нар шалгарсан. Ерөнхий боловсролын сургуулийн багш нарын дунд “Багш нарын мэргэжлийн өсөлтөд ахмад багш нарын оролцоог нэмэгдүүлэх нь” сэдвээр эрдэм шинжилгээний хурлыг 3-р сард цахим хэлбэрээр 2 үе шаттайгаар зохион байгуулан, төрийн өмчийн 26 сургуулийн 35 багш оролцон эхний 3 байрт 67,	100%

						Ирээдүй цогцолбор, 153-р сургуулийн багш нарын баг орсон байна.	
9	3.1.9. Төгсөх ангийн сурагчдын дунд "BOOM" төслийг хэрэгжүүлэх	50.0 Дүүргийн төсөв	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	Цахим хуудсыг 12-р ангийн суралцагч, багш нар, сургуулийн удирдлагуудын дунд ажиллуулан, 2,9 мянга гаруй дагагчидтай болсон.	100	Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдыг элсэлтийн ерөнхий шалгалтад бэлтгэх, багш нарын мэдлэг ур чадварыг нэмэгдүүлэх, боловсролын үйлчилгээний чанарыг сайжруулах зорилгоор "BOOM" төслийг 2021-2022 оны хичээлийн жилд 2040 суралцагч, багш, сургуулийн удирдлагуудын дунд зохион байгуулсан. Төсөл хэрэгжүүлэх үйл ажиллагааны арга зүйн сургалт зохион байгуулан, төлөвлөгөөг ерөнхий боловсролын сургуулиудад хүргүүлэн, сургууль тус бүр хэрэгжилтийг ханган ажилласан. Төслийн хүрээнд Боловсролын үнэлгээний төв, "Цахим сорилго" ХХК-тай хамтран "Цахим сорилго-2022" шалгалтыг зохион байгуулж, анализ хийн үр дүнг тооцож ажилласан. Элсэлтийн ерөнхий шалгалт өгөх сурагчдын судалгааг судлагдахуун тус бүрээр гаргаж, элсэлтийн ерөнхий шалгалтын цахим санд тулгалт хийн баталгаажуулж, сар тутамд сургуулиудаас ажлын тайланг авч, үр дүнг тооцон үүрэг чиглэл өгч ажилласан. Багш нарын ур чадварыг дээшлүүлэх, заах арга барилыг сайжруулах зорилгоор сар тутам заах аргын нэгдлийн багш нарын дунд туршлага судлах уулзалтуудыг бүсчлэн зохион байгуулан, элсэлтийн ерөнхий шалгалтын дундаж оноог 493 буюу өнгөрсөн оны дундажтай харьцуулахад 0,1 пунктээр нэмэгдүүлсэн байна. "BOOM" төслийн 2021-2022 оны хичээлийн жилийн үйл ажиллагааг дүгнэн, элсэлтийн ерөнхий шалгалтад 800 оноо авсан 5 суралцагч, суралцагчдаа амжилттай бэлтгэсэн 5 багш, амжилт үзүүлсэн Ирээдүй цогцолбор, 106, Хөгжил цогцолбор, 65, 151, Номуун сургуулиудыг Засаг даргын өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаж урамшууллаа.	100%
10	3.1.10. Суралцагчдын гадаад хэлний мэдлэгийг нэмэгдүүлэх, багш нарын ур чадварыг нэмэгдүүлэх зорилгоор "IELTS-600" төслийг хэрэгжүүлэх	20.0 Дүүргийн төсөв	Сурагчдын сурлагын хоцрогдлыг нөхөх	Олон улсын тэтгэлэгт хөтөлбөрт хамруулах зорилгоор "IELTS-600" төслийг хэрэгжүүлсэн	100	Ерөнхий боловсролын сургуулийн гадаад хэлний багш нарын ур чадварыг нэмэгдүүлэх, 11 дүгээр ангийн суралцагчдыг гадаадын их, дээд сургуулийн тэтгэлэгт хөтөлбөрт хамруулах зорилгоор "IELTS-600" төслийг 2 дахь жилдээ "Сантис" гадаад хэлний сургалтын төвтэй хамтран хэрэгжүүлж байна. 2022 онд дүүргийн Засаг даргатай байгуулсан Санамж бичгийн хүрээнд тус төслийг өргөжүүлэн гадаад хэлний 26 багш, ерөнхий боловсролын 23 суралцагчид хамруулан сургасан. Англи хэлний багш нарыг Inlingua олон улсын хэлний цахим сургалтад 6, 8 дугаар саруудад 2 сарын хугацаанд хамруулсан.	100%

						Суралцагчдад зориулсан дунд болон ахисан түвшингийн сургалтыг танхим, цахим хэлбэрээр хослуулан 2 сарын турш зохион байгуулан, суралцагч тус бүр нийт 80 цагийн сургалтад хамрагдсан. Сургалтад хамрагдсан багш, суралцагчдад сертификат гардуулах хаалтын арга хэмжээг ерөнхий боловсролын 122 дугаар сургууль дээр зохион байгуулсан.	
11	3.1.11. Олон улсын хөтөлбөртэй сургалтын асуудлаар холбогдох байгууллагуудад уламжлах	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	30	100	Улсын төсвийн 19.9 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар ээлжит хичээлийн цахим контент боловсруулах ажлын хүрээнд ерөнхий боловсролын 151 дүгээр сургуульд техник, тоног төхөөрөмжийн хангалт хийгдсэн. Үүнтэй холбогдуулан 3-р ангийн математик, хүн ба орчин хичээл, 8-р ангийн түүх, 11-р ангийн эрүүл мэнд, 12-р ангийн дизайн технологи, зураг зүйн хичээлүүдийн 134 цагийн цахим хичээл боловсруулан, "medlee.mn" сайтад байршуулах ажил хийгдэж байна. Кембриджийн хөтөлбөртэй сургалтын англи хэлний гүнзгийрүүлсэн сургалтад 2 багш хамрагдсан. Кембриджийн олон улсын хөтөлбөрийн эрхийг авах үйл ажиллагааны бэлтгэл хангах ажлын хүрээнд УИХ-ын гишүүн Н.Учрал сургуулийн үйл ажиллагаатай танилцан, сургуулийн багш нарт Их Засаг их сургуультай хамтран гадаад хэлний сургалтыг зохион байгуулах ажлыг эхлүүлээд байна.	30%
12	3.1.12. Сургуулийн цайны газар, цэцэрлэгийн гал тогооны тоног төхөөрөмжийг стандартын шаардлагад нийцсэн иж бүрэн тоног төхөөрөмжтэй болгох ажлыг үе шаттайгаар зохион байгуулах	4,000.0 Улсын төсөв	Сургууль, цэцэрлэгийн тоо	ЕБ-ын 151 дүгээр сургуульд стандартын шаардлага хангасан хоол үйлдвэрлэлийн загвар гал тогоо байгуулах төсөл хэрэгжүүлж байна.	15, /29/	Сургуулийн цайны газрын тоног төхөөрөмжийг шинэчлэх ажлын хүрээнд улсын төсвийн нийт 4,1 тэрбум төгрөгийн санхүүжилтээр 17 /12, 62, 67, 74, 76, Хөгжил, Ирээдүй, Өнөр цогцолбор, 105, 121, 122, 124, 129, 134, 151, 153, 154/-н сургуулийн цайны газар тус бүрт гал тогооны тоног төхөөрөмжийн нийлүүлэлт хийгдсэн. Цэцэрлэгийн гал тогооны тоног төхөөрөмжийн шинэчлэлийн хүрээнд 18 /38, 78, 99, 101, 105, 107, 111, 112, 113, 118, 119, 125, 163, 244, 252, 271, 286, 306/-н цэцэрлэгт нийт 181,1 тэрбум төгрөгийн тоног төхөөрөмжийн нийлүүлэлт хийгдсэн.	100%
13	3.1.13. "Сурагч тээвэр" үйлчилгээг нэмэгдүүлэх чиглэлээр холбогдох арга	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	ЕБ-ын 29 сургуулиас 104, 123, 134 дүгээр сургуулиуд	100	"Сурагч тээвэр" үйлчилгээнд Нийслэлийн Нийтийн тээврийн газраас 3, 24, 26, 36, 41 дүгээр хорооны алслагдсан суурьшлын цэгүүдээс сурагчдыг 42, 65, 104, 123, 134, 124, 152 дугаар сургуульд хүргэх сургуулийн автобусны С:38, С:39 чиглэлийг шинээр нэмэгдүүлсэн. Тус чиглэл С:38 буюу Бумбатын	90%

	хэмжээг авч хэрэгжүүлэх			“Автобус” төсөлд хамрагдсан		рашааны эцэс 124 дүгээр сургуулиас 152 дугаар сургууль хүртэл, С:39 чиглэл буюу Улаанчулуутын эцэс-Алтан овоо 48 дугаар гудамж, 65 дугаар сургуулиас 152 дугаар сургуулийн хооронд 2 ээлжинд сурагчдыг тээвэрлэж байна. Нийслэлийн Нийтийн тээврийн үйлчилгээний газраас ирсэн хуваарийн дагуу төрийн өмчийн 67, 74, 121, 122, 124-р сургуулиудын хүүхдийн автобус үзлэг оношилгоондоо тогтмол хамрагдаж байна. Сургуулийн автобус төслийн хүрээнд 106-р сургууль хүүхдийн автобустай болсон.	
14	3.1.14. "Багш хотхон"-ы барилгын асуудлыг холбогдох байгууллагуудад уламжлах	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	0	100	Зорилтот бүлгийн өрхийн иргэдэд зориулсан байр барих төслийн хүрээнд /багш нарыг хамруулах/ 6 дугаар хорооны Ханын материалын эцэст 712 айлын орон сууц барих ТЭЗҮ боловсруулагдан, зээлийн хэлэлцээр хийх шатандаа үйл ажиллагаа явагдаж байна.	30%
15	3.1.15. Багш нарыг хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүйн сургалтад хамруулах	2.0 Дүүргийн төсөв	Зохион байгуулах сургалт, тоо	0	1	2022-2023 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын 27 сургуульд 217, сургуулийн өмнөх боловсролын 60 байгууллагад 136 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд суралцаж байна. “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын дүүргийн салбар комисс”-той хамтран 2022-2023 оны хичээлийн жилд шинээр сургуульд элсэн суралцах 132 хүүхдийн мэдээлэл цуглуулан ажиллаж байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролын байгууллагад холбон зуучлах үүрэг бүхий “Боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөл”-ийг дүүргийн Засаг даргын 2022 оны А/85 дугаар захирамжаар байгуулан, ажлын хэсгийн хурлаар төрийн өмчийн 24 сургуульд шинээр элсэн орох хүүхдүүдийн мэдээллийг сургуулиудад хүлээлгэн өгч, “Сургуулийн дэмжлэгийн баг”-ийг хуралдуулах зөвлөмж чиглэл өгч ажилласан. “Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний үлгэрчилсэн загвар”-ын дагуу ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн 97, дунд, ахлах ангийн 45 багш хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна. БШУ-ны сайдын 2020 оны А/296 дүгээр тогтоолоор батлагдсан “Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж байгаа багш, туслах багшид нэмэгдэл хөлс олгох заавар”-ын дагуу бага ангийн 62, дунд	100%

						ахлах ангийн 19 багш нэмэгдэл хөлс авч байна. Азийн хөгжлийн банкны “Тэгш хамруулах боловсролыг дэмжих” төслийн сургалтад 105-р сургууль, 253-р цэцэрлэгийн дэмжлэгийн багийн 15 гишүүн, “Жайка старт-2” төслийн хүрээнд 143, 104, Өнөр цогцолбор сургуулийн дэмжлэгийн багийн гишүүд болон сургуулийн удирдлага, багш нийт 51 хүнийг “Боловсролд тэгш хамруулах тухай” сэдэвт онлайн сургалтад тус тус хамруулсан. Японы хүүхдийг ивээх сангийн “Хүүхэд нэг бүрийг боловсролд тэгш хамруулах зарчмыг дэмжих нь- II” төслийн хүрээнд ерөнхий боловсролын 9 дүгээр сургууль дээр Хүүхэд хөгжлийн танхимыг шинээр тохижуулан, нийслэлийн “Тэгш хамруулан сургагч байгууллага”-аар шалгарсан.	
16	3.1.16. Тусгай хэрэгцээт хүүхдийн цэцэрлэгийн барилгын ажлыг эхлүүлэх	3,500.0 Улсын төсөв	Барилгын ажлын явц, хувь	0	70	28-р хорооны тусгай хэрэгцээт хүүхдийн цэцэрлэгийн барилгын карказ угсрах ажил бүрэн хийгдэж, өрлөгийн ажил эхлэх бэлтгэл хийгдэж байна. Гүйцэтгэл 35%-тай байна.	50%
17	3.1.17. “Бадминтон”-ы спортыг хөгжүүлэх богино хугацааны төсөл боловсруулан хэрэгжүүлэх	-	Хэрэгжүүлэх төсөл, тоо	0	100	“Бадминтон”-ы спортыг хөгжүүлэх богино хугацааны төслийг боловсруулж, хэрэгжилтийг ханган ажиллалаа. Төслийн хүрээнд ерөнхий боловсролын 26 сургуулийн биеийн тамирын багш нарыг бадминтоны сургагч багш бэлтгэх сургалтад хамруулан, гэрчилгээжүүлсэн ба бэлтгэгдсэн багш нар 520 хүүхдийг тус спортоор хичээллүүлж байна. 2022 оны 11 дүгээр сард “Бадминтон”-ны нээлттэй сургалтыг Биеийн тамир, спорт хорооны зааланд зохион байгуулж 16 хорооны 16 иргэн, ерөнхий боловсролын 21 сургуулийн 21 багшийг хамруулж, сургуулиудад “Бадминтон”-ын иж бүрэн тоног төхөөрөмж гардуулан өглөө.	100%
18	3.1.18. Сургууль завсардалтын нарийвчилсан судалгааг гарган, холбогдох байгууллагуудтай хамтран боловсрол нөхөн олгох сургалтыг зохион байгуулах	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	“Сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах төлөвлөгөөг хэрэгжүүлэх сургалт, үйл ажиллагааны удирдамж”-ийг	100	2021-2022 оны хичээлийн жилд сургууль завсардсан 213 иргэнд боловсрол нөхөн олгох танхимын сургалтыг 8 танхим, 13 бүлгээр зохион байгуулж, бүрэн дунд боловсрол эзэмших хүсэлтэй 50 иргэн боловсрол нөхөн олгох журамд заасны дагуу танхимын болон түр цугларалт хосолсон хэлбэрээр суралцсан. Үүнээс бага боловсрол 26, суурь боловсрол 20, бүрэн дунд боловсрол 33 суралцагчид бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшин төгссөн. 2021-2022 оны хичээлийн жилд тус төвд хөгжлийн бэрхшээлтэй 22 иргэн суралцсанаас 8 суралцагч ганцаарчилсан сургалтын хөтөлбөрөөр, 4 сурагч зайнаас	100%

				баримтлан сургалтыг зохион байгуулсан.		суралцаж зохих түвшний боловсролыг эзэмшиж анги дэвшив. Сургууль завсардсан иргэдийн судалгаа, боловсролын хэрэгцээний судалгааг хороодоос авч нэгтгэн, судалгааны дүнд сургууль завсардсан сургуулийн насны 67, насанд хүрэгч 25 иргэнийг илрүүлэн, боловсрол нөхөн олгох хөтөлбөрийн унших, бичих, ярих чадвар сул 8 хүүхдийг бичиг үсэг тайлах анхан шатны танхимын сургалтад хамруулан, үргэлжлүүлэн суралцах боломжийг бүрдүүлсэн. Бичиг үсгийн боловсрол олгох сургалтын хүрээнд эрүүл мэндийн болон амьдралын гачигдлаас шалтгаалан бичиг үсгийн боловсрол эзэмшээгүй хөдөлмөр эрхэлдэг насанд хүрсэн 6 иргэнийг бичиг үсгийн боловсрол олгох танхимын болон бие даан суралцах хосолсон хэлбэрээр суралцуулж төгсгөсөн. 2022-2023 оны хичээлийн жилд сургууль завсардсан сургуулийн насны хүүхэд болон насанд хүрэгч 176 иргэнд боловсрол нөхөн олгох сургалтыг 65, 76, 42-р сургууль, "Харилцааны хөгжил" ТББ болон Төвийн байранд байрлах нийт 6 танхимд 9 бүлгээр зохион байгуулан ажиллаж байна. Энэ хичээлийн жилд 26 хүүхэд боловсрол нөхөн олгох сургалтад хамрагдан суралцаж байгаагаас 4 нь гадаад улсаас эх орондоо эргэн ирсэн хүүхэд байна.	
<b>Зорилт 3.2 Иргэдийн соёл, урлагийн талаарх мэдлэг, хандлагыг нэмэгдүүлэн төлөвшүүлэх ажлыг хүртээмжтэй хэлбэрээр зохион байгуулж, хотын соёлыг түгээн дэлгэрүүлэх, түүх, соёлын дурсгалыг хадгалж хамгаалах, биет болон биет бус өв тээгчдийг нээн илрүүлэх, хөгжүүлэх, сурталчлах ажлыг эрчимжүүлнэ.</b>							
19	3.2.1. "Иргэдийн соёлын боловсролыг дээшлүүлэх" дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллах	50.0 Дүүргийн төсөв	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	Төслийн зохион байгуулалтын ажилд дүүргийн төсвөөс 423.0 сая төгрөгийг зарцуулж, 90.0 хувьтай хэрэгжсэн.	100	"Иргэдийн соёлын боловсролыг дээшлүүлэх" төслийн 2022 оны төлөвлөгөөг 4 зорилтын хүрээнд 12 арга хэмжээг хэрэгжүүлэхээр батлуулан, хэрэгжилтийг ханган ажиллалаа. Төслийн хүрээнд: "Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр" "Бүсгүйчүүд" VIP тоглолт, "Эндүүрмээр гэнээ би ээжтэйгээ" гэрэл зургийн "Challenge", "Одонтой ээжүүд", "Эх орон", "Дээлтэй Монгол-2022", "Нүүдэлчин Монгол-2022" арга хэмжээг тус тус зохион байгуулж, давхардсан тоогоор 21 байгууллагын 4439 ажилтан, албан хаагч, иргэдийг хамруулсан ба "Дээлтэй Монгол-2022" арга хэмжээний "Шилдэг дүүрэг"-ээр шалгарсан. Хүүхдүүдийн авъяас чадварыг нээн хөгжүүлэх зорилгоор Соёлын ордон, ерөнхий боловсролын сургуулиудад 10 гаруй (дуу, бүжиг, даралтад хөгжим, морин хуур, хөөмэй, гитар, төгөлдөр хуур, даам, шатар) төрлийн дугуйланг хичээллүүлж, 685 сурагч хамрагдаад байна. "Үндэсний бичиг, соёл, номын өдрүүд-2022" нэгдсэн арга хэмжээнд "Илүү их уншъя"	90%

					<p>уриатайгаар дүүргийн 3 бичил номын сангууд номын үзэсгэлэн, танилцуулгыг хийж оролцсон.</p> <p>ЕБС, цэцэрлэгийн хүүхдүүдэд урлагаар дамжуулан соёлыг түгээх, уламжлалт өв соёлыг таниулах ажлын хүрээнд музей болон түүхэн газруудаар аялуулах ажлыг зохион байгуулж 48 цэцэрлэг, 9 сургуулийн нийт 12,768 хүүхдийг хамруулсан. Мөн соёлын биет бус өв тээгч Г.Баяртай, Б.Балган, Д.Сэмбэдорж нараар 1 цэцэрлэг 2 сургуулийн нийт 236 хүүхдэд дөрвөд, хотон, баяд бий биелгээний өвийг уламжлуулах ажлыг зохион байгуулж байна. Жил бүр уламжлал болон зохион байгуулагддаг Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, Төрийн шагналт Ардын жүжигчин Д.Лувсаншарав агсны нэрэмжит “Хүүхдийн найрал дууны шилдэг хамтлаг” шалгаруулах уралдааны нэгдүгээр шатны шалгаруулалтыг зохион байгуулж 20 сургуулийн 1165 сурагч оролцлоо. Уралдааны эхний 3 байранд шалгарсан 65, 62, 67 дугаар сургуулиуд нийслэлийн шалгаруулалтад оролцож 62 дугаар сургууль 9 дүүргийн 20 сургуулийн найрал дууны хамтлагыг тэргүүлж “Шилдэг хамтлаг”-аар, соёлын асуудал хариуцсан мэргэжилтэн “Шилдэг зохион байгуулагч”-аар шалгарсан амжилтийг үзүүллээ.</p> <p>Монголын бүжгийн спортын холбоотой хамтран ЕБС, СӨББ-ийн багш нарын дунд бүжгийн сургалтыг зохион байгуулж 57 байгууллагын 96 багш албан хаагчдыг хамрууллаа.</p>		
20	3.2.2. "Хотын соёл"-ыг түгээн дэлгэрүүлэх уриалга, нөлөөллийн ажил зохион байгуулах	1.5 Дүүргийн төсөв	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	16 төрлийн уралдааныг цахим хэлбэрээр зохион байгуулж 580 иргэдийг хамруулан шилдэг 66 иргэд, хүүхэд, залуучуудыг шалгаруулж, 5.0 сая төгрөгийн хөрөнгө зарцуулсан.	100	<p>“Хотын соёл”-ыг түгээн дэлгэрүүлэх ажлын хүрээнд “Соёлтой болГоё” 3 төрлийн зурган фостер, нөлөөллийн 3D контент, “Хот”, “Бидний тухай бид” бичил цуврал нэвтрүүлэг, хотын соёлыг төлөвшүүлэх нөлөөллийн зурагт постуудыг дүүргийн хэвлэл мэдээллийн алба, 43 хороо, Соёлын ордны албан ёсны фэйсбүүк хуудсуудаар дамжуулан сурталчилж нийт давхардсан тоогоор 23,000 иргэн, олон нийтэд хүргээд байна. Нийслэл хотоос соёлын талаар баримталж буй бодлогыг иргэд олон нийтэд түгээн сурталчилж, иргэдийн нийтийн соёлыг дээшлүүлэх, соён гэгээрүүлэх “Хотын соёл-Хариуцлагатай иргэн” аяныг 2022 оны 8 дугаар сарын 29-ний өдрөөс 9 дүгээр сарын 05-ны өдрүүдэд зохион байгууллаа. Аяны хүрээнд хотын соёлын талаар нээлттэй хэлэлцүүлэг, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай сургалт, хөгжөөнт, цэнгээнт тоглоом, урлагийн тоглолт зэрэг арга хэмжээг алслагдсан 9 хорооны иргэний танхим болон сургуулийн урлаг зааланд явуулж, нийт 680</p>	100%



						гаруй иргэдийг хамруулсан. Үйлчилгээний стандартыг сайжруулах, үйлчилгээний соёлыг нэвтрүүлэх, түргэн шуурхай, соёлтой үйлчилгээг хэвшүүлэх зорилгоор дүүргийн Засаг даргын 2022 оны А/603 дугаар захирамжаар “Соёлтой Сонгинохайрханчууд” уралдаант аяныг 1 сарын хугацаатай зарлан дүгнэлээ. Аяны шалгуур үзүүлэлтийг салбарын онцлогуудтай уялдуулан боловсруулж, 98 байгууллагаас аяны тайланг хүлээн авч, идэвх санаачлагатай оролцсон 6 байгууллагыг шалгаруулан, урамшуулсан.Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын хүний нөөцийн хөгжлийн төв, “Баялаг бүтээгч Монгол хүн” ТББ-тай хамтран “Хотын соёл-Харилцааны соёл” цахим сургалтыг 11 дүгээр сарын 01, 02-ны өдрүүдэд цахим хэлбэрээр зохион байгуулж ерөнхий боловсролын сургуулийн 22, сургуулийн өмнөх боловсролын байгууллагын 58, хороодын 407, нийт 487 албан хаагчдыг оролцууллаа.	
21	3.2.3. Хүүхэд, залуучуудын театрын ордны барилгыг гадна тохижилтын хамт ашиглалтад оруулах	3,562.0 Улсын төсөв	Ашиглалтад орох барилга, тоо	0	1	Хүүхэд, залуучуудын театрын ордны барилгын ажлын ерөнхий гүйцэтгэгчээр “Аглуут” ХХК, гадна тохижилтын ажлыг “Содон Номин” ХХК тус тус гүйцэтгэсэн. Барилгын интерьер өөрчлөгдсөнөөс шалтгаалан барилгын ажил 85%, гадна тохижилтын ажил 90%-тай түр зогссон. Үерийн ус зайлуулах шугам сүлжээний гүйцэтгэлийн ажилд орон нутгийн төсвөөс 800 сая төгрөг төсөвлөсөн. Соёлын яаманд зураг төсвийн ажил үргэлжлэн хийгдэж байна.	70%
22	3.2.4. Хүүхэд, залуучуудын театрын тоног төхөөрөмж худалдан авах	3,000.0 Улсын төсөв	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	0	70.0	Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/46 дугаар захирамжаар “Хүүхэд залуучуудын театр”-ын 5 тэрбум төгрөгийн тоног төхөөрөмжийг худалдан авах эрх нээгдэж, худалдан авах ажиллагааны тендерийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдөр зарлан 11 дүгээр сарын 01-нд нээсэн. Уг тендер нь үндсэн 9 багцтай зарлагдсан бөгөөд 1 дүгээр багц “Техник хэрэгсэл” (1,694,943,800 төгрөг), 5 дугаар багц “Хөгжмийн багц” (375,509,200 төгрөг) шалгараад байна. Үлдсэн 7 багцыг дахин зарласан ба 12 дугаар сарын 12-ны өдөр нээхээр ажиллаж байна.	30%
23	3.2.5. Түүх, соёлын үл хөдлөх хөшөө дурсгалын хадгалалт, хамгаалалтын	42.0 Дүүргийн төсөв	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	12 хөшөө, 8 булш, хиргисүүрүүдэд хяналт тавьж,	100	Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12/35 дугаар тогтоолоор “Дүүргийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалт”-ыг баталсан. Нийслэлийн нутаг дэвсгэр дэх түүх соёлын үл хөдлөх дурсгалын тооллогыг явуулах тухай Нийслэлийн Засаг даргын А/1138 дугаар	100%

	аюулгүй байдлыг хангах ажлыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулах			гэрээгээр эзэмшигчдэд зөвлөн тусалж, үүрэг чиглэл өгсөн.		захирамжийн дагуу дүүргийн нутаг дэвсгэр дэх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалтад батлагдсан 27 газрын тооллогыг 9 дүгээр сарын 07, 08-ны өдрүүдэд Соёлын яам, Соёлын өвийн үндэсний төв, нийслэлийн засаг даргын Тамгын газар, Соёл урлагийн газар, Шинжлэх ухааны академийн Архелогийн хүрээлэн, Мэргэжлийн хяналтын газар зэрэг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулсан. Тооллогоор: <ul style="list-style-type: none"> <li>• Архелогийн дурсгалт газруудыг кадастержуулж, хамгааллалтын бүс тогтоох;</li> <li>• Шинэ суурьшлын бүсэд байрлалтай архелогийн дурсгалуудын өмчлөгч эзэмшигчийг цуцлах;</li> <li>• Дурсгалыг авран хамгаалах шаардлагатай гэсэн дүгнэлтүүдийг гаргасан.</li> </ul> Газар зохион байгуулалтын 1 дүгээр албатай хамтран архелогийн дурсгалт газруудыг кадастржуулах ажил хийгдэж байна.	
24	3.2.6. Биет бус өв тээгчдийн бүртгэл мэдээллийн санг баяжуулан, тэднийг алдаршуулахад зориулсан уламжлалт наадам, өдөрлөг зохион байгуулах	38.0 Дүүргийн төсөв	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	Монгол хөөмийн 3, “Тууль хайлах” 4, уламжлалт тоглоом наадгай талаар 5, нийт 12 удаагийн мэдээллийг цахим хаягаар дамжуулан иргэдэд хүргэсэн.	100	Соёлын биет бус өв тээгч 324 иргэний бүртгэл, судалгааг шинэчлэн нэгтгэж, мэдээллийн санг баяжуулан 7 ай савд ангилан “ich.mongoluv.mn” программд шивсэн. Өв тээгчдийн бүтээлийг олон нийтэд сурталчлан, таниулах, алдаршуулах зорилгоор доорх ажлуудыг хийж хэрэгжүүллээ. “Уран гар” уралдааныг зохион байгууллаа. Уралдаанд “Төмөр, чулуу, ясан эдлэл”, “Хатгамал, наамал, уран зураг”, “Эсгий урлал”, “Модон эдлэл”, “Арьсан урлал” төрлөөр 34 иргэн оролцсоноос 8 өв тээгч шагналт байранд шалгарсан. Соёлын биет бус өвийг сурталчлан таниулах түгээн дэлгэрүүлэх, өвийг хадгалж хамгаалах, өв тээгч өвлөн уламжлагчдыг алдаршуулах, тэдний авьяас билгийг хүүхэд залуучуудад өвлүүлэн уламжлуулах зорилгоор өв тээгчдийн уулзалт, өдөрлөгийг 7 дугаар сарын 06-ны өдөр зохион байгуулан, 240 гаруй өв тээгчдийг хамруулсан. Өдөрлөгийн арга хэмжээний хүрээнд ай савын төрлүүдээр урлагийн тоглолт, биет бус өв тээгчдийн бүтээлийн үзэсгэлэн худалдаа, “Соёлын өвөө түгээн дэлгэрүүлэе” илтгэл, Соёлын ордны уран бүтээлчдийн тоглолт, ай савын төрөлд бүртгэлтэй өвлөн уламжлагчдад шагнал, талархал гардуулах ёслолыг тус тус зохион байгууллаа. Дүүргийн баримтат өв эзэмшигч иргэдийн 2022 оны судалгааг шинэчлэн гаргаж нийслэлийн Соёл урлагийн газарт хүргүүлсэн. Соёлын биет бус өвийн бүсчилсэн судалгааны ажлын хүрээнд 4 ай савын 20	100%

						өвлөн уламжлагчаас биечлэн судалгаа авч, 4 өвлөн уламжлагчийн өвийг гэр болон ажлын байранд нь очиж баримтжуулан бүртгэсэн ба 175 өвлөн уламжлагчийн судалгааг цахимаар авч дуусган, холбогдох байгууллагад хүлээлгэн өгсөн.	
<b>Зорилт 3.3. Хүүхэд, гэр бүлийн хүчирхийллийг бууруулах талаар холбогдох шийдвэрүүдийг гарган, хүчирхийлэлд өртөгчдийг хамгаалах байртай болж, гэр бүлийн гишүүдийн хариуцлагыг нэмэгдүүлэн, үлгэр жишээ гэр бүлийг дэмжин, сурталчлах, хүүхдийн эрхийг дээдэлж, залуучуудыг хөгжих, суралцах, хөдөлмөрлөх орчин нөхцөлөөр хангана.</b>							
25	3.3.1. Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжил, хамгааллын чиглэлээр ажиллаж буй албан хаагчдын ур чадварыг нэмэгдүүлэх, мэргэшүүлэх ажлыг зохион байгуулах	7.5 Дүүргийн төсөв	Хамрагдах албан хаагч, давхардсан тоо	410	500	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжил, хамгааллын чиглэлээр ажиллаж буй албан хаагчдын мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх зорилгоор 12 удаагийн чадавхжуулах сургалтыг танхим, цахим хэлбэрээр болон ажлын байран дээр нь зөвлөн туслах чиглэлээр зохион байгуулж давхардсан тоогоор 700 гаруй албан хаагчдыг хамруулсан. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, нийслэлийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар болон төрийн бус байгууллагуудтай хамтарч “Кейс менежментийн нийтлэг арга зүй”, “Нийгмийн ажилтны систем /has.fcy.gov.mn/-ийн ашиглалт, хэрэгжилтэд зөвлөн туслах арга зүй”, “Гэр бүл дэх хариуцлага харилцаа, ёс зүйн”, “Хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга”, “Үйлчилгээг баримтжуулах арга зүй”, “Нөхцөл байдлын үнэлгээ хийх болон эко зураглал, генограммын арга техникийг ашиглах арга зүй” сэдвийн хүрээнд чадавхжуулах сургалтуудыг зохион байгуулж, дүүргийн 43 хорооны “Хамтарсан баг”-ийн 310 гишүүн, ГБХЗХХ-ийн хэлтсийн 21 албан хаагчдыг хамрууллаа. Мөн “Японы хүүхдийг ивээх сан”-тай хамтран 2, 10, 11 дүгээр хорооны “Хамтарсан баг”-ийн 21 гишүүдэд “Хамтарсан багаар ажиллах арга зүй” чадавхжуулах сургалтыг зохион байгуулаад байна. Гар утасны камерын үндсэн тохиргоог үр дүнтэй ашиглах чадвар болон хүүхэд хамгааллын үйлчилгээ, төрийн байгууллагын үйлчилгээг баримтжуулах, тайлан мэдээнд чанартай зураг дүрс оруулж тайлагнах зэрэг мэдлэг, ур чадвар олгох сургалтыг 43 хорооны Засаг дарга, хөгжлийн нийгмийн ажилтан, цэцэрлэгийн арга зүйч, сургуулийн нийгмийн ажилтан нийт 105 албан хаагчдыг, “Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын ажилтны өдөр”-ийг угтан “Урлагийн боловсрол, сэтгэл заслын VIP эвент” арга хэмжээг хөгжлийн нийгмийн ажилтан, гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжил, хамгааллын 10 ажилтан, нийт 53 албан хаагчдыг хамруулан уран зургийн	100%

						галарейд зохион байгуулж 158 албан хаагчийг чадавхжуулсан. 43 хорооны хамтарсан багийн гишүүдэд ажлын байранд нь арга зүй өгөх, хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлсэн байдалд хяналт, шалгалт хийх, зөвлөн туслах ажлыг 2022 оны 10 дугаар сарын 26-ны өдрөөс 11 дүгээр сарын 03-ны өдрийг дуустал зохион байгууллаа.	
26	3.3.2. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхэд, эмэгтэйчүүдийг хамгаалах байрыг ашиглалтад оруулж, хариу үйлчилгээг шуурхай үзүүлэх	-	Хариу үйлчилгээ авах хүүхэд, иргэн, тоо	200	200	Хууль зүй дотоод хэргийн яамны дэмжлэг, Азийн хөгжлийн банкны санхүүжилттэйгээр дүүргийн 10 дугаар хороонд баригдаж буй 400м <sup>2</sup> хүүхэд, эмэгтэйчүүдийг хамгаалах байрны барилгын гүйцэтгэл 80 хувьтай явагдаж байгаа бөгөөд барилгыг 2022 оны 12 дугаар сард ашиглалтад оруулахаар төлөвлөн ажиллаж байна. Бэлгийн хүчирхийллийн хэргийн тохиолдлын нийт 16 хүүхдэд 31.6 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж, эрх зүйн туслалцаа болон өмгөөлөгчийн зардлыг олгосон ба хүүхэд хамгааллын хариу үйлчилгээнд 150 хүүхэд хамрагдаж, эм тариа, хувцас, ахуйн хэрэглээний болон хүнсний дэмжлэгийг авсан.	90%
27	3.3.3. Гэр бүл, хүүхэд, залуучуудад чиглэсэн хөгжлийн үйлчилгээ үзүүлэх, тэдний эрхийг хангах, хамгаалах, оролцоог нэмэгдүүлэх зорилгоор Хөдөлмөр зусланг ажиллуулах	20.0 Дүүргийн төсөв	Зохион байгуулах арга хэмжээ, тоо	"Сонгины оюу" аяны хүрээнд 1600 гаруй хүүхэд, залуучуудын уралдаан зарлаж, шилдэг 54 оролцогчийг шалгаруулан, 8.7 сая төгрөг зарцуулсан.	5	Хүүхдийн эрхийг хангах, хамгаалах, оролцоог нэмэгдүүлэх, "Монгол зан заншил", ёс суртахууны төлөвшил, хөдөлмөрлөх дадал, зуршил олгох, хүүхэд хөгжлийн үйлчилгээ үзүүлэх зорилготой "Хөдөлмөрч хүүхэд" зуслангийн үйл ажиллагааг дүүргийн "Амралт цогцолбор"-ын дэргэд 2022 оны 7 дугаар сарын 18-ний өдрөөс 8 дугаар сарын 15-ны өдрийг дуустал хугацаанд зохион байгууллаа. Зуслангийн арга хэмжээ нь нийт 4 ээлжээр, дүүргийн ахлах ангийн 240 сурагчдыг хүлээн авч, үнэ төлбөргүй хамруулж арьсан урлал, эсгий урлал хийх, зүү ороох зэрэг сургалтыг хийсэн ба сургалтыг дүүргийн "Эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн хөгжлийн төв"-тэй хамтран явуулсан. Зуслангийн үйл ажиллагаа Олон улсын хүүхдийн "Найрамдал" төвийн хөтөлбөрөөр явсан бөгөөд цагаан идээ боловсруулах, учиртай уяа зангилаа сурах, монгол гэр барих зэрэг уламжлалт арга ухаанд суралцахаас гадна өвлөн биелье бүжгийн сургалт, багийн ажил-багийн тоглолт, оньсон тоглоом наадгай, сэтгэл зүйн боловсрол олгох зэрэг хөгжлийн хөтөлбөрүүдэд хамрагдаж ур чадвараа нэмэгдүүллээ.	100%
28	3.3.4. Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан	20.0 Дүүргийн төсөв	Хэрэгжүүлэх төсөл, тоо	Гэр бүлийн хүчирхийлэл үйлддэг 69	1	Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх "Хүүхэд, эмэгтэйчүүдийн хөгжил, хамгаалал" төслийг ЕБС, цэцэрлэг болон мэргэжлийн байгууллагуудын саналыг тусган 6 зорилтын	70%

	сэргийлэх “Хүүхэд эмэгтэйчүүдийн хөгжил хамгаалал” төсөл боловсруулан хэрэгжүүлэх			эмчилгээнд хамруулж, “Шийдэл” сэдэвт зөвлөгөөн зохион байгуулсан.		хүрээнд 17 үйл ажиллагаа зохион байгуулахаар боловсруулж, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дэргэдэх Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлд хүргүүлсэн. Төслийг хүргүүлснээр дүүргийн Онцгой байдлын хэлтэс, ИТХ-ын дэргэдэх Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөлтэй хамтран “Ээлтэй-ирээдүй” нөлөөллийн аяныг гурван үе шаттайгаар хэрэгжүүлж, нийт 181 боловсролын байгууллагад хяналт шалгалтыг зохион байгуулж, илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээ авч, ерөнхий боловсролын дунд болон ахлах ангийн сурагчдын дунд “Оролцоотой хүүхэд-1000” хүүхдийн чуулга уулзалтыг зохион байгууллаа. Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх “Хүүхэд, эмэгтэйчүүдийн хөгжил, хамгааллын VOICE UP” төслийг боловсруулан, 11 үйл ажиллагааг 3 сарын хугацаатай зохион байгуулахаар төлөвлөн, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Төслийн хүрээнд “Урам” арга хэмжээг хэрэгжүүлж эрүүлжүүлэх байранд удаа дараа бүртгэгдсэн иргэдийг хамруулж, зөвлөн туслах үйлчилгээг үзүүлж, архинд донтох өвчний архагшсан шинж тэмдэгтэй 22 иргэнийг клиник эмчилгээ, “Гоё амьдрал” ТББ-аас эрхлэн явуулдаг донтолтын ховс эмчилгээнд хамруулж, сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг явуулсан. Мөн хүүхэд хамгааллын үйлчилгээг тохижуулсан автобусаар хөдөлгөөнт явуулын хэлбэрээр зохион байгуулж, ГБХЗХХ-ийн мэргэжилтнүүд сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээ болон хууль эрх зүйн зөвлөгөө мэдээллийг өгч ажиллаж байна. Тус арга хэмжээнд дүүргийн 14 сургуулийн 3-12 дугаар ангийн 670 хүүхэд хамрагдаж “Үе тэнгийн дарамт дээрэлхэлт”, “Өсвөр насны онцлог”, “Сэтгэл хөдлөлөө удирдах арга”, “Гэр бүлийн харилцаа хандлага” сэдвийн хүрээнд ярилцлага хийж, мэдээлэл авсан. Мөн өсвөр үеийн сурагчдын манлайлах, нөлөөлөх, бүтээлчээр сэтгэх, нийгмийн амьдралд идэвхтэй оролцох ур чадварыг хөгжүүлэх зорилт бүхий “Зөв өглөө” цуврал уулзалтыг нийт 7 удаа зохион байгуулж 260 гаруй ахлах ангийн сурагчдыг хамруулж ажиллаад байна.	
29	3.3.5. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, тэдний эцэг эх, асран хамгаалагчдын	5.5 Дүүргийн төсөв	Зохион байгуулах арга хэмжээ, тоо	Хөгжлийн бэрхшээлтэй 741 хүүхдээс сургуульд суралцдаг	1	“Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэндийг дэмжих” арга хэмжээг Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс, дүүргийн Нэгдсэн эмнэлэг, Гүүднейборс ОУБ, Очирт тулга ХХК тусгай хэрэгсэл нийлүүлэгч байгууллагуудтай хамтран зохион	100%

	нийгмийн оролцоог нэмэгдүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах			хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд 324, тусгай сургуульд 156, сургуульд суралцдаггүй 239, сургууль завсардсан 22 хүүхэд байна.		байгууллаа. Тус арга хэмжээний хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг дүүргийн Нэгдсэн эмнэлгийн нарийн мэргэжлийн эмч нарын үзлэг, оношлогоонд үнэ төлбөргүй хамруулж, тэдний эцэг, эх асран хамгаалагчдад сэтгэл зүйн болон хууль эрх зүйн зөвлөгөө, мэдээлэл өглөө. Үзлэгт нийт 250 хүүхэд хамрагдсан ба “Сүү” Хувьцаат компани нийгмийн хариуцлагын хүрээнд 1.0 сая төгрөгийн бүтээгдэхүүний дэмлэг үзүүлж, гарын бэлэг гардуулсан. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг, эхчүүдэд зориулсан “Дауны синдром гэж юу”, “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүдэд өгөх зөвлөгөө” сэдэвт сургалтыг 53 эцэг, эх, асран хамгаалагчдыг хамруулан, “HOLT” Олон улсын байгууллагатай хамтран “Асаргаа ба хооллолт” сургалтыг төрөлхийн ДЦП буюу тархины саа, саажилт оноштой, өөрөө хоолоо идэж чаддаггүй байнгын асаргаанд байдаг 20 хүүхдүүдийн асран хамгаалагчдыг хамруулан зохион байгууллаа. Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах үндэсний төв”-тэй хамтран “Бяцхан гэрэл 5” хүүхдийн баярын нэгдсэн арга хэмжээг зохион байгуулж тус төвд хэвтэн эмчлүүлж байгаа 100 хүүхдэд баярын бэлэг гардуулсан. Баян-Өлгий аймгийн “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгаалалын орон тооны бус салбар комисс”-ын гишүүдэд дүүргийн салбар комиссын үйл ажиллагааг танилцуулах, харилцан туршлага солилцох, үзүүлэх ажлыг зохион байгууллаа. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эх, асран хамгаалагчдын нийгмийн оролцоог нэмэгдүүлэх, хөгжүүлэх, нийгмийн харилцаанд тэгш оролцуулах, мэдлэг мэдээллээр хангах “НИЙГМИЙН ОРОЛЦООГ ДЭМЖЬЕ” арга хэмжээг зохион байгуулж, 43 хорооны 150 гаруй асран хамгаалагчдыг оролцуулж, төрийн байгууллагын төлөөлөлүүд өртөөчилсөн байдлаар мэдээлэл хүргэж ажилласан. Арга хэмжээний хүрээнд явган аялал, хөгжөөнт буухиа, хууль эрх зүйн мэдлэгийг сорих “АХА” тэмцээнүүдийг явууллаа.	
30	3.3.6. Гэрлэх ёслолын өргөөг ашиглалтад оруулж, үйл	230.0 Дүүргийн төсөв	Ашиглалтад орох өргөө, тоо	0	1	“Гэрлэх ёслолын өргөө” тохижуулах ажлын зураг төсвийг “Грийн арт солишн” ХХК хийж гүйцэтгэсэн. Дотоод засал чимэглэл, тохижилтын ажлыг “Өндөр хаан өргөө” ХХК гүйцэтгэж байна. Тус өргөөг 2022 оны 12 дугаар сард хүлээж авахаар төлөвлөөд байна.	70%

	ажиллагааг тогтмолжуулах						
31	3.3.7. Залуу гэр бүлүүдэд зориулсан сургалт, нөлөөллийн ажлыг тогтмол зохион байгуулж хэвшүүлэх	2.0 Дүүргийн төсөв	Зохион байгуулах сургалт, тоо	Нийт 860 залуу гэр бүлийн 1370 иргэнд 54 удаагийн танхимын болон цахим сургалт, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулсан.	8	Иргэдэд гэр бүлийн боловсрол олгох зорилгоор “Стресс менежмент”, “Хүүхэд хүмүүжлийн эерэг арга”, “Гэр бүл дэх жендэрийн эрх тэгш байдал”, “IQ хөгжүүлэх нь” сэдэвт сургалтыг 8 удаа зохион байгуулж дүүргийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багш, эцэг, эхчүүд, хороодын иргэд, цэргийн ангийн албан хаагч бүхий нийт 1500 иргэнийг хамрууллаа. Дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн дэргэдэх “Эцэг эхийн зөвлөл”-ийн залуу гишүүдэд “Хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга”, “Өсвөр насны хүүхэдтэй хэрхэн харилцах вэ?” зэрэг сэдвээр сургалтыг явуулж, 15 гишүүн хамрагдсан. Цахимаар гэр бүлийн боловсрол олгох цуврал подкастын 4 дугаарыг “Гэр бүл дэх жендэрийн тэгш байдал”, “Гэр бүлийн харилцаа хандлага”, “Гэр бүлийн орчин хүүхдийн хүмүүжилд хэрхэн нөлөөлөх нь” “Гэр бүл төлөвлөлт” сэдвүүдийн хүрээнд зохион байгуулан 5000 гаруй иргэнд мэдээлэл олгосон ба “Хүүхэд хүмүүжлийн эерэг арга” сэдвээр нээлттэй лайв хийж 1500 иргэнийг оролцууллаа. Эрүүл мэндийн боловсрол олгох, эцэг эх болох бэлтгэл, төрөлт ба төрөх үйл явц, нярайн асаргаа, сувилгаа, хосууд хэрхэн бие биенээ дэмжих туслах талаар болон гэр бүл төлөвлөлттэй холбоотой зөвлөгөө, мэдээлэл олгох зорилготой гэр бүлийн сургалтыг 115 иргэнийг хамруулан “Энх Төрөхүй жирэмсэн эмэгтэйчүүдийн сургалтын төв”-тэй хамтран зохион байгуулсан.	100%
<b>Зорилт 3.4 Төр хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлж, олон улсын болон гадаад дотоодын байгууллагуудтай хамтран ажиллаж хөрөнгө оруулалтыг татаж, жижиг дунд үйлдвэрлэл, бизнесийг хөгжүүлэх таатай орчныг бүрдүүлж, тэдгээрийн оролцоог нэмэгдүүлнэ.</b>							
32	3.4.1. Улаанбаатар хотын хүнсний хаягдлыг дахин боловсруулах төсөл хэрэгжүүлэхэд хамтарч ажиллах	5,700.0 ОУБ-ын хөрөнгө	Төслийн хэрэгжилт, хувь	0	30	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанаас Азийн хөгжлийн банктай хамтран Ази, Номхон далайн бүсийн тогтвортой хөгжлийн Япон сангийн 3 сая долларын санхүүжилтээр “9202-МОН: Улаанбаатар хотын хүнсний хог хаягдлыг дахин боловсруулах төсөл”-ийг 2020-2023 онд хэрэгжүүлж эхэлсэн. Төслийн хүрээнд дүүргийн 3 дугаар хорооны хүнсний ногооны чиглэлээр үйлдвэрлэл эрхлэгч 25 айл өрхүүд хамрагдаж, 16 кг органик компост бордоог боловсруулсан. 2022 оны 11 сараас Ерөнхий боловсролын 67 дугаар сургууль, Сургуулийн өмнөх насны боловсролын 80 дугаар цэцэрлэгүүдэд хэрэгжиж эхэлсэн	70%

						бөгөөд хүнсний хаягдлыг дахин боловсруулах, бордоо хийх, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, зохистой хэрэглээний хандлагыг бий болгох талаар сургалтыг зохион байгуулж, 580 ширхэг гарын авлага тарааж, төсөл хэрэгжүүлсэн айл өрхүүдийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлсэн.	
33	3.4.2. Улаанбаатар хотын тогтвортой зам тээврийн хөгжил төсөл хэрэгжүүлэхэд хамтарч ажиллах	ОУБ-ын хөрөнгө	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	0	100	<p>Төслийн хүрээнд иж бүрэн гудамж замын одоо байгаа сүлжээг засварлаж, шинэчлэх шинээр авто зам барих, замын хөдөлгөөний зохицуулалтын ухаалаг тээврийн системийг нэвтрүүлэх, Замын хөдөлгөөний удирдлагын төвийн системийн цогц шинэчлэл хийх, хөдөлгөөний аюулгүй байдлыг сайжруулах, нийтийн тээврийг сайжруулах, хотын зам, тээврийн стратегийн судалгаа, чадавх бэхжүүлэх арга хэмжээнүүдийг авна. 2022 онд хийгдэхээр төлөвлөсөн ажлууд:</p> <p>1. Сонгогдсон шинээр барих авто зам, гудамжны бүтээн байгуулалтын Техник эдийн засгийн үндэслэл, нарийвчилсан зураг төслийн ажлыг эхлүүлнэ. 1, 2, 3, 4, 5, 6, 20, 26, 33, 34, 35, 37, 42 дугаар хороод шинээр тавих авто замын зураг төслийн ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газарт зарлагдсан.</p> <p>2. Сонгогдсон гудамж замыг шинэчлэх, өөрчлөн байгуулах бүтээн байгуулалтын нарийвчилсан зураг төслийг боловсруулна.</p> <p>3. Ухаалаг тээврийн систем болон ухаалаг, бүсчилсэн зогсоолын судалгаа хийх, эрх зүйн баримт бичиг боловсруулна. Улаанбаатар хотын гэр хорооллыг хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр төслийн хүрээнд Баянхошуу дэд төвийн бүтээн байгуулалтаар дүүргийн 10 дугаар хороо Зүүн баян уул 9 дүгээр гудамжнаас 28 дугаар хороо Хувьсгалчдын зам хүртэлх 1,4 км замын ажлыг 2021-2022 онд “Шилдэг зам” ХХК хийж гүйцэтгэсэн.</p> <p>Азийн хөгжлийн банкны 2022-2023 оны санхүүжилтээр 1 дүгээр хорооллын арын холбоос авто зам, замын байгууламж нь Толгойтын авто замыг Ард аюушийн өргөн чөлөөтэй холбох 3.6 км авто замын ажил хийгдэхээр төлөвлөгдсөн. Авто замын трасст 6, 23, 30, 31, 37, 43 дугаар хорооны нийт 324 нэгж талбар нөлөөлөлд өртсөн. Үүнээс 43 нэгж талбарыг нөлөөллөөс гаргаж, 281 нэгж талбараас 197 нэгж талбартай зөвшилцөн газар чөлөөлөлтийн ажлыг гүйцэтгэж байна. 84 нэгж талбарын</p>	70%



						айл өрх, аж ахуйн нэгж байгууллагатай газар чөлөөлөлтийн талаар зөвшилцөх ажил хийгдэж байна.	
34	3.4.3. Дүүргийн аялал жуулчлалын маршрутын дагуу аялал зохион байгуулах	2.5 Дүүргийн төсөв	Зохион байгуулах ажил, тоо	Морин аялал хийх маршрут бүхий танилцуулга гаргасан.	2	Дүүрэг үүсгэн байгуулагдсаны 30 жилийн ойг угтан, Засаг даргын 2022 оны А/308 дугаар захирамжийн хүрээнд “Сонгинохайрхан уул-Хун нуурын шинэ явган аялал”-ын маршрутын дагуу “Эко явган аялал” зохион байгуулж, хайрхан уул болон нуурын орчмын бохирдлыг цэвэрлэн, аялагч, иргэдэд зориулсан амьтан, ургамал, шувуудын төрөл зүйлийн тухай тухай танилцуулга бүхий 4 самбарыг байршуулж тохижилт бүтээн байгуулалтын ажлуудыг өрнүүлээ. Аяллын хөтөлбөрт хайрханаа тахих, шувуу ажиглах, буухиа тэмцээн зохион байгуулж, ИТХ-ын Ажлын алба, ЗДТГ, харьяа байгууллагуудын 150 гаруй албан хаагчид оролцсон. “Сараана байгаль хамгаалах сан” ТББ-тай хамтран Хун нуурыг танилцуулах, шувуу ажиглах аяллыг нийслэлийн ерөнхий боловсролын 60 гаруй сурагчдыг хамруулан зохион байгуулж хун нууранд ирж зуншдаг шувуудын төрөл зүйл, аймгийн талаар танилцуулга мэдээлэл хийсэн.	100%
35	3.4.4. Сонгинохайрхан уулын тохижилтын ажлыг эхлүүлж, явган аяллын цогцолбор болгох, Нарангийн энгэр дэх төвлөрсөн хогийн цэгийн хог хаягдал буулгах талбайд нөхөн сэргээлтийн ажлыг хийж, эко орчин бүрдүүлэх	800.0 Нийслэлийн төсөв	Тохижилт нөхөн сэргээлт хийх талбай, га	Сонгинохайрхан уулын явган аялалын маршрутын дагуу тохижилтын ажлыг нийслэлийн төсвийн 63.0 сая төгрөгийн төсөвт өртгөөр хийсэн.	4	Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/397 дугаар захирамжаар Сонгинохайрхан уулын явган аяллын маршрутын дагуу сандал сүүдрэвч, авто машины зогсоол, танилцуулга бүхий тохижилтын ажлыг нийслэлийн төсвийн 63.0 сая төгрөгийн төсөвт өртгөөр хийгдсэн. Дүүргийн Засаг даргын захирамжаар ажлын хэсэг байгуулагдаж, холбогдох судалгаа, танилцуулгыг хийсэн. Үүнд: 1. Сонгинохайрхан уулыг түшиглэсэн явган аяллын маршрут, 2. Аялагчдад зориулсан - Найрамдал олон улсын хүүхдийн зуслангийн Цагаан хаалга,-Цэдэнбал Филатовагийн хөшөө дурсгалтай танилцах-Шижирийн даваагаар давж 21 дүгээр хороо Жаргалант тосгоны соёлын төвд үндэсний өв соёлоо хадгалсан язгуур урлагийн тоглолт, Улаанбаатар хотын явуулын музей үзэх, Хүйн голд уламжлалт сийлбэртэй монгол гэр, адууны өв соёлтой танилцаж, Цагаан бургастай аманд дүүргийн Амралт цогцолборын газарт амарч, морин аялал хийх маршрут бүхий танилцуулга гаргасан. Мянганы сорилтын сангийн санхүүжилтээр Сонгинохайрхан уулын тохижилтын ажлын хүрээнд явган аяллын маршрут, хэлмэгсдийн хөшөө орчмын тохижилтын ажил хийгдсэн. Улаанбаатар хотын захирагчийн ажлын албанаас Нарангийн энгэрийн хогийн цэгт нийт 20 га газрын нөхөн сэргээлт,	100%

						зүлэгжүүлэлт хийгдэхээр төлөвлөсөн. Үүнээс 2020, 2021 онд тус бүр 8 га, 2022 онд 4 га, талбайн нөхөн сэргээлтийн ажлыг "Сүхбаатар-Тохижилт" ХХК хариуцан гүйцэтгэсэн.	
<b>Зорилт 3.5 Гэр хорооллын иргэдийн усны хангамжийг сайжруулж, ухаалаг худаг төслийг хэрэгжүүлж, иргэдийг 24 цагийн турш ундны усаар хангана.</b>							
36	3.5.1. Гэр хорооллын айл өрхүүдийг цахилгаан эрчим хүчээр хангах ажлыг хийж гүйцэтгэх /31 дүгээр хороо/	40.0 НОНХС	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	5418 өрхийн цахилгаан эрчим хүчний хүчдлийг сайжруулах, цахилгаан эрчим хүчинд холбогдох шаардагдах 16.5 тэрбум төгрөгийн зардлын тооцоог гаргасан.	100	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022-2023 онд он дамжин хэрэгжих дүүргийн 1, 21, 22, 26, 28, 31, 32, 33, 39, 40, 42 дугаар хороодын айл, өрхүүдийг цахилгаан эрчим хүчинд холбох хүчдэлийн уналттай айл өрхүүдийн цахилгаан хангамжийг сайжруулах төсөл арга хэмжээ 6 багц ажил болгон Эрчим хүчний яаманд тендер зарлагдаж, ажил гүйцэтгэх байгууллага шалгаран, гэрээ байгуулах ажлууд хийгдэн, зарим хороодын ажлууд хийгдэж эхлээд байна. Үүнд: -31 дүгээр хорооны Дундарангийн 17, 18 дугаар гудамжны айл, өрхүүдийг цахилгаан эрчим хүчээр хангах ажил дээрх багцад орсон тул зориулалтыг өөрчлүүлэхээр Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар, Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газруудад албан бичиг хүргүүлсэн. -Сонгинохайрхан дүүргийн 22, 26, 32, 33 дугаар хороодын нийт 2513 өрхийн цахилгаангүй болон хүчдэлийн уналттай айл өрхүүдийг эрчим хүчинд холбох 3,835,8 сая төгрөгний санхүүжилтээр хийгдэх ажлын гүйцэтгэгчээр "Энержи тех" ХХК шалгарч ажил эхэлсэн. -Нийслэлийн төсвийн 199,7 сая төгрөгний хөрөнгө оруулалтаар дүүргийн 26, 41 дүгээр хороодын хүчдэлийн уналттай айл өрхийг цахилгаан эрчим хүчээр хангах ажлын гүйцэтгэгчээр "Чандмань хонгор групп" ХХК шалгарч, Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт гэрээ баталгаажиж зураг төсөл хийгдсэн. -Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн 79,4 сая төгрөгний хөрөнгөөр 39 дүгээр хороо Хамбын овоо орчмын хүчдэлийн уналттай айл өрхүүдийг цахилгаан эрчим хүчээр хангах ажлын гүйцэтгэгчээр "Перфект солюшн энд инженеринг" ХХК шалгарч, 2022 оны 06 дугаар сард бүрэн дуусч, байнгын ашиглалтад хүлээж авах комисс ажиллан комиссын дүгнэлт баталгаажсан. -21 дүгээр хороо 335 гарам дүүргийн төсвийн 72,7 сая төгрөгөөр мал бүхий иргэдийг эрчим хүчээр хангах ажилд Инерци ХХК шалгарч, хүлээлгэн өгсөн.	70%
37	3.5.2. Хүн амын тоонд нийцүүлэн гүний худаг,	210.0 Улсын төсөв,	Ашиглалтад оруулах худаг, тоо	22, 31, 35-р хороодод гүйцэтгэгчээр	7	Нийслэлийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 22, 24, 26, 31, 35 дугаар хороодын нутаг дэвсгэрт зөөврийн ус түгээх байр барих байршлыг Улаанбаатар хотын Ус сувгийн удирдах	70%

	зөөврийн ус түгээх байр барьж ашиглалтад оруулах /1, 7, 24, 22, 26, 31, 35 дугаар хороо/	40.0 НОНХС		“Урал их” ХХК шалгарч, 24, 26-р хороодын 4 зөөврийн ус түгээх байр барих ажил дууссан.		газар ОНӨААТҮГ-т албан бичгээр судалгаа болон kmz файлыг хүргүүлж байршлуудыг судлан тогтоож, Газар зохион байгуулалтын албаар газрын гэрчилгээ, кадастрын зургийг хийлгэн Засаг даргын Тамгын газрын нэр дээр гаргуулсан. Энэ ажлын хүрээнд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар: -33 дугаар хорооны Тахилт 4, 7, 13 дугаар гудамжинд 240,0 сая төгрөгний санхүүжилтээр 3 ус түгээх байр барих ажлын гүйцэтгэгчээр “Виво зоно” ХХК шалгарч барилгын ажил бүрэн дуусаж, 2022 оны 12 дугаар сард байнгын ашиглалтад оруулах комисс ажиллах бэлтгэл ажлыг хангасан. Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар: -22 хороонд 59,9 сая, 31 дүгээр хороонд 58,6 сая, 35 дугаар хороонд 119,8 сая төгрөгний санхүүжилтээр 2 ус түгээх байр барих ажлын гүйцэтгэгчээр “Урал их” ХХК шалгарч, 31, 22 дугаар хороодын ус түгээх байрны барилгын ажил бүрэн дуусаж, 35 дугаар хорооны 2 ус түгээх байрны барилгын ажлын явц 80%-ийн гүйцэтгэлтэй байна. -24, 26 дугаар хороонд 234,4 сая төгрөгний санхүүжилтээр 4 ус түгээх байр барих ажлын гүйцэтгэгчээр “Зорь бүтээ” ХХК шалгаран, 2022 оны 06 дугаар сард ашиглагч байгууллагад хүлээлгэн өгч, байнгын ашиглалтад оруулсан. Мөн Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө 38,6 сая төгрөгний санхүүжилтээр ухаалаг худгийн тоог нэмэгдүүлэхээр “Баялаг говь” ХХК шалгарсан. Тайваний хүүхэд, гэр бүлийг дэмжих сангийн “Ундны усны хангамжийг сайжруулах төслийн хүрээнд 32, 33 дугаар хороонд нийт 116.5 сая төгрөгийн ус түгээх байрыг шинээр барьж хандивласан. Шинээр баригдсан ус түгээх 2 байранд ухаалаг худгийн төхөөрөмжийг нийт 19.6 сая төгрөгөөр суурилуулсан. Ус түгээх байруудыг нийслэлийн өмчид бүртгүүлж, байнгын ашиглалтад оруулах хүсэлтийг Нийслэлийн өмчийн харилцааны газар, Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ-дад тус тус хүргүүлсэн.	
38	3.5.3. 3, 4, 26, 36 дугаар хороодын айл өрхүүдийг цэвэр, бохир усны шугам сүлжээнд	3,400,0 Улсын төсөв	Ажлын явц, хувь	30	100	Улсын төсвийн 4,500,0 тэрбум төгрөгний санхүүжилтээр 3, 4, 26, 36 дугаар хороодын айл өрхүүдийг цэвэр бохир усны шугам сүлжээнд холбох ажлын гүйцэтгэгчээр “Гидродизайн инноваци” ХХК-ны туслан гүйцэтгэгчээр “Баткомплект” ХХК шалгарч цэвэр бохир усны шугам сүлжээнд холбох шугам сүлжээний ажил	50%

	холбох ажлыг үргэлжлүүлэх					гүйцэтгэх шатандаа. Бохир усны шугам сүлжээнд холбох ажил бүрэн дуусч, цэвэр усны шугам сүлжээнд холбох ажил 50%-тай хийгдэж байна.	
39	3.5.4. 5 дугаар хорооны айл өрхүүдийг инженерийн шугам сүлжээнд холбох ажлын зураг, төсвийг хийх	40.0 Дүүргийн төсөв	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	0	100	Сонгинохайрхан дүүргийн 5 дугаар хороо Баянголын 8, 9, 10, 11, 13 дугаар гудамжны айл өрхүүдийг төвлөрсөн цэвэр, бохир усны шугам сүлжээнд холбох ажлын зураг төсөл боловсруулах ажлын тендер 3 удаа зарлагдсан боловч гүйцэтгэгч компани шалгараагүй.	30%
40	3.5.5. Гэр хорооллын гудамж дунд Чулуун авто зам шинээр тавих, Шороон замын засвар шинэчлэлт хийх /30, 36, 40 дүгээр хороо/	80.0 НОНХС , 93.04 ДОНХС	Ашиглалтад оруулах авто зам, км	Нийт 9.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй авто замын ажлууд хийгдсэн.	100	Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн 77,6 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар дүүргийн 30 дугаар хороонд “Мега титан” ХХК чулуун авто зам тавих ажлыг гүйцэтгэж байнгын ашиглалтад оруулсан. 36 дугаар хороонд 43,6 сая, 40 дүгээр хороонд 49,4 сая төгрөгийн санхүүжилтээр шороон замын нөхцөл сайжруулах ажилд “Этүгэн жим” ХХК хийж гүйцэтгэн, байнгын ашиглалтад оруулсан.	100%
41	3.5.6. Нийтийн тээврийн үйлчилгээний чиглэлийг нэмэгдүүлэх арга хэмжээг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулж, 38, 40 дүгээр хороодод автобусны буудал байгуулах	60.0 НОНХС , 44.1 ДОНХС	Нэмэгдэх чиглэл, буудлын тоо	Шинээр чиглэл нээх, тээврийн хэрэгслийн тоог нэмэгдээгүй.	3	Дүүргийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр автобусны буудал шинээр байгуулах ажлын үнэлгээний хороо байгуулагдсан. Нийтийн тээврийн үйлчилгээний чиглэлийг нэмэгдүүлэх арга хэмжээний хүрээнд дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 38 дугаар хороонд хийгдэх автобусны буудлыг Өндөр буянт хайрхан ХХК 43,5 сая төгрөгөөр, нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө 59,9 сая төгрөгөөр 9 дүгээр хороонд Автобусны буудал шинээр хийх тохижуулах ажлын тендерт “Өндөр буянт хайрхан” тус тус шалгарсан. 24, 41 дүгээр хороодод Автобусны эцсийн буудлын зогсоол байгуулах тохижуулах ажлыг дүүргийн Хот тохижуулах зардал 16,9 сая төгрөгөөр Дэд бүтцийн хөгжлийн алба ОНӨААТҮГ хийж гүйцэтгэхээр гэрээ байгуулсан. Иргэдээс ирүүлсэн хүсэлтийг Нийтийн тээврийн үйлчилгээний газар албан бичгээр хүргүүлсэний дагуу Толгойт Ботаник чиглэлийн автобусыг 2022 оны 05 дугаар сараас 2 чиглэлд үйлчилгээ үзүүлж эхэлсэн.	90%
<b>Хэсгийн дундаж хувь</b>							<b>76.5</b>
<b>ЗОРИЛГО 4. “ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ТӨРИЙН АЛБАН ХААГЧДЫН НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ХӨТӨЛБӨР”, “ТӨРИЙН АЛБАН ХААГЧДЫН СУРГАЛТЫН ДЭД ХӨТӨЛБӨР”-ИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХҮРЭЭНД:</b>							

**Зорилт 4.1 Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах, сургалтын дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж, мэргэшсэн, чадварлаг ёс зүйтэй, хариуцлагатай төрийн албыг бүрдүүлнэ.**

1	4.1.1. “Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр”-ийн 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах	100.0 Дүүргийн төсөв	Хамрагдсан албан хаагчид	23 албан хаагчдад 15,2 сая төгрөгийн мөнгөн тусламж үзүүлсэн.	80 албан хаагчийг тэтгэлэгт хамруулна.	<p>“Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр”-ийг 2022 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд албан хаагчдын ажиллах нөхцөл, хангамжийг сайжруулах, ажлын байранд сонгон шалгаруулах, удирдах албан хаагчдын манлайллын чадварыг хөгжүүлэх, амьдрах нөхцөлийг сайжруулах, тусламж дэмжлэг үзүүлэх, эрүүл мэндийг хамгаалах, бие бялдрыг хөгжүүлэх, гадаад, дотоодын хамтын ажиллагааг хангах, хүний нөөцийн ил тод байдлыг хангах, ёс зүй, чиг хандлагыг өөрчлөх зорилтын хүрээнд нийт 28 ажил төлөвлөн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Хөтөлбөрийн хүрээнд:</p> <p>Албан хаагчдын ажиллах нөхцөл, хангамжийг сайжруулах зорилтын хүрээнд нийт 839,960,238 төгрөгийг зарцуулсан байна.</p> <p>Албан хаагчдын амьдрах нөхцөлийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх, нийгмийн баталгааг хангах зорилтын хүрээнд нийт 266,375,811 төгрөгийн мөнгөн тусламж үзүүлсэн.</p> <p>Төрийн албан хаагчдын ур чадварыг дээшлүүлэх төлөвлөгөөний хүрээнд Төрийн албан хаагчдын сургалтаар хөгжүүлэх 2 бүлэг, 14 заалт бүхий төлөвлөгөө гарган хэрэгжилтийг ханган ажилласан. Дүүргийн Засаг даргын Тамгын газраас холбогдох төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамран 36 удаагийн сургалт зохион байгуулж, давхардсан тоогоор нийт 1603 албан хаагчдыг хамрууллаа.</p>	100%
2	4.1.2. “Дүүргийн Засаг даргын Тамгын газрын сургалтын дэд хөтөлбөр”-ийн хүрээнд хэрэгжих 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, төрийн албан хаагчдыг богино болон дунд	-	Сургалтад хамрагдах хүн, тоо	Дэд хөтөлбөрийн хэрэгжилт 91.0 хувь, сургалтад хамрагдсан хүний тоо 1406, 79,1 сая төгрөг зарцуулсан.	Албан хаагчдыг бүрэн хамруулсан байх	<p>Төрийн албан хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх зорилтын хүрээнд 2 бүлэг, 14 заалт бүхий сургалтын төлөвлөгөө гаргаж холбогдох байгууллагуудтай хамран 36 удаагийн сургалт зохион байгуулсан. Үүнд:</p> <p>Төрийн албан хаагчийн мэргэшүүлэх багц сургалтад 20, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хүний нөөцийн хөгжлийн төвөөс зохион байгуулсан төлөвлөгөөт, богино хугацааны болон сэдэвчилсэн 27 удаагийн сургалтад 642, БНХАУ-ыг хэрэгжүүлж байгаа “Бүс ба Зам” санаачилгаас зохион байгуулсан сургалтад 1, Сингапур улсад зохион байгуулагдсан “Хүнсний бүтээмж, ХАБ, инновацын хөтөлбөр, Сингапурын туршлагаас хуваалцах нь” сэдэвт сургалтад 1 албан хаагчийг хамруулсан. 2022 онд давхардсан тоогоор нийт</p>	90%

	хугацааны, мэргэшүүлэх багц сургалтад үе шаттайгаар хамруулах					1603 албан хаагчдыг сургалтад хамруулсан байна. 2023 онд зохион байгуулах сургалтын төлөвлөгөөг боловсруулах ажлын хүрээнд Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хүний нөөцийн хөгжлийн төвтэй хамтран албан хаагчдын сургалтын хэрэгцээ тодорхойлох судалгааг авч нэгтгэсэн.	
3	4.1.3. Төрийн албан хаагчдын ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж, дүгнэх	-	Хагас, бүтэн жилд	2021 онд 237 албан хаагчдын ажлын гүйцэтгэл, үр дүнг дүгнэн, 235.9 сая төгрөгийн урамшуулал олгосон.	Хамрагдах албан хаагчид, гүйцэтгэлийн хувь	Засаг даргын Тамгын газрын даргын 2022 оны А/80 дугаар тушаалаар албан хаагчдын 2022 оны эхний хагас жилийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшин, хөдөлмөрийн гэрээний биелэлтийг үнэлэх ажлын хэсгийг томилж, Тамгын газрын хэлтэс, тасаг, хороодын 252 албан хаагчдын тайланг үнэлж дүгнэх ажлыг зохион байгууллаа. “А” буюу маш сайн үнэлэгдсэн 31, “В” буюу сайн үнэлэгдсэн 207, “С” буюу хангалттай үнэлэгдсэн 2, F буюу хангалтгүй үнэлэгдсэн 1 албан хаагчдын үнэлгээг баталгаажуулсан. Засгийн газрын 2020 оны 218 дугаар тогтоолын дагуу А, В үнэлэгдсэн 238 албан хаагчдад дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2022 оны Б/297 дугаар тушаалаар үр дүнгийн урамшуулал 104,2 сая төгрөг олголсон. 2022 оны жилийн эцсийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшин, хөдөлмөрийн гэрээний биелэлтийг үнэлэх ажлын хэсгийг дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын А/155 тушаалаар томилж, 12 дугаар сарын 05-ны дотор үнэлгээг баталгаажуулж үр дүнгийн урамшуулал олгохоор төлөвлөж байна.	100%
<b>Хэсгийн дундаж хувь</b>							<b>96.6</b>
<b>ЗОРИЛГО 5. “ТУХАЙН ЖИЛД ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР ЗАРЛАСАН ЗОРИЛТОД АЖЛЫН ХҮРЭЭНД:</b>							
<b>Зорилт 5.1 Ойн зурвас, ногоон төгөл, цэцэрлэгт хүрээлэн барьж байгуулан нэг хүнд ноогдох ногоон байгууламжийг нэмэгдүүлнэ.</b>							
1	5.1.1.“Тэрбум” мод үндэсний хөдөлгөөний арга хэмжээг зохион байгуулж, Гэр хорооллын айл өрхүүдийг хашаандаа мод тарихыг уриалж, дэмжлэг үзүүлэх	420.0 Дүүргийн төсөв	Тарих мод, тоо	1 хорооны 50-60 айл өрхийг сонгон /1 айл өрхөд 5-6 ширхэг/ тарьц суулгацыг гарын үсгээр баталгаажуулан, ургалт арчилгааны бүртгэл хөтлөх	1.2 сая	“Тэрбум” мод үндэсний хөдөлгөөний хүрээнд нийт 8 зорилтын 31 арга хэмжээ зохион байгуулахаар төлөвлөгөө гаргаж боловсруулан Засаг даргын 2022 оны 3 дугаар сарын 29-ний өдрийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн. Дүүргийн Засаг даргын 2022 оны “Ногоон хот-Иргэдийн оролцоо” бүх нийтээр мод тарих ажлыг зохион байгуулах тухай А/251 дүгээр захирамжийн хүрээнд “Тэрбум” мод үндэсний хөдөлгөөний нээлтийн арга хэмжээг 5 дугаар сард 24 дүгээр хорооны Бумбатын рашаанд зохион байгуулсан. Арга хэмжээнд нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газрын харьяа 20 байгууллагын 315 албан хаагчид оролцож 2753 мод бут, сөөг тарьсан. 2021 оны 10 дугаар сард Ерөнхийлөгчийн Тамгын газар, БОАЖЯ, нийслэлийн ЗДТГ, Улаанбаатар хотын ЗАА,	50%

				гэрчилгээ гардуулсан.		Нийслэлийн Байгаль орчны газруудтай хамтран зохион байгуулж тарьсан 5199 модны усалгаа арчилгаа, нөхөн сэргээлтийн ажлыг 44 аж ахуй нэгж, байгууллагын 684 албан хаагчид оролцоотой хийж гүйцэтгэсэн. 2022 оны А/613 дугаар захирамжаар “Тэрбум” мод үндэсний хөдөлгөөний хүрээнд дүүргийн 43 хорооны 12500 иргэд, 164 аж ахуйн нэгж байгууллагын 1435 ажилтан албан хаагчид оролцож, 2022 онд нийтдээ 134276 мод таригдсан. Ойн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1-д заасны дагуу мөнгөн хандивыг 7 аж ахуйн нэгж байгууллагын 162 ажилтан албан хаагчид 1,620,000 төгрөгийг нийслэлийн Байгаль орчны газрын дансанд шилжүүлж мөнгөн хэлбэрээр тарих үйл ажиллагаанд оролцсон. Дүүргийн Засаг даргын 2022 оны “Ой угтсан бүтээн байгуулалтын ажил өрнүүлэх тухай” А/174 дүгээр захирамжийн хүрээнд 6 сарын аян зарлаж, болзолт уралдааны шалгуур үзүүлэлтийн дагуу аяныг дүгнэж, нийт 12 байгууллага, 2 хороо, 3 айл өрхийг шагнаж урамшуулсан. Энэ ажилд Хот тохижуулах зардлаас 13,4 сая төгрөг зарцуулсан.	
2	5.1.2. Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага бүр орчны 50 м газартаа мод, бут, сөөг тарьж, зүлэгжүүлэлт хийх ажлыг зохион байгуулж, хяналт тавьж ажиллах	-	Мод тарих ААНБ, хувь	40	50	Монгол Улсын Ерөнхийлөгчийн 58 дугаар зарлиг “Тэрбум” мод үндэсний хөдөлгөөний хүрээнд “Ногоон хот-Иргэдийн оролцоо” Бүх нийтээр мод тарих ажлыг зохион байгуулах тухай Дүүргийн Засаг даргын 2022 оны 5 дугаар сарын 04-ний А/251 дүгээр захирамжийг хүргүүлэн хэрэгжилтийн хангаж ажиллах чиглэлийг аж ахуйн нэгж, байгууллагуудад хүргүүлсэн. 2022 онд Хот тохижуулах зардлаас 62,2 сая төгрөгөөр 43 хороонд нийт 49283 мод, бут, сөөг, дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй төрийн байгууллага, үйлдвэр, үйлчилгээ, хүнс, бараа, зах худалдааны төвүүд, амралт сувиллын газар, төрийн болон хувийн хэвшлийн эмнэлэг, сургууль, цэцэрлэг, сууц өмчлөгчдийн холбоод нийт 17023 мод, бут, сөөг, тарьж, мэдээ тайланг Нийслэлийн байгаль орчны газар, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хотын тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн хэлтэст хүргүүлсэн. Нийт 66306 мод бут сөөг тарьсан.	100%
3	5.1.3. 28 дугаар хорооны нийтийн эзэмшлийн талбайн тохижилт, ногоон	100.0 НОНХС	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	0	100	Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө 100,0 сая төгрөгөөр 28 дугаар хорооны нутаг дэвсгэр Ногоон чулуутын 10 дугаар гудамжинд хийгдэх бичил цэцэрлэгт хүрээлэн байгуулах ажлын гүйцэтгэгчээр “Прогресс интер медишн” ХХК шалгарч, нийт 1000м <sup>2</sup> талбайд тохижилт, ногоон байгууламжийн ажлыг гүйцэтгэн, ашиглалтад оруулсан.	100%

	байгууламжийг нэмэгдүүлэх						
4	5.1.4. Баянхошуу хайрханы бэлд 2 га газарт цэцэрлэгт хүрээлэн байгуулах ажлыг үргэлжлүүлж, Хамбын овооны цэцэрлэгт хүрээлэн байгуулах ажлыг эхлүүлэх	1,700.0 АХБ, 3,000.0 Нийслэлийн төсөв	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	30	70	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр төслийн захиалгаар Баянхошуу дэд төвийн бүтээн байгуулалтын хүрээнд 9, 24 дүгээр хорооны нутаг дэвсгэр Баянхошуу хайрханы энгэр бэлд цэцэрлэгт хүрээлэн байгуулах ажлын гүйцэтгэгчээр "Дүүрэн трейд" ХХК шалгарсан. Нийт 2 га талбайд 8336 м2 ногоон байгууламж нийтийн бие засах газар, хөлбөмбөг, сагсан бөмбөгийн талбай, хүүхдийн тоглоомын талбай, эргүүлийн пост, авто машины зогсоол хийгдэхээр төлөвлөгдсөн. Ажлын гүйцэтгэл 60 хувьтай. Цэцэрлэгт хүрээлэнгийн бүтээн байгуулалтын ажлын нөлөөлөлд өртсөн 1 иргэнд 70,6 сая төгрөгийн нөхөн олговрыг олгосон. Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 39-р хорооны нутаг дэвсгэрт Хамбын овооны цэцэрлэгт хүрээлэнгийн ажил 2022-2023 онд хийгдэхээр төлөвлөгдөн, 2022 онд 3.0 тэрбум төгрөгийн санхүүжилт төсөвт тусгагдсаны дагуу 4 га газрыг тэгшилж, зураг төсөв боловсруулагдах шатандаа байна.	50%
5	5.1.5. Баянхошуу хайрханы "Төгсөгчдийн төгөл"-д мод тарьж, Улаанчулуут, Хүй долоон худаг орчимд ногоон төгөл байгуулах ажлыг үргэлжлүүлэх	5.0 Дүүргийн төсөв	Тарьсан мод, тоо	1500	3000	Баянхошуу дэд төвийн хүрээнд хийгдэж байгаа цэцэрлэгт хүрээлэнгийн ажил бүрэн дууссаны дараа "Төгсөгчдийн төгөл"-ийн 3 га газарт төгөл байгуулахыг ажлыг эхлүүлэхээр төлөвлөсөн. Дүүргийн "Тохижилт, цэвэрлэгээ, үйлчилгээ" ОНӨААТҮГ 26-р хорооны Улаан чулуутын ногоон төгөлд өмнөх онуудад тарьсан 500 ширхэг улиас, 61 ширхэг чацарганын усалгаа, арчилгаа, нөхөн сэргээлтийг тогтмол хийж байна. Улаанбаатар хотын захирагчийн ажлын албанаас Нарангийн энгэр дэх төвлөрсөн хогийн цэгийн 4 га талбайд нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт зүлэгжүүлэлтийг хийх ажил тендер зарлагдах шатандаа, Их нарангийн оршуулгын газрын хамгаалалтын бүсэд өмнө жил тарьсан 500 ширхэг улиас модны арчилгаа, цэнэг усалгааг дүүргийн нутаг дэвсгэрт Түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг "Ялгуусан" ХХК хийж гүйцэтгэсэн.	70%
<b>Зорилт 5.2 Агаар, хөрс, орчны бохирдлыг бууруулж, эрүүл аюулгүй орчныг бүрдүүлэн, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлыг эрчимжүүлэн экосистемийн тэнцвэрт байдлыг хадгална.</b>							
6	5.2.1. Түгээмэл тархацтай ашигт малтмалын	-	Хяналт тавих ААНБ, тоо	Нийт 22.0 сая төгрөгийн	6 аж ахуйн нэгж,	Түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгж байгууллагуудад холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран хяналт	100%



	ашиглалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагуудад холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран хяналт тавих			байгаль орчныг нөхөн сэргээх барьцаа хөрөнгийг байршуулсан.	байгууллагыг хамруулах	шалгалт хийх 4 зорилт 14 заалт бүхий төлөвлөгөөг боловсруулан, хяналт шалгалтын ажлыг үе шаттайгаар зохион байгуулахаар төлөвлөсөн. Дүүргийн Засаг даргын 2022 оны А/558 дугаар захирамжаар байгуулагдсан Ажлын хэсэг 10 дугаар сарын 03-наас 14-ний хооронд түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй 12 аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд газар дээр зөвлөн туслах, шалгалтын ажлыг хийж гүйцэтгэсэн. Огт газрын хэвлийн эвдээгүй үйл ажиллагаа эхлээгүй, зогссон 18 аж ахуйн нэгжийн холбогдох удирдлагыг дуудан уулзаж, бичиг баримтны бүрдэл нөхцөл байдлыг шалгаж зөвлөгөөг өгч ажилласан.Хяналт шалтгалтаар 16,748,159.00 төгрөгийн орлогыг татвар төлөгчдөөр тайлагнуулж, төсөвт төвлөрүүлж, 2022 оны 11 дүгээр сарын байдлаар нийт 24,028,383.28 сая төгрөгийн орлогыг дүүргийн төсөвт төвлөрүүлсэн. Зөрчилтэй “ЦДЦ” ХХК, “Жи Эс Эн Ди” ХХК, “Газрын орд” ХХК-дад Мэргэжлийн хяналтын хэлтэс, Татварын хэлтэс, Онцгой байдлын хэлтсүүд зохих арга хэмжээг авч, үүрэг даалгавар өгч ажилласан. “Монгол керамик” ХХК, “Эрэл” ХХК, “Ялгуулсан” ХХК, “Макадамтрансфортэйшн” ХХК, “Местранспортейшн” ХХК, “Монголит” ХХК, “Тэнгэрийн хүрд” ХХК, “Нарангол тоосго” ХХК, “Тэнгэрийн хүрд” ХХК нь 2022 онд үйл ажиллагаа явуулаагүй гэсэн хүсэлтээ албан бичгээр ирүүлсэн. Дүүргийн хэмжээнд 1712,15 га талбайд 28 аж ахуйн нэгжид түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрлийг холбогдох мэргэжлийн байгууллагаас олгосон байна.	
7	5.2.2. Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах, цуглуулж тээвэрлэх, тогтолцоог бий болгох замаар төвлөрсөн цэгт дарж булагдах хог хаягдлын хэмжээг бууруулан бага оврын дундын байгууламж барих	-	Ангилан ялгаж, дахин боловсруулалтад орсон хог хаягдал, хувь	13,950 тн ангилсан хог хаягдлыг ачиж тээвэрлэн дахивар авах цэг болон бордооны үйлдвэрүүдэд хүргэсэн.	3	Хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх менежментийг үр дүнтэй, зардал багатай, бүх оролцогчдод хүртээмжтэй болгох замаар гэр хорооллын оршин суугчдын цэвэр, эрүүл орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, хог хаягдлыг ангилан ялгаж хэвшүүлэхээр 2, 3 дугаар хорооны 500 айл өрхөд хог хаягдал ангилан ялгах савыг суурилуулан үүсмэл хогийн цэг үүсэж болзошгүй нийтийн эзэмшлийн гудамж талбайн 15 байршилд нарны эрчим хүчээр цэнэглэгддэг, өдөр шөнийн бичлэг хийх зөөврийн 15 ширхэг камерыг бүрэн угсран байршуулсан. Хог хаягдлыг ангилан ялгах, тээвэрлэх бага оврын дунд байгууламж барих ажлын хүрээнд 36 дугаар хорооны нутаг дэвсгэр Нарангийн төвлөрсөн хогийн цэгт хог ангилан ялгах үйлдвэрийг барьж дууссан. Үйлдвэрийн дотоод орчинд	70%

	ажлыг зохион байгуулах					суурилуулах тоног төхөөрөмжийн худалдан авах тендерийн ажил зарлагдсан. Дүүргийн хэмжээнд айл өрх, аж ахуйн нэгж байгууллагуудын нийт 263,416 тн хог хаягдлыг ачиж тээвэрлэснээс 26,320 тн буюу (9,9 хувь) ангилсан хог хаягдлыг ачиж тээвэрлэн дахивар авах цэг, дахин боловсруулах болон бордооны үйлдвэрүүдэд хүргэсэн. “Хуванцар хог хаягдлын дахин боловсруулалтын тогтвортой байдлыг хангах төсөл”-тэй хамтран 9 дүгээр хорооны 46 айл өрхөд хог хаягдал ангилан ялгах зориулалтын савыг суурилуулж, 46 айл өрх, 19 аж ахуйн нэгж байгууллагуудын нийт 64,717 тн хог хаягдлыг ачиж тээвэрлэснээс 4194 тн буюу (243 тн хуванцар, гялгар уут, шил лааз, 3951 тн бусад хог хаягдал буюу 6.5 хувь) ангилсан хог хаягдлыг ачиж тээвэрлэсэн.	
8	5.2.3. Хог хаягдлыг тээвэрлэгч байгууллагуудыг зориулалтын машин механизмаар хангаж, хүчин чадлыг нэмэгдүүлэн парк шинэчлэлт хийж, их цэвэрлэгээг зохион байгуулах	-	Парк шинэчлэлт хийх автомашин, тоо	Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хог тээврийн тусгай зориулалтын тоног төхөөрөмжтэй 7 автомашинаар парк шинэчлэлийг нэмэгдүүлсэн.	6	Хог тээврийн байгууллагуудын парк шинэчлэлтийн ажлын хүрээнд шаардлагатай байгаа 46 автомашин, техникийн судалгааг нэгтгэн дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2022 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн 03/756 тоот албан бичгээр нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн. Хог хаягдлыг тээвэрлэх орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудад Швейцарын хөгжлийн агентлагийн санхүүжилтээр “Улаанбаатар хотын ахуйн хог хаягдлын цуглуулалт, тээвэрлэлтийн менежмент”-ийн төслийн хүрээнд Солонгос улсын Хьондэй маркийн тусгай зориулалтын хог тээврийн 2 автомашин, дүүргийн төсвийн 1,4 тэрбум төгрөгийн санхүүжилтээр Оросын холбоот улсын Камаз маркийн тусгай төхөөрөмжит орон сууцны хог хаягдлыг ачих зориулалттай хог тээврийн 1 автомашин, гэр хорооллын хог хаягдлын ачих зориулалттай задгай тэвштэй 3 автомашин нийт 6 хог тээврийн автомашинаар парк шинэчлэлийг нэмэгдүүлсэн.	90%
9	5.2.4. Малын гаралтай хог хаягдлыг ангилах, дахин боловсруулах арга хэмжээг хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллагуудтай	-	Малын гаралтай хог хаягдлын хэмжээ, тн	12150	850	“МСРТ” ХХК, “Эко тайхи” ХХК-тай хамтран Эмээлт дэх мал нядалгааны чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй 12 аж ахуйн нэгж байгууллагуудын малын гаралтай хог хаягдлыг цуглуулж тээвэрлэн 21 дүгээр хорооны нутаг дэвсгэр Барын аманд 5 га талбайд малын өтөг бууц, ялгадсаар компостлох аргаар органик бордоо үйлдвэрлэх төслийг хэрэгжүүлсэн. Тус ажлын хүрээнд мал нядалгааны хагас хуурай 60 тн хог хаягдлыг бактерийн аргаар боловсруулж, 250 м <sup>3</sup> органик бордоог үйлдвэрлэсэн. Дүүргийн 21 дүгээр хорооны мал бүхий 1202 айл өрхүүдээс 4000 тн малын өтөг бууцыг ачиж тээвэрлэн,	100%

	хамтран хэрэгжүүлэх					үйлдвэрлэл явагдаж буй 2,6 га талбайд 20000 м <sup>3</sup> өтөг бууцыг нуруулдах, талбайг тэгшлэх ажлуудыг хийж гүйцэтгэсэн.	
10	5.2.5. Дүүргийн нутаг дэвсгэрт үүссэн хур болон үүсмэл хог хаягдлын цэгийг устгах, бүх нийтийн цэвэрлэгээг ажлыг зохион байгуулах	-	Бүх нийтийн их цэвэрлэгээ зохион байгуулсан тоо	5	2	Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн А/01 тушаал, дүүргийн Засаг даргын А/17, А/183, А/347 А/547 дугаар захирамжаар дүүргийн нутаг дэвсгэрт бүх нийтийн 6 удаагийн их цэвэрлэгээг зохион байгуулсан. Цэвэрлэгээний ажилд давхардсан тоогоор 9074 аж ахуйн нэгж, байгууллага, 19230 иргэд оролцож 1,440,509 м <sup>2</sup> талбайг цэвэрлэн 43 хороонд 72 хог тээврийн автомашин 1026 рейсээр 4719 тн хог хаягдлыг ачиж тээвэрлэн Нарангийн төвлөрсөн хогийн цэгт хүргэсэн. Дүүргийн нутаг дэвсгэрийн гуу жалга, үерийн далан суваг, нийтийн эзэмшлийн зам талбайн хог хаягдлыг цэвэрлэж иргэдийн ая тухтай цэвэр орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албатай хамтран 4 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хог хаягдлын үйлчилгээний байгууллагуудын иргэдийн бүлгийн 36 ажилтанг ажиллуулж, 43 хороодын нутаг дэвсгэрийн ниитийн эзэмшлийн гудамж, гуу жалга, үерийн далан сувгийн 326,500 м <sup>2</sup> талбайн хог хаягдлыг цэвэрлэх ажлыг хийж гүйцэтгэн 22 хорооны нутаг дэвсгэрт үүссэн 65 үүсмэл болон хур хогийн цэгийн судалгааг гаргаж, хог хаягдлын үйлчилгээний байгууллагууд, дотоодын цэргийн 05 дугаар анги, хороодтой хамтран 21 хорооны нутаг дэвсгэрт үүссэн 62 хогийн цэгийн 114700 м <sup>2</sup> талбайг бүрэн цэвэрлэж, 1812 рейсээр 12300 тн хог хаягдлыг тээвэрлэсэн. Жилийн эцсийн байдлаар гэр хорооллоос 25,168 рейсээр 157,567 тн, орон сууцны хорооллоос 10,164 рейсээр 81,679 тн, аж ахуйн нэгж байгууллагаас 5226 рейсээр 14,873 тн, зам талбайгаас 4397 рейсээр 9297 тн нийт 44,955 рейсээр 263,416 тн хог хаягдлыг ачиж тээвэрлэн Нарангийн төвлөрсөн хогийн цэгт хүргэсэн.	100%
11	5.2.6. Зорилтот бүлгийн өрхөд сайжруулсан түлшний дэмжлэг үзүүлэх	189.0 Улсын төсөв	Дэмжлэг үзүүлэх өрх, тоо	3442	1400	Дүүргийн Засаг даргын А/606 дугаар захирамжаар гэр хорооллын 33 хорооны зорилтот бүлгийн 1500 айл өрхөд /өрх тус бүрт 1 тн нийт 1500 тн сайжруулсан шахмал түлшийг улсын төсвийн 189,0 сая төгрөгийн санхүүжилтээр олгосон.	90%
12	5.2.7. Гэр хорооллын айл өрхүүдийн зуух, пийшингийн	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	36 хорооны 29400 өрхийн угаарын хий мэдрэгчийн	100	Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны А/479 дүгээр тушаалаар батлагдсан журмын дагуу агаарын бохирдлын эх үүсвэрийн улсын нэгдсэн тоо бүртгэлийн ажилтай холбогдуулан "Орчны бохирдлын эх үүсвэр, хаягдлын	100%

	<p>аюулгүй ажиллагаа, түүхий нүүрсний хэрэглээ, хог хаягдал шатаахад хяналт тавьж, халаалтын зуухнуудыг үе шаттайгаар төвлөрсөн болон хэсэгчилсэн эх үүсвэрт холбох</p>			<p>хэвийн ажиллагаа, яндан зуухны битүүмжлэлд хяналт тавин, угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх заавар, зөвлөгөө өгч ажилласан.</p>		<p>тоо бүртгэлийн мэдээллийн сан" сэдэвт цахим сургалтыг хороодын зохион байгуулагч нарт 01 дүгээр сарын 05-ны өдөр зохион байгуулсан. Тус ажлын хүрээнд гэр хорооллын 33 хороонд 3-15 кВт хүртэл хүчин чадалтай агаар бохирдуулагч эх үүсвэрийн 59721 айл өрх тоологдож, мэдээллийг нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газарт хүргүүлсэн. Монгол Улсын Засгийн газрын 2018 оны "Түүхий нүүрс хэрэглэхийг хориглох тухай" 62, 2022 оны 223 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Нийслэлийн Засаг даргын А/1025 дугаар, дүүргийн Засаг даргын А/559 дугаар захирамжийн хүрээнд Онцгой байдлын хэлтэс, ОБЕГ-ын харьяа Үндэсний аврах бригад, Таван толгой түлш ХХК, Улаан загалмайн хороотой хамтран Угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх, эрсдэлээс хамгаалах, зуух, яндангийн битүүмжийг шалгах, хөөлөх, сайжруулсан түлшний зөв хэрэглээг иргэдэд сурталчлах, хэрэглээний зөв дадлыг эзэмшүүлэх "Нэгдсэн өдөрлөг"-ийн арга хэмжээг 10 дугаар сарын 12-ны өдөр Хүүхэд залуучуудын театрын гадна талбайд зохион байгуулсан. Тус ажлын хүрээнд стандартын шаардлага хангасан зуухны хэрэглээ, сайжруулсан шахмал түлшний зөв галлагаа, угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх талаар зөвлөмжийг иргэдэд сурталчилж, гэр хорооллын 33 хорооны 1760 аж ахуйн нэгж байгууллага, 58240 айл өрхүүдэд гал түймэр, угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх заавар зөвлөмжийг тараах ажлыг хийж гүйцэтгэсэн. Дүүргийн хэмжээнд сайжруулсан шахмал түлшний 23 саравч, 17 агуулахад нийт 30,967 тонн түлшний нөөцийг бүрдүүлсэн. Гэр хорооллын 33 хороонд сайжруулсан шахмал түлшний 224 жижиглэнгийн борлуулалтын цэг ажиллаж байна.</p>	
13	<p>5.2.8. Гадна орчныг бохирдуулж буй тоосонцорыг бууруулах ажлыг зохион байгуулах</p>	-	<p>Үйлдвэрийн орчны бохирдол, хувь</p>	70	50	<p>Агаарт тоос тоосонцор болон орчны бохирдол үүсгэж буй нөхцөл байдлыг бууруулах ажлын хүрээнд үйлдвэрийн орчинд 3 цехийн 7 шугамын сайжруулсан түлш үйлдвэрлэх бутлуурын төхөөрөмжийн гадуур хамгаалалтын байгууламж барьж, 9 дүгээр сард ашиглалтад оруулсан. Тус битүүмжилсэн хамгаалалтын байгууламжид нэмэлтээр тоос тоосонцорыг сорох төхөөрөмж байршуулах зардлыг 2023 оны төсөвт суулгах саналыг дээд шатны байгууллагад хүргүүлсэн. Түлш үйлдвэрлэх явцад түүхий эдийн илүүдэл хог хаягдал гардаггүй ба үйлдвэрээс гарсан үнс, ахуйн хог хаягдлыг тээвэрлэгч</p>	70%

						байгууллагатай хамтран тухай бүр биокомбинатын төвлөрсөн хогийн цэгт хүргэсэн.	
<b>Хэсгийн дундаж хувь</b>							<b>83.8</b>
<b>Үнэлгээний дундаж хувь:</b>							<b>88.5%</b>

## ХОЁРДУГААР ХЭСЭГ

### ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

№	Дүүргийн Засаг даргын 2020-2024 оны ажиллагааны хөтөлбөр, 2021 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилто т түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
<b>ЗОРИЛГО 6. ИННОВАЦ, ГАРААНЫ БИЗНЕС, ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ДЭМЖИН, ХӨДӨӨ АЖ АХУЙН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛ, БОРЛУУЛАЛТЫН СҮЛЖЭЭГ ХӨГЖҮҮЛЖ, ИРГЭДИЙГ БАТАЛГААТ ХҮНСЭЭР ХАНГАНА.</b>							
<b>Зорилт 6.1. Өрхийн үйлдвэрлэл, жижиг бизнес, эрхлэгч, гар урлаачдыг дэмжих төвийг бүс бүрт байгуулна.</b>							
1	6.1.1. Төв, баянхошуу бүсэд байгуулагдсан хөгжлийн төвийг түшиглэн жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ	-	Дэмжлэг үзүүлсэн үйлдвэрлэгч, тоо, сургалтад	16, 437	30, 450	“Инвескор” ББСБ-ын “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих” сарын 0.4%-ийн хүүтэй төслийн зээлд 10 үйлдвэр эрхлэгч 243.0 сая, Богд банкны сарын 1.8%-ийн хүүтэй бизнесийн зээлд 1 үйлдвэр эрхлэгч 10.0 сая, “Очир Ундраа” ББСБ-ийн сарын 2%-ийн хүүтэй, зээлийн шимтгэлгүй, барьцаагүй	100%

	эрхлэгчдэд тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлэх холбон зуучлах, холбогдох сургалтыг зохион байгуулах		хамрагдах иргэн, ААН, тоо			бизнесийн зээлд 1 үйлдвэр эрхлэгч 10.0 сая, оёдлын бизнес эрхлэгчдэд зориулсан жилийн 3-4%-ийн хүүтэй, 24-36 сарын хугацаатай оёдлын багц тоног төхөөрөмжийн зээлд 5 үйлдвэр эрхлэгч 60 сая, нийт 17 бизнес эрхлэгч 323 сая төгрөгийн зээлийг авсан. Азийн хөгжлийн банкнаас хэрэгжүүлж буй "Ковид-19 цар тахлын үед Улаанбаатар хотын гэр хорооллын БЖДҮ эрхлэгчдийг дэмжих нь" тоног төхөөрөмжийн буцалтгүй тусламжийн дэмжлэгт зорилтод хорооны 29 оёдлын үйлдвэр эрхлэгч, 12 бусад чиглэлийн үйлдвэр эрхлэгч, "КОВИД-19 цар тахлын нөлөөг олон нийтийн оролцоотой бууруулах нь" төсөл хөтөлбөрт 4 иргэн, нийт 45 үйлдвэр эрхлэгч 188.4 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн буцалтгүй тусламжид хамрагдсан. Төслийн захиалгат болон мэргэжлийн ур чадвар олгох, хөгжүүлэх, туршлага судлах 47 удаагийн сургалтад танхимаар 861, цахимаар 90, нийт 951 үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчийг хамруулж, ажлын байран дээрх болон цахимаар зөвлөн туслах, мэдээ, мэдээллээр хангах үйлчилгээг нийт 1023 жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд үзүүлж ажилласан.	
2	6.1.2. Үйлдвэрлэл эрхлэгчдийг гадаад дотоодын үзэсгэлэн худалдаанд оролцуулах, зохион байгуулах	4.0 Дүүргийн төсөв	Хамрагдах ААН, иргэн, тоо	107	150	"Цагаан сар", "Их хотын хавар-2022" задгай талбайн үзэсгэлэн худалдаанд дүүргийн 16 үйлдвэр эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж оролцож 17.2 сая төгрөгийн борлуулалт хийн, 20-30 хэрэглэгчээс захиалга авсан байна. "Мишээл" олон улсын худалдааны танхим, Худалдаа Аж Үйлдвэрийн танхим, Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд зохион байгуулагдсан "ЖДҮ бүтээгдэхүүн үйлчилгээ технологи-2022" "Жаргалтай инээмсэглэл"8 "Golden week Монгол-Японы Бизнес экспо" үзэсгэлэн худалдаанд 12 үйлдвэр эрхлэгч оролцож 3.1 төгрөгийн борлуулалтыг тус тус хийсэн. "Их хотын бүсгүйчүүд", Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр Сүхбаатарын талбай, Хүүхэд залуучуудын театрын гадна талбайд зохион байгуулсан худалдаа үйлчилгээ, "Авто машингүй өдөр" арга хэмжээнд 17 нийт 170 үйлдвэр эрхлэгч хамрагдаж, 20.4 сая төгрөгийн борлуулалт хийсэн байна. Мөн "Сонгинохайрханд үйлдвэрлэв" амралтын өдрийн үзэсгэлэн худалдаанд 15, "Жижиг, дунд үйлдвэрийн өдөр-2022" үзэсгэлэн худалдаанд 16 үйлдвэр эрхлэгч, "Дээлтэй Монгол" наадмын үзэсгэлэн худалдаанд 8 үйлдвэр эрхлэгч, "Даншиг наадам-Хүрээ цам 2022" шашин	100%

					соёлын наадмын үзэсгэлэн худалдаанд 4 бизнес эрхлэгч, АНУ-д зохион байгуулагдсан “Монголын худалдаа, хөрөнгө оруулалт, өв соёлын чуулган 2022” арга хэмжээнд 1, СХД-ийн ЖДҮү эрхлэгчдийг олон нийтэд таниулах төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааг сайжруулах зорилготой Сүхбаатарын талбайд зохион байгуулагдсан “Сонгинохайрханы гоёл-2022” үзэсгэлэн худалдаанд 25 үйлдвэр эрхлэгч, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын “Эко Монголиа-2022” үзэсгэлэн яармагт 6 үйлдвэр эрхлэгч, ЖДҮ эрхлэгчдийн “DAYs4SME EXPO-2022” үзэсгэлэн худалдаанд 12 үйлдвэр эрхлэгч оролцож 17,4 сая төгрөгийн, “Уламжлалт гар урлалыг дэмжих хөгжүүлэх боломж, шийдэл-2022” хэлэлцүүлэг форумд 33 урлаач оролцож 2,4 сая төгрөгийн борлуулалт хийж, Нийт 17 удаагийн үзэсгэлэнд 166 үйлдвэр эрхлэгч хамрагдаж, 133 сая төгрөгийн борлуулалтыг хийсэн байна.		
3	6.1.3. Цахим орчинд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүнийг сурталчлах, борлуулах, бүтээгдэхүүн хөгжүүлэлтэд дэмжлэг үзүүлэх	2.5 Дүүргийн төсөв	Хамрагдах ААН, иргэн, тоо	45	112	6.1.3.Бараа бүтээгдэхүүний борлуулалтыг дэмжин ажиллах зорилтын хүрээнд: “Алунгоо фэйшн” ХХК, “Шилмэл дизайн” ХХК, “Хос учиг” ХХК, “Дү Дү кидс” зэрэг өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүний борлуулалтыг дэмжин “Ари Жасмин” цахим хуудсаар сурталчилж 22,8 сая төгрөгийн борлуулалт хийсэн. Байгууллагын “Сонгинохайрханд үйлдвэрлэв” цахим хуудсаар 23 үйлдвэр эрхлэгчдийн мэдээлэл бүхий 24 зурган болон видео танилцуулгыг олон нийтэд таниулан сурталчилсан. Бүтээгдэхүүн хөгжүүлэлтэд дэмжлэг үзүүлэх ажлын хүрээнд: -“Сонгинохайрхан дүүргийн жижиг, дунд үйлдвэр эрхлэгч эмэгтэйчүүдийг хөгжүүлэх бичил төсөл”-ийг хэрэгжүүлж, 20 бизнес эрхлэгчийг хамруулан, чадавхжуулах сургалтыг 8 удаа зохион байгууллаа. “Сэцэн фэйшн” ХХК-тай хамтран “Шилмэл дизайн” ХХК-ийн бараа бүтээгдэхүүний чанар, борлуулалтыг сайжруулахад зөвлөн тусалж, бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлж шинэ загварын бүтээгдэхүүн гаргахад дэмжлэг үзүүлсэн. -“Сав баглаа боодлын стандартыг мөрдүүлэх, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийн бүтээгдэхүүний сав, баглаа боодлыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх” хөтөлбөрийн хүрээнд	100%

						Дүүргийн Засаг даргын А/537 дугаар захирамжаар дүүргийн Хүнс худалдаа, үйлчилгээний хэлтэс, Улаанбаатар хотын Худалдааны Танхим хамтран 29 үйлдвэр эрхлэгчдэд “Сав баглаа боодол, түүнд тавигдах шаардлага, бүтээгдэхүүн хөгжүүлэлт” сэдэвт сургалт зохион байгуулсан, Захирамжийн дагуу Ц.Болормаагийн үйлдвэрлэлийн “Солонго” кимчи бүтээгдэхүүний сав баглаа боодлын загварыг шинэчлэн, эх бэлтгэлийг хэвлэлтэнд, “Канаан ланд” ХХКомпаний 6 төрлийн бүтээгдэхүүний сав, баглаа боодол, шошгоны загварыг шинэчлэн боловсруулж, 1460 ширхэгийг хэвлүүлж өгсөн.	
4	6.1.4. Үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийг кластераар хөгжүүлэх, туршлага судлуулах	0.5 Дүүргийн төсөв	Хамрагдах ААН, иргэн, тоо	28	50	Дүүргийн оёдлын үйлдвэрлэл эрхлэгчдийг кластераар хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, баг хамтын ажиллагааны үр шимийг таниулах туршлага солилцох, автобус доторх сургалт бүхий бизнес аяллыг 40 оёдлын үйлдвэр эрхлэгч 4 сургагч багшийн бүрэлдэхүүнтэй зохион байгууллаа. Кластерийн системээр ажиллах хүсэлтэй оёмол бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийг “Шилмэл дизайн”, “Цагаан шонхор” зэрэг оёдлын үйлдвэрүүдийн үйл ажиллагаатай танилцуулсан. Үндэсний тэргүүлэгч үйлдвэр “Грийн групп”-тэй танилцаж туршлага судлах, хамтран ажиллах боломжийг эрэлхийлсэн танилцах бизнес аяллыг зохион байгуулж 65 үйлдвэр эрхлэгчийг хамруулсан. Дүүргийн 11 өрхийн оёдлын үйлдвэр “Шилмэл дизайн” ХХК-тай холбон кластераар ажиллуулж байна.	100%
4	6.1.5. Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа худалдаа, үйлдвэрлэл үйлчилгээний аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд хууль, журам, стандартыг мөрдүүлэх чиглэлээр зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх, аттестатчилах	7.0 Дүүргийн төсөв	Хамрагдах ААН, иргэн, тоо	600	300	Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2022 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн А/79 дүгээр тушаалаар баталсан “Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй газруудад аттестатчиллын шалгалт явуулах тухай” удирдамжийн дагуу холбогдох хууль тогтоомж, стандартын хэрэгжилтийг хангуулах чиглэлээр аттестатчиллын шалгалтыг явуулсан. Аттестатчиллыг Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс, Тохижилт нийтийн аж ахуйн хэлтэс, Онцгой байдлын хэлтэс, Цагдаагийн хэлтэс хамтран худалдааны чиглэлийн 216, хоол үйлдвэрлэлийн 70 аж ахуйн нэгжүүдийг хамруулж, 2022 оны 5 дугаар сарын 25-ны өдрөөс 7 дугаар сарын 09, 10 дугаар сарын 01-нээс 10 дугаар сарын 30-ны өдрүүдэд 2 үе шаттай явуулсан. Шалгалтад хамрагдсан аж ахуйн нэгж байгууллагууд гэрээт	100%



						байгууллагуудаар сард 1 удаа, өдөр тутмын ариутгалын бодист цэвэрлэгээг тогтмол хийж хэвшсэн. 42 байгууллага үл хөдлөх эд хөрөнгийн зориулалт өөрчлүүлэхээр хүсэлт гаргаж шийдвэрлүүлсэн. Аж ахуйн нэгж байгууллагууд гадна, дотор камержуулалтыг хангалттай түвшинд хийсэн байна. Аттестатчилалд хамрагдаж, холбогдох хууль тогтоомж, стандартын шаардлагыг хангасан худалдааны 182, ресторан-24, баар-37, кафе-4 аж ахуйн нэгжийн зөвшөөрлийн хугацааг сунгах, нэр шилжүүлсэн-2, үйл ажиллагаагаа бүрмөсөн зогсоосон-23, стандартын болон бусад тавигдах шаардлагыг хангаагүй-8, үйл ажиллагааны чиглэлээ өөрчилсөн-6 аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийн эрхийг хүчингүй болгох саналыг УБЗАА-ны ХХААХҮХҮХ-т хүргүүлж шийдвэрлүүлсэн.	
6	6.1.6. Худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгжүүдэд зориулсан хууль, тогтоомж, стандартын сургалтыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулж, мэдээ мэдээллээр хангаж ажиллах	7.0 Дүүргийн төсөв	Хамрагдах ААН, иргэн, тоо	Худалдаа үйлчилгээг зохицуулах зөвлөл “Худалдаа, үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх гэрээ”-г 436 иргэн, аж ахуйн нэгжтэй байгуулан, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа.	300	Sevice.ulaanbaatar.mn сайтын Онлайн бизнес төв цахим хуудсанд хүсэлт илгээх зааварчилгаа, мэргэжил арга зүйгээр хангах чиглэлээр худалдаа үйлчилгээний 600 гаруй аж ахуйн нэгжүүдэд 16 удаагийн давтамжтайгаар Мэргэжлийн хяналтын хэлтэс, Онцгой байдлын хэлтэс, Цагдаагийн газартай хамтран сургалт зохион байгуулж, мэдээлэл хүргэлээ. Сургалтанд худалдааны 424, хоол үйлдвэрлэл, ахуйн үйлчилгээ, авто үйлчилгээний 176 аж ахуйн нэгж хамрагдсан. Цахим системд 2022 оны жилийн эцсийн байдлаар 1307 иргэн, аж ахуйн нэгж хүсэлт ирүүлснийг хянаж үзэн 1088 аж ахуйн нэгж бүртэгсэн. Мэдээлэл алдаатай, давхардаж ирүүлсэн зэрэг 219 аж ахуйн нэгж иргэний хүсэлт зөрчилтэй байсан тул буцааж, татгалзаж шийдвэрлэсэн байна. Дүүргийн Засаг даргын 2022 оны А/94 дугаар захирамжийн хүрээнд “Хүүхэд-Эрхэм хэрэглэгч” сэдэвт сургалт зохион байгуулж, ЕБС орчимд үйл ажиллагаа явуулж буй худалдааны 104 аж ахуйн нэгж, ЕБС-ийн 30 Нийгмийн ажилтнуудыг хамруулан, “Электрон тамхинаас татгалзах шалтгаан”, “Электрон тамхины хор уршиг” сэдвүүдээр мэдээлэл өгч, санал бодлоо солилцлоо. Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа 58 үсчин, гоо сайханчдыг хамруулсан “Хувь хүний хөгжил, харилцаа хандлага”, “ESTEL” брэнд сэдвүүдээр сургалт зохион байгуулж, гоо сайхны салбарт баримталж буй стандарт	100%

					<p>шаардлага, нэгдсэн мэдлэг, мэдээллийг хүргэлээ. “ЕБС, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний эрүүл ахуйн менежмент, хүнсний аюулгүй байдлын менежментийн тогтолцоо” сэдэвт сургалтад сургууль, цэцэрлэгийн 34 нярав, тогооч нарыг хамруулж, “Хүүхдийн хоолны жор технологи” ном, гарын авлагаар хангасан. Худалдаа үйлчилгээний байгууллагуудын дагаж мөрдөх журам, гадна, дотор орчны тохижилт, ерөнхий шаардлага, стандартыг сурталчилах, танилцуулах сургалтыг Хотын стандарт хяналтын газартай хамтран 126 худалдаа, хоол үйлдвэрлэлийн газруудыг хамруулан явуулж, мэдээллээр хангасан.</p> <p>Эрүүл мэндийн яам, Захирагчийн ажлын албатай хамтран “Коронавируст (ковид-19)” халдвар, хоол хүнсээр дамжихаас сэргийлэх” сургалтыг зохион байгуулж, Хоол үйлдвэрлэлийн салбарын 7 аж ахуйн нэгж байгууллагын менежер, зохион байгуулагч нар хамруулсан. Сургалтад оролцогчдод Эрүүл мэндийн яамны Нийтийн эрүүл мэндийн газраас сертификат олгосон. “Нийслэлийн нутаг дэвсгэрт худалдаа үйлчилгээ эрхлэх нийтлэг журам”, дүүргийн Засаг даргын 2022 оны А/619 дүгээр захирамжийн хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд тус дүүргийн Худалдаа үйлчилгээг зохицуулах зөвлөл, 12-18, 29 дүгээр хороодын Засаг дарга нар ЭТӨЧ дэх төв зам дагуу Түргэн үйлчилгээний цэгийн үйл ажиллагаа явуулж буй 82 иргэнтэй 2022 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр уулзалт хийж мэдээлэл өгсөн. Улаанбаатар хотын түгжрэлийг бууруулах ажлын хүрээнд Сонгинохайрхан дүүргийн нутаг дэвсгэрт Саппоро үйлчилгээний төвөөс 5 шарын автобусны буудлын чиглэлд “Дугуйн зам багц-2” төлөвлөгөөт ажил хийгдэхтэй холбогдуулан уг байршилд байгаа 82 ТҮЦ эрхлэгчидтэй 2023 оны 4 дүгээр сарын 01-нийг хүртэлх хугацаагаар, зөвшөөрөгдсөн байршилд байршсан ТҮЦ-ийн эзэдтэй 1 жилийн хугацаагаар гэрээ байгуулсан.</p>		
7	6.1.7. Салбарын аж ахуйн нэгжүүдийн дунд мэргэжлийн аварга шалгаруулах уралдаан тэмцээн,	9.5 Дүүргийн төсөв	Хамрагдах ААН, иргэн, тоо	11 удаагийн онлайн сургалтад 230, 10 удаагийн танхимын	80	Нийслэлийн Аялал жуулчлалын газар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албатай хамтран Монгол хоолны соёлыг гадаадын жуулчдад таниулах, бусад улсын хоолны соёлыг түгээх, иргэдийн эрүүл зөв хоололтын талаарх ойлголтыг дээшлүүлэх зорилгоор “Улаанбаатар үндэсний хоолны	100%

	өдөрлөг зохион байгуулах			сургалтад 207, нийт 437 үйлдвэрлэл эрхлэгчдийг хамруулсан.		өдөрлөг"-ийг 2022 оны 8 дугаар сарын 21-ний өдөр Сүхбаатарын талбай дээр зохион байгуулсан. Өдөрлөгт Сонгинохайрхан дүүргийн нутаг дэвсгэрт хоол үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 2 аж ахуйн нэгж, Street food буюу гудамжны хоолны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 2 иргэн хамрагдсан. Дүүргийн Засаг даргын 2022 оны А/673 дугаар захирамжийн дагуу худалдаа, үйлчилгээний нийт 169 аж ахуйн нэгжийн гар бөмбөгийн 20 баг, дартсын 14 багийн дунд спортын нөхөрсөг тэмцээнийг 11 дүгээр сарын 22-ны өдөр зохион байгуулав. Тэмцээний үеэр Үндэсний үйлдвэрлэгч байгууллагуудын бараа бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдаа зохион байгуулав. Үзэсгэлэнд: "Сүү" ХК, "Айсмарк" ХХК, "Хос ивээл" ХХК, "Милко" ХХК, "Арвайн үндэс" ХХК, "Жем интернэшнл" ХХК-иуд оролцлоо. Хүнс худалдаа үйлчилгээний хэлтсээс Онлайн бизнес төвийн мэдээллийн санд бүртгэл хийн, Нийслэлийн нутаг дэвсгэрт худалдаа үйлчилгээ эрхлэх нийтлэг журмын танилцуулга хийж гарын авлага материалаар хангаж ажиллав.	
8	6.1.8. Худалдааны стандарт шаардлагад нийцсэн "Ая тухтай" дэлгүүрийн сүлжээг нэмэгдүүлэх	20.0 Дүүргийн төсөв	Хамрагдах ААН, иргэн, тоо	0	10	6.1.8. Дүүргийн нутаг дэвсгэрт Ая тухтай сүлжээ дэлгүүрийг хөгжүүлэх зорилгоор 5 аж ахуйн нэгжийг сонгон МОРА ТББ-тай хамтран ажиллаж байна. Эхний удаад 24-р хорооны "Шармал зоос" ХХК-ийг "Жишиг" сүлжээ дэлгүүр болгон, стандартын шаардлагад нийцүүлэн зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж, үнэлгээ хийлгэн тохижуулах ажлуудыг хийж байна. ХХААХҮЯ, Монголын Худалдаа аж үйлдвэрийн танхим, холбогдох мэргэжлийн байгууллагууд, МОРА ТББ хамтран ая тухтай сүлжээ дэлгүүрийн стандартыг танилцуулах, цаашид хэрэгжүүлэх чиглэлээр 2022 оны 11-р сарын 22-нд хэлэлцүүлэг хийсэн. Уг хэлэлцүүлэгт цаашид ая тухтай сүлжээ болж өргөжих боломжтой 15 аж ахуйн нэгжийг оролцуулсан. 2022 онд шинээр GS-25 сүлжээ-4, СУ сүлжээ-6 нэмэгдсэн байна. Үндэсний сүлжээ-1 байгуулагдсан ба нийт ая тухтай сүлжээ дэлгүүр 20 болж өргөжсөн байна.	100%
9	6.1.9. Нөөцийн махны нөөц бүрдүүлэлт, хадгалалтад хяналт тавьж, жижиглэн болон өргөтгөсөн	2.5 Дүүргийн төсөв	Борлуулалтын цэг, тоо	100	110	Нөөцийн махны өргөтгөсөн худалдааг 43 хорооны нутаг дэвсгэрт зохион байгуулж, үхрийн 18.5 тн, хонины 148.3 тн, ямааны 6.1 тн нийт 173.1 тн дүүргийн хэмжээнд жижиглэн болон өргөтгөсөн худалдаагаар 513.9 тн мах худалдан борлуулсан байна.	100%

	хэлбэрээр худалдан борлуулах ажлыг зохион байгуулах					<p>Нөөцийн махны хаягийг нэгдсэн журмаар 1 загвараар хэвлүүлэн тараасан. Бэлтгэн нийлүүлж буй компаниуд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1."Мах импекс" ХК</li> <li>2."Агро нэгтгэл трейд" ХХК</li> <li>3."ХКҮ" ХХК</li> <li>4."Жавхлант дэлгэр хангай" ХХК</li> <li>5."Дэлхийн хүнс" ХХК</li> <li>6."Цэц манхан" ХХК</li> <li>7."Эрдэнэт мах маркет" ХХК</li> <li>8."Дархан мийт фүүдс" ХХК</li> </ol> <p>Нөөцийн махны жижиглэнгийн худалдааны 104 цэгээр 1821 удаагийн татан авалтаар үхрийн 181.5тн, хонины 143.4тн, ямааны 16.5тн нийт 341.1тн мах худалдан борлуулсан. Дүн мэдээг нэгтгэн 7 хоногийн Пүрэв гарагт УБЗАА-ны ХХААХҮХҮХ-т хүргүүлж, мэдээллээр ханган ажилласан.</p> <p>Дүүргийн нутаг дэвсгэрт нөөцийн мах худалдан борлуулах 43 хорооны 104 хүнсний дэлгүүр, бэлтгэн нийлүүлэгч 8 компанитай агентын гэрээ байгуулан, зөвлөн туслах үйлчилгээг үзүүлж ажиллалаа. Бэлтгэн нийлүүлж буй компаниуд нөөцийн махны жижиглэнгийн худалдаанд 1821 удаагийн татан авалтаар үхрийн 181.5 тн, хонины 143.4 тн, ямааны 16.5 тн нийт 341.1 тн мах худалдан борлуулсан.</p>	
<b>Хэсгийн дундаж хувь</b>							<b>100%</b>
<b>ИРГЭНД ЧИГЛЭСЭН ҮЙЛЧИЛГЭЭ:</b>							
<b>ЗОРИЛГО 7. ДҮҮРГИЙН ХҮН АМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙГ ХАЛДВАРТ БОЛОН ХАЛДВАРТ БУС ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ДЭД ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ, ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН УР ЧАДВАРЫГ ДЭЭШЛҮҮЛНЭ.</b>							
<b>Зорилт 7.1. Эмнэлгүүдийг оношлогоо, эмчилгээний орчин үеийн тоног төхөөрөмжөөр хангах, барилга, байгууламжийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулна.</b>							
1	7.1.1. Эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг төгсөлтийн дараах болон мэргэшүүлэх сургалтад хамруулах, дэмжлэг үзүүлэх, нийгмийн баталгааг хангах арга хэмжээг авч хэрэгжүүлэх	30.0 Дүүргийн төсөв	Батлуулах төсөл, тоо	Албан хаагчдын нийгмийн баталгааг хангахад зориулж 5.4 тэрбум төгрөгийг олгосон	Эмч, эмнэлгийн ажилтнуудыг төсөлд хамруулах	2022 онд үндсэн мэргэжлийн төрийн сангийн тэтгэлэгээр 5 эмч, үндсэн мэргэжлийг байгууллагын зардлаар 1 эмч, төрөлжсөн мэргэжлийн хувийн зардлаар 2 эмч, төрөлжсөн мэргэжлийн төрийн сангийн зардлаар 5 сувилагч, төрөлжсөн мэргэжлийн байгууллагын зардлаар 2 лаборант нийт 13 мэргэжилтэн мэс засал, уушиг судлал, тархины судасны хэт авиа оношилгоо, зүрхний бичлэг хэт авиан оношилгоо, хүүхэд, мэдээгүйжүүлэг, эх барих эмэгтэйчүүд, гэмтэл, дуран диализийн чиглэлээр төгсөлтийн дараах мэргэшүүлэх сургалтад хамрагдаж байна. Сургалтад хамрагдаж байгаа эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд	100%

						цалинтай чөлөө олгож, төрийн сангийн болон сургалтын төлбөрийн дэмжлэгийг үзүүлсэн. Дүүргийн Эрүүл мэндийн төв, Нэгдсэн эмнэлэг, өрхийн эрүүл мэндийн төвийн 10 сувилагчийн нийгмийн асуудлыг шийдвэрлэж 32 дугаар хороо “Бичигт 52” нэртэй газарт гэр бүлийн зориулалтаар газар олгож, гэрчилгээг гардуулаад байна. Эрүүл мэндийн байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтэн нийт 395 ажилтны гэр бүлийн хэрэгцээнд зориулж газар олгуулах асуудлыг шийдвэрлүүлэхээр Газар зохион байгуулалтын албанд 01/387 дугаар албан бичгээр хүсэлтийг хүргүүлсэн. Дүүргийн Эрүүл мэндийн төв эрүүл мэндийн салбарын ажилтны нийгмийн баталгааг хангах сарын ажлын хүрээнд орон сууцны урьдчилгаа 30 сая төгрөг 10, ипотекийн зээлийн дэмжлэг 20 сая төгрөг 15, гэр 10 ажилтанд олгож нийгмийн асуудлыг шийдвэрлэсэн ба цалинг 10%-иар нэмэгдүүлэн нийт 980 сая төгрөгийг зарцуулаад байна. Нэгдсэн эмнэлэг нийт 396 ажилтнууддаа 300,000-15 сая төгрөгийн мөнгөн тусламжийг олгосон ба ажилтнуудын ажиллах нөхцөлийг хангах зорилгоор хуучин барилгын нэг хэсгийг хүүхдийн цэцэрлэгийн зориулалтаар засварлаж, тохижуулахаар тендер зарлагдаад байна	
2	7.1.2. Эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилгыг ашиглалтад оруулж, үйл ажиллагааг жигдрүүлэх	500.0 Улсын төсөв	Барилгын ажлын явц, хувь	90	100	2022 онд улсын төсвөөс 1.4 тэрбум төгрөгийн нэмэлт санхүүжилтийн асуудал шийдэгдэж, барилгын үндсэн ажлууд дуусаж Улсын комисс ажилласан ба 12 дугаар сарын 15-ны өдөр үйл ажиллагааг нээхээр төлөвлөөд байна.	100%
3	7.1.3. Нэгдсэн эмнэлгийн тусламж үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх, өдрийн эмчилгээг өргөжүүлэх	-	Эмчилгээний нэр төрөл, тоо	4	4	Дүүргийн Нэгдсэн эмнэлгийн тусламж үйлчилгээнд 5 төрлийн тусламж үйлчилгээг нэмэгдүүлээд байна. Үүнд: “Сэргээн засах, уламжлалтын өдрийн эмчилгээ”, Мамаграфия, СТ тодосгогчтой, Судасны мэс засал, Эмгэг судлалын тусламж үйлчилгээ багтаж, 3 дугаар шатлалын тусламж үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна.	100%
4	7.1.4. “Эрүүл мэндийг дэмжих төв”-ийн тоног төхөөрөмж суурилуулах ажлыг зохион байгуулж, үйл ажиллагааг эхлүүлэх	3,100.0 Улсын төсөв	Үйлчилгээний нэр төрөл, тоо	Улсын төсвийн хөрөнгөөс 2.1 тэрбум төгрөг батлагдаж төвийн байрыг 228.0 сая	10	Нэгдсэн эмнэлэг, Эрүүл мэндийн төвийн “Эрүүл мэндийг дэмжих” төвд 32 төрлийн (зүрхний ачаалалтай бичлэгийн аппарат, биеийн жингийн найрлага, дуран, тархины цахилгаан бичлэг, шүдний ком, ЭКГ, ЭХО, Рентген, Инбоди аппарат гэх мэт) тоног төхөөрөмж суурьлуулж 2022 оны 5 дугаар сарын 01-ний өдрөөс үйл ажиллагааг эхлүүлсэн ба	100%

				төгрөгөөр засварлаж дууссан.		Эрүүл мэндийн төвийн салбар 3 дугаар амбулаторид “Эрүүл мэндийг дэмжих төв”-ийг шинээр байгуулж, 12 дугаар сарын 05-ны өдрөөс үйл ажиллагааг эхлүүлэхээр ажиллаж байна.2022 оны байдлаар нийт 7800 гаруй хүнд үзлэг, оношлогоо хийгээд байна.	
5	7.1.5. Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн магадлан итгэмжлэлд бүрэн хамруулах, шинэ хороодод өрхийн эрүүл мэндийн төвүүдийн салбар нээх ажлыг зохион байгуулах	84.0 Дүүргийн төсөв	Салбар эмнэлэг, тоо	4	8	Дүүргийн 33, 34, 35, 37, 38 дугаар хороодын өрхийн эрүүл мэндийн төвийг шинээр байгуулж, үйл ажиллагааг эхлүүлсэн. 33, 34, 37, 38 дугаар хороод түрээсийн байранд, 35 дугаар хороо шинэ баригдсан барилгад үйл ажиллагааг хэвийн явуулж байгаа ба 33, 34, 35, 36, 37, 38, 40, 41, 42 дугаар хорооны өрхийн эрүүл мэндийн төв тусдаа байртай болж түрээсийн төлбөрийг Засаг даргын Тамгын газраас төлж байна. Өрхийн эрүүл мэндийн төвүүд магадлан итгэмжлэлд хамрагдаж, эмнэлгийн тусламж үйлчилгээний нэр төрөл нэмэгдэж байгаатай холбогдуулан 6 автомашин, 1 рентген аппарат, 4 эхо аппарат, 5 хүчилтөрөгч өтгөрүүлэгч, 10 хяналтын монитор, 1 шарлагын аппарат, 1 ургын билимитр, 17 гематологийн аппаратаар тоног төхөөрөмжөө нэмэгдүүлсэн ба Монпен төслийн хүрээнд шээсний анализатор, даралтны аппарат, танита аппарат зэрэг 10 нэр төрлийн оношлогооны багажуудыг ӨЭМТ-үүдэд хүлээлгэж өгөөд байна. 10 өрхийн эрүүл мэндийн магадлан итгэмжлэлийн шалгалтаар орж 2-3 жилээр сунгагдаж зөвшөөрлөө авснаар бүх эмнэлгүүд эрүүл мэндийн даатгалаар эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх боломжтой болсон.	100%
6	7.1.6. Ураг, нярайн эндэгдлийг бууруулах нярайн шарлалтын аппарат, ургийн гажиг оношлох ЭХО аппаратаар хангах ажлыг зохион байгуулах	170.0 Дүүргийн төсөв	Тоног төхөөрөмж, тоо	0	2	Дүүргийн 28 дугаар хорооны “Арвин мэнд” өрхийн эрүүл мэндийн төвийг нярайн шарлалт хэмжих “Билиметр” аппаратаар хангах ажлыг хувийн хэвшлийн байгууллагатай хамтран зохион байгуулж, 4 өрхийн эрүүл мэндийн төвд зөөврийн ЭХО аппаратыг олгоод байна. Ургын гажиг оношлох ЭХО аппарат худалдан авах үнэлгээний хороог дүүргийн Засаг даргын 2022 оны А/596 дугаар захирамжаар байгуулж, төндэрийг зарлан худалдан авах үйл ажиллагааг зохион байгуулж 122 сая төгрөгийн өртөг бүхий аппаратыг дүүргийн Эрүүл мэндийн төвд хүлээлгэж өглөө. Эрүүл мэндийн байгууллагуудад шаардлагатай тоног төхөөрөмжийн судалгааг гаргасан ба холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлсэн.	100%

**Зорилт 7.2. Халдварт бус өвчний эрт илрүүлгийг нэмэгдүүлж, сэтгэц, донтолтын эмгэгээс урьдчилан сэргийлэх зорилгоор “Нийгмийн эрүүл мэндийг дэмжих” дэд хөтөлбөрийг батлуулж, хэрэгжүүлнэ.**

7	7.2.1. “Нийгмийн эрүүл мэндийг дэмжих” төслийн 2022 оны төлөвлөгөөг боловсруулж, батлуулах, эрүүл мэндийн нийгмийн ажилтнуудыг тусгай хөтөлбөрөөр мэргэшүүлэх ажлыг зохион байгуулах	20.0 Дүүргийн төсөв	Төлөвлөгөөний хэрэгжилт, хувь	Төслийн 1, 2-р зорилтын хүрээнд урьдчилан сэргийлэх үзлэг 171,141 иргэнийг хамруулж, 378 хорт хавдрыг оношилсон.	100	2022 онд халдварт бус өвчний чиглэлээр 839 танхимийн сургалтад 35,810 хүнийг, 1689 цахим сургалтад 149,954 хүнийг хамруулсан байна. “Эрүүл Сонгинохайрханчууд” 3 сарын аяныг зохион байгууллаа. “Дэлхийн сонсгол хамгаалах өдөр”, “Дэлхийн сүрьеэтэй тэмцэх өдөр”, “Дэлхийн амны хөндийн өдөр”, “Сонсголоо хайрлах өдөр” сэдэвт өдөрлөг, “Автомашингүй өдөр”, “Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хамгаалах өдөр”, “Эрсдлийг бууруулж, маскаа зүүцгээе”, “Оюутныг дэмжих сар” зэрэг аян уулзалт, сургалтын арга хэмжээг 671 удаа цахимаар, 357 удаа танхимаар явуулж 57,814 хүнд мэдээлэл хүргэсэн. Артерийн гипертенз, чихрийн шижин өвчний эрт илрүүлгийн үзлэгт 18-аас дээш насны 224,032 зорилтот бүлгийн хүн хамрагдахаас артерийн гипертензийн үзлэгт 88477 буюу 39,1%, чихрийн шижингийн үзлэгт 74169 буюу 33,1% хамрагдаж, нийт 858 өвчлөл оношлогдон батлагдаж, эмчийн хяналтанд эмчлэгдэж байна. Хүүхдийн хавдрын өвчлөл, бүх төрлийн хавдрын өвчлөлийн шалтгаан нөхцөлийг тодорхойлох судалгааны ажлыг зохион байгуулж, хавдраар өвдсөн 45 хүүхдийн эцэг, эхтэй биечлэн уулзаж, зөвлөгөө мэдээлэл хүргэн ажилласан ба хавдрын эрт илрүүлэг, үзлэгийг 27 удаа зохион байгуулж 1815 иргэнийг хамруулсан. Эрүүл мэндийн нийгмийн ажилтнуудыг чадавхжуулах, сургалт зохион байгуулах, судалгаа хийх чадвартай болгох зорилгоор өглөөний уулзалтыг 4 удаа зохион байгууллаа. Уулзалтаар олгосон мэдлэгийн хүрээнд өрхийн эрүүл мэндийн төв бүрт өвчлөлийн судалгааг 5 жилийн байдлаар хийлгэж, дүгнэлт гаргуулан, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч, хороодын Засаг дарга нийт 60 гаруй удирдлагуудыг мэдээллээр хангасан. Эрүүл мэндийн байгууллагын ажилтнуудын ёс зүй, харилцаа хандлагыг сайжруулах зорилгоор сургалт зохион байгуулж 298 ажилтанд кридит олголоо. Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн асуудал, өсвөр насны хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах ажлын хүрээнд “Зөв өглөө” уулзалтыг зохион байгуулж, ахлах ангийн 40 хөвгүүд, ээлжийн буюу суугаа ажилтай 200	90%
---	--	------------------------	-------------------------------	--	-----	---	-----

						залууд эрүүл мэндийн боловсрол олгох ажлыг зохион байгуулсан.	
8	7.2.2. “Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх” төслийн 2022 төлөвлөгөөг боловсруулж, батлуулан, хэрэгжилтийг хангах	50.0 Дүүргийн төсөв	Төлөвлөгөөний хэрэгжилт, хувь	Танхимаар 80, цахимаар 254 удаагийн сургалт зохион байгуулж 7500 иргэнийг хамруулсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал өссөн үзүүлэлттэй байна.	100	“Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх” төслийн 2022 оны төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Төслийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд цахимаар 1694, танхимаар 851 удаагийн сургалтыг зохион байгуулж, нийт 187,352 иргэнийг хамруулсан. 33 өрхийн эрүүл мэндийн төв товлолын дархлаажуулалтын цэгтэй ба 2022 онд 3 төвд шинээр нэгж нээн ажиллуулж байна. Оны эхний 11 сарын байдлаар 2,5 тэрбум төгрөгийн үнэ бүхий 204,044 хүн тун вакциныг дагалдах хэрэгслийн хамт 33 дархлаажуулалтын нэгжид хүргэлээ. 2022 оны байдлаар сүрьеэгийн амбулаторийн үзлэг 4408, диспансерийн үзлэг 2864, урьдчилан сэргийлэх үзлэгт 25,204 иргэнийг хамруулж, 363 иргэнийг эмчилгээнд оруулж 62 иргэн бүрэн эдгэрээд байна. “Сүрьеэгүй дүүрэг-Хамтын ажиллагаа” дүүргийн зөвлөгөөнийг зохион байгуулж, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгч, эрүүл мэндийн байгууллагын удирдлага, хороодын Засаг дарга, өрхийн эрүүл мэндийн төвийн дарга нараас бүрдсэн 105 хүнийг хамруулаа. Сүрьеэ судлалын мэргэжлийн салбар зөвлөл, Хүүхэд судлалын мэргэжлийн салбар зөвлөл, МСТХ, Австралийн Мельбурний Их сургуулийн доктор, профессоруудтай хамтран хүүхдийн болон сүрьеэгийн эмч нарт “Хүүхэд, өсвөр насанд тохиолдох сүрьеэгээс сэргийлэх, оношлох, эмчилгээний менежмент” сэдэвт 2 өдрийн сургалтыг зохион байгуулж 58 эмчийг чадавхжууллаа. Дүүргийн ерөнхий боловсролын сургуулийн нийгмийн ажилтнуудтай “Өглөөний уулзалт” арга хэмжээг зохион байгуулж өсвөр насныхны дундах БЗДХӨ, жирэмслэлтийн талаар мэдээлэл олгож, санал солилцлоо. Өсвөр үе, нөхөн үржихүйн кабинет байгуулах “Ворлд шэйр” олон улсын байгууллагатай хамтран хэрэгжүүлэхээр тохирсон ба 2 удаагийн уулзалтыг зохион байгуулж, хамтран ажиллах санамж бичиг үсэглэж, 2023 онд төслийг хэрэгжүүлэхээр ажиллаж байна. 2022 оны 11 дүгээр сарын байдлаар Ковид-19 халдварын эсрэг дархлаажуулалтанд 25,315 иргэн хамрагдсан.	90%



9	7.2.3. Сүрьеэгийн эрт илрүүлэг үзлэгийг төрийн болон Глобаль сантай хамтран өрхийн эрүүл мэндийн төвүүдийг түшиглэн зохион байгуулах	Глобаль сангийн дэмжлэг	Хамрагдах иргэн, тоо	300	3000	Монголын Сүрьеэтэй тэмцэх нийгэмлэг, ХӨСҮТ, ӨАУМХ, ӨЭМТ-тэй хамтран эрсдэлт бүлгийн хүн амд эрт илрүүлэг үзлэг зохион байгуулж 3200 иргэдийг үзлэгт хамруулсан. Үзлэгийн хүрээнд эмэнд тэсвэртэй сүрьеэтэй 85 өвчтөнд ХӨСҮТ, МАТА, Улаанзагалмай нийгэмлэгтэй хамтран хүнсний тусламж, 60 хүнд автобусны билет, 60 хүнийг ЭХМКомиссоор оруулж ХЧА-ийн хувь тогтоолгон, сунгалт хийлгүүлж, нийгмийн халамжийн үйлчилгээнд хамруулаад байна. Зорилтот бүлгийн иргэдтэй хамгийн ойр тулж ажилладаг хорооны хэсгийн байцаагч, нийгмийн ажилтнуудад зориулан “Сүрьеэ эдгэдэг, хамгаалж болдог өвчин” сэдэвт сургалтыг зохион байгуулсан. “Сүрьеэтэй тэмцэх дэлхийн өдөр”-ийн хүрээнд зохион байгуулсан “Сүрьеэ өвчнөөс хамтдаа сэргийлье” нийслэлийн хэмжээний өдөрлөгт амжилтай оролцлоо. Олон улсад болон бусад байгууллагуудад хэрэгжүүлж буй сүрьеэгийн оношилгоо, эмчилгээний шинэ техник, технологи TUBIS системийг үйл ажиллагаандаа нэвтрүүлж иргэдэд ойр үйлчлэх зорилгоор цахим эмчилгээний хяналтыг сайжруулан ажиллаж байна. Дүүргийн Засаг даргын 2022 оны А/617 дугаар захирамжаар Монголын Сүрьеэтэй тэмцэх нийгэмлэгтэй хамтран 10 дугаар сарын 17-ны өдрөөс эрт илрүүлэг үзлэгийг зохион байгуулж эхлээд байна. Үзлэгийн хүрээнд хороо, өрхийн эрүүл мэндийн төвийн хамтарсан уулзалтыг зохион байгуулж, чиг үүргийг тодорхой болгож, үзлэгийг хуваарилан эхлүүлснээр 559 иргэнийг үзлэгт хамруулж, 7 өвчлөлийг илрүүлж, эмчилгээнд орууллаа.	100%
10	7.2.4. Эх, хүүхдийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулан “Эх хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” төслийн 2022 төлөвлөгөөг боловсруулж, батлуулан, хэрэгжилтийг хангах	30.0 Дүүргийн төсөв	Төлөвлөгөөний хэрэгжилт, хувь	Эх, хүүхэд, нөхөн үржихүйн чиглэлээр танхимаар 58, цахимаар 267 удаагийн сургалтыг зохион байгуулж 9700 гаруй иргэнийг хамруулсан.	100	“Эх хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” төслийн 2022 оны төлөвлөгөөг боловсруулан батлуулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 2022 оны байдлаар 5688 жирэмсэн эхийг шинээр хяналтанд авсан. Эхний 3 сартайд 2857, 4-6 сартайд 226, 7 ба түүнээс дээш сартайд 19 жирэмсэн эх хяналтанд орж жирэмсний эрт хяналтын хувь 91 буюу өмнөх оны мөн үеэс 2%-иар өссөн үзүүлэлттэй байна. Тайлант хугацаанд 0-1 насны эндэгдэл-71, 1-5 насны эндэгдэл-6, төрөлт 3950, үүнээс амьгүй төрөлт-24, гэрийн төрөлт-24, хяналтгүй төрөлт-9 байна. Нөхөн үржихүйн насны эрсдэлт бүлгийн эмэгтэйчүүдийн урьдчилан сэргийлэх үзлэгт 4528 эмэгтэйг хамруулж, цахимаар 1141, танхимаар 824 удаагийн	100%

					<p>сургалтыг явуулж, 126808 иргэнийг хамрууллаа. Дүүргийн эрүүл мэндийн байгууллагуудын дунд “Бидний мэргэжил-Бидний бахархал”, “Дэнлүү барьсан эмэгтэй” ур чадварын Анхдугаар уралдаан, үзүүлэх ажлыг зохион байгууллаа. Уралдаанд Эрүүл мэндийн төв, Нэгдсэн эмнэлэг, Хүүхдийн сэргээн засах төв, Жаргалант тосгоны эрүүл мэндийн төв, өрхийн эрүүл мэндийн төвийн эмч, сувилагч нараас бүрдсэн 8 баг 84 эмч, сувилагч авьяас, чадвараа сорин өрсөлдсөнөөс Толгойт бүсийн эмч нар, Нэгдсэн эмнэлгийн сувилагч тэргүүн байр эзэллээ. Уралдаанд эх хүүхэд, нөхөн үржихүй, яаралтай тусламж, сувилахуйн тусламж үйлчилгээний төрлөөр ур чадвараа уралдуулсан ба нийт 400 гаруй хүн хамрагдаж мэдлэгээ нэмэгдүүлсэн. Өсвөр насныхны эрүүл мэндийн боловсролыг нэмэгдүүлэх, өвчлөлийг бууруулах ажлын хүрээнд “World share” олон улсын байгууллагад “Өсвөр үе нөхөн нөхөн үржихүйн кабинет” байгуулах төслийг илгээж, 2 удаагийн уулзалтыг зохион байгуулж, Санамж бичиг үзэглэлээ. Залуу гэр бүлүүдийн эрүүл мэндийн боловсролыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд ажил хэрэгч “Өглөөний уулзалт”-ыг ерөнхий боловсролын сургуулийн нийгмийн ажилтнуудтай зохион байгууллаа. Нөхөн үржихүйн эрүүл мэнд, эх, хүүхдийн эрүүл мэндийн талаар 1141 удаагийн цахим, 824 удаагийн танхимын уулзалтыг зохион байгуулж 126,808 иргэнд мэдээлэл өглөө.</p> <p>Урьдчилан сэргийлэх үзлэгийг 0-1 насны хүүхдүүдийн дунд 54 удаа явуулж 5942 хүүхэд, 1-5 насны хүүхдүүдийн дунд 48 удаа зохион байгуулж, 10,782 хүүхдийг хамруулсан. Хүүхэд, жирэмсэн эхчүүдийн гэрийн идэвхтэй эргэлт давхардсан тоогоор 104,270 буюу 92.1%-тай байна. Өрхийн эрүүл мэндийн төвүүдэд эрүүл мэндийн даатгал төлдөггүй, зорилтот бүлгийн нөхөн үржихүйн насны 11021 эмэгтэйд урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, 2457 эмэгтэйд ЖСА хэрэглүүлэх арга хэмжээг аваад байна.</p>	
<b>Хэсгийн дундаж хувь</b>					<b>98%</b>	
<b>ЗОРИЛГО 8. ДҮҮРГИЙН ХЭМЖЭЭНД ИРГЭДИЙН НИЙТИЙН БИЕИЙН ТАМИР БОЛОН ОЛОН ТӨРӨЛТ СПОРТООР ХИЧЭЭЛЛЭХ ОРЧИН, НӨХЦӨЛИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ, ТЭМЦЭЭН, НААДМЫН ТОГТОЛЦООГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ЧИГЛЭЛЭЭР БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛНА.</b>						

**Зорилт 8.1. Нийтийн биеийн тамир спортыг хөгжүүлэх, иргэдийн биеийн тамир, спортоор хичээллэх нөхцөлийг бүрдүүлэх, усан спортоор хүүхэд залуучуудын бие бялдар, чийрэгжүүлэлтийн түвшинг дээшлүүлэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх арга хэмжээ авч ажиллана.**

11	8.1.1. Нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэх, хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх аж ахуйн нэгжрүү чиглэсэн арга хэмжээнүүдийг зохион байгуулах	20.0 Дүүргийн төсөв	Зохион байгуулах арга хэмжээ, тоо	Нийтийг хамарсан 11 удаагийн арга хэмжээг цахимаар зохион байгуулж, 362 байгууллагын 16,288 иргэдийг хамруулсан.	5	<p>Нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэх 43 удаагийн арга хэмжээг зохион байгуулж 5964 байгууллагын 99546 иргэнийг хамрууллаа. “Илүүдэл жингүй-Эртэч Монгол”, “Алхацгаая-Гүйцгээе” аян, “Идэвхтэй хөдөлгөөнд-Иргэн бүр” цахим уралдаануудыг зохион байгуулж сургуулийн спорт заалыг 06:30-07:30 цагт иргэдэд нээлттэй байлгаж, дасгал хөдөлгөөнөөр хичээллэх нөхцөлийг бүрдүүлж 155 байгууллагын 39,572 иргэнийг хамруулж, 3 багц дасгалын хүрээнд 67 иргэн, аж ахуйн нэгж байгууллага, хамт олныг шагнаж урамшууллаа. Монголын бүх ард түмний XV, Үндэсний спортын VII наадам, Иргэдийн спортын X их наадмын дүүргийн аварга шалгаруулах тэмцээнүүдийг 24 төрлөөр зохион байгуулж 123 байгууллагын 16828 тамирчдыг хамруулж, шигшээ тэмцээнээс нийт 3 алт, 9 мөнгө, 11 хүрэл, нийт 24 медаль хүртсэн амжилттай оролцлоо. Төрийн захиргааны байгууллага, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн “Өвлийн спорт наадам-2022”, “Спорт наадам” арга хэмжээнүүдийг 4 удаа зохион байгуулж 180 байгууллагын 3620 албан хаагчид хамрагдсан. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд “Суугаа волейбол”, “Хонхот бөмбөг”-ийн 2 төрлөөр дүүргийн аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулж нийт 14 байгууллагын 88 тамирчин хамрагдсан.</p> <p>Дүүргийн Засаг даргын 2022 оны А/187 дугаар захирамжаар “Улаанбаатар марафон-2022” олон улсын гүйлтийн 5 цомыг бүс тус бүрт амжилттай аялуулж, 200 гаруй арга хэмжээг зохион байгуулж, 2235 иргэнийг “Улаанбаатар марафон-2022” оролцуулахаар бүртгэж, 2160 иргэний оролцоог ханган ажиллалаа. “Ulaanbaatar Cup-2022” насанд хүрэгчдийн аварга шалгаруулах хөл бөмбөгийн тэмцээнд дүүргийн тамирчид тэргүүн байр эзэлсэн.Багт 3.0 сая төгрөгийн дэмжлэгийг Засаг даргын Тамгын газраас үзүүлсэн. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн нэрэмжит “Их нүүдэл” өсвөрийн шатарчдын тэмцээнийг 2022 оны 10 дугаар сарын 22-ны өдөр зохион байгуулж 17 сургуулийн</p>	100%
----	--	------------------------	-----------------------------------	--	---	--	------

						408 тамирчин өрсөлдсөнөөс Ирээдүй цогцолбор сургуулийн баг тамирчид тэргүүлээ. 2022 оны 10 дугаар сарын 25-ны өдөр МЖ-клубын нэрэмжит дүүргийн аварга шалгаруулах “Жү-до” болон “Чөлөөт бөх”-ийн нээлттэй тэмцээнүүд зохион байгуулагдаж 55 байгууллагын 880 өсвөрийн тамирчин хамрагдсан. Мөн МЖ-клубын нэрэмжит дүүргийн аварга шалгаруулах нээлттэй тэмцээн зохион байгуулагдаж нийт 84 байгууллагын 1496 өсвөрийн тамирчин хамрагдаад байна. “Төрийн албан хаагчдын ажил мэргэжлийн онцлогт уялдуулан бие бялдрын хөгжил, хөдөлгөөний идэвхийг тодорхойлох” судалгаанд 19 байгууллагын 1495 иргэн, албан хаагчид хамрагдлаа.	
12	8.2.2. Усан спорт, сургалтын төвийн үйл ажиллагааг дэмжих, усан спорт хичээллэх хүүхэд, залуучуудын тоог нэмэгдүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх	-	Хамрагдах хүүхэд, залуучууд, тоо	Бассейнаар нийт 230, фитнес заалаар 200, лабораториор 195 иргэн үйлчлүүлсэн	1500	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2022 оны ЭБ-02/05 тогтоолоор Усан спорт сургалтын төвийн үйлчилгээний үнэ тарифыг шинэчлэн баталсан. Дүүргийн 30 жилийн ойг угтан “Эртэч Сонгинохайрханчууд-Эрт бос эд, эс бүхнээ сэргээцгээе” эрүүл мэндийн аяныг 3 сарын хугацаатай зохион байгуулж аяны хугацаанд өглөө 06:00-21:00 цаг хүртэл иргэдэд нээлттэй ажиллаж нийт 559 иргэнийг усан спортоор хичээллүүллээ. Байгууллага сурталчлах өдөрлөгийг “Тольт”, 62, 82, 83, 143 дугаар сургууль, 16,17, 22, 23, 32, 39, 43 дугаар хороодтой хамтран зохион байгуулсан. 2022 оны байдлаар бассейнаар 1250, лабораториор 700, фитнес заалаар 370, үйлчлүүлэгч үйлчлүүлж төсвийн орлогыг 42 хувиар давуулан ажиллаад байна. 2022 оны 04 дүгээр сард зохион байгуулагдсан “Өсвөр үе, залуучуудын улсын аварга шалгаруулах тэмцээн”-д төвийн усанд сэлэлтийн дугуйлангийн 1 тамирчин 3 дугаар зэргийн болзол хангаж, 3 тамирчин хувийн амжилтаа ахиуллаа. 2022 оны 10 дугаар сард Эрдэнэт хотод зохион байгуулагдсан усанд сэлэлтийн “Улсын аварга 2022” тэмцээнд нийт 10 тамирчин оролцож 2 тамирчин хувийн амжилтаа ахиулан 1 тамирчин спортын мастерын 2 дугаар зэргийн болзолыг тус тус хангасан амжилтийг үзүүллээ.	100%
13	8.2.3. “Ногоон ажлын байр хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх	-	Үйл ажиллагаан	0	Иргэд ажлын байраар	Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс баталсан Ногоон ажлын байр хөтөлбөрийн хүрээнд мод тарих, нийтийн эзэмшлийн талбайд тохижилт бүтээн	100%

			ы хэрэгжилт хувь		хангагдаж, орлого нэмэгдсэн байна	байгуулалтын ажил хийх 38 төслийг ажлын хэсгийн хурлаар хэлэлцүүлж, 38 төслийг дэмжин гэрээ байгуулж гүйцэтгүүлсэн. Нийтийг хамарсан ажил зохион байгуулах арга хэмжээний хүрээнд: Нийтийг хамарсан ажилд 641 иргэнийг хамруулсан. Төсөл хэрэгжсэн үйл ажиллагааны чиглэлийг ангилж үзвэл: -Хүүхдийн тоглоомын талбай засаж тохижуулах - 13 -Нийтийн эзэмшлийн зам, талбай засварлах - 7 -Явган хүний гүүр барих - 2 -Нийтийн эзэмшлийн хог цэвэрлэгээ хийх - 3 байна. Мод тарих арга хэмжээний хүрээнд: Мод тарих арга хэмжээнд 12 хорооны Засаг даргын ажлын албанаас ирүүлсэн төслийг дэмжиж, 127 иргэнийг түр ажлын байраар ханган 1970 мод тарьсан.	
14	8.2.4. Усан спорт, сургалтын төвийн барилгын ажлыг эхлүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх	3,400.0 Улсын төсөв	Барилгын ажлын явц, хувь	0	10	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар дүүргийн 34 дүгээр хороонд 25 метрийн урттай таван зам бүхий усан бассейн, боулинг, фитнесийн тоног төхөөрөмжтэй олон улсын стандартад нийцсэн орчин үеийн шийдэлтэй “Усан спорт сургалтын төв” барих ажлын тендерт “Ванхүү” ХХК шалгарч газар шорооны ажил, суурийн цутгалтын ажлыг бүрэн дуусгасан. Барилгын ажлын гүйцэтгэл 30%-тай байна.	100%
15	8.2.5. Хөл бөмбөгийн талбай бүхий спортын цогцолборын барилгын ажлыг эхлүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх	4,000.0 Улсын төсөв	Барилгын ажлын явц, хувь	11 айлын газрыг 1.2 тэрбум төгрөгийн нөхөх олговор олгож чөлөөлсөн. Гүйцэтгэгчээр “Аглуут” ХХК гүйцэтгэгчээр шалгарсан.	70	3 дугаар хорооны нутаг дэвсгэрт баригдаж буй хөл бөмбөгийн талбай бүхий спортын цогцолборын барилгын ажлын тендер зарлагдаж “Аглуут” ХХК шалгарсан. 2022 оны 5 дугаар сард барилгын шав тавигдаж, газар шорооны ажил дууссан. 3 айлын газар чөлөөлтийн ажил удаашралтай, хүлээгдэж байна.	50%
16	8.2.6. Дүүргийн Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багийн үйл ажиллагааг дэмжих, Улс, тив, дэлхий, нийслэлийн чанартай	20.0 Дүүргийн төсөв	Улс, тив, дэлхийн чанартай тэмцээний медал, тоо	2021 онд 27 медал	50	Дүүргийн Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ баг нь 2022 онд сагсан бөмбөг, гар бөмбөг, дугуй, буудлага, чөлөөт бөх, жудо бөх, аэробек, хөнгөн атлетик, бокс, таеквондо гэсэн 10 төрлөөр хичээллэж, тамирчид дараах амжилтуудыг үзүүлээд байна. Үүнд: Буудлагын өсвөрийн шигшээ баг өсвөр үеийн Монгол Улсын аварга шалгаруулах тэмцээнд 2 алт, 3 хүрэл медаль, багаараа	100%

	уралдаан тэмцээнүүдэд оролцуулж, ур чадварыг дээшлүүлэх					тэргүүн байр, Жү-до бөхийн төрлөөр 5 алт, 6 мөнгө, 17 хүрэл, Аэробикийн төрлөөр 28 алт, 29 мөнгө, 4 хүрэл, Таеквондогийн төрлөөр 1 алт, 3 хүрэл, Самбо бөхийн ДАШТ-ий өсвөр үеийн ангилалд 1-мөнгөн, 1 хүрэл медаль, залуучуудын ангилалд 1 алт нийт 101 медаль тус тус хүртлээ. Засаг даргын дэргэдэх Өсвөрийн шигшээ багийн дунд ёс зүй болон сэтгэл зүйн сургалтыг 2 удаа зохион байгуулж 223 тамирчин хамрагдсан байна. Засаг даргын 2022 оны А/349, А/468, А/487, А/610 захирамжуудаар 25 тамирчдад нийт 15,690,000 төгрөгийн дэмжлэг үзүүлээд байна.	
<b>Хэсгийн дундаж хувь</b>							<b>91.6%</b>
<b>ЗОРИЛГО 9. ИРГЭД ОЛОН НИЙТИЙГ “КОВИД-19” ЦАР ТАХЛААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЖ, НӨӨЦИЙН БЭЛЭН БАЙДЛЫГ ХАНГАНА.</b>							
<b>Зорилт 9.1. Гамшгаас хамгаалах хуулийн хүрээнд хариу арга хэмжээг зохион байгуулна.</b>							
17	9.1.1. Улирлын чанартай томуу, томуу төст өвчин, амьсгалын замын халдварт өвчин, цар тахлаас урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааг байгууллага, аж ахуйн нэгжүүдэд зохион байгуулах	2.0 Дүүргийн төсөв	Зохион байгуулах сургалт, тоо	0	10	Дүүргийн Засаг даргын 2022 оны “Амьсгалын замын цочмог халдвар, коронавируст халдвар, томуу, томуу төст өвчний үед авах арга хэмжээний тухай” А/618 дугаар захирамжаар 3 зорилт, 23 арга хэмжээ бүхий төлөвлөгөөг батлан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Халдвараас сэргийлэх, дэгдэлтийн үед авах арга хэмжээний хүрээнд ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, өрхийн эрүүл мэндийн төвийн эмч нарыг чадавхжуулах сургалтыг Халдварт өвчин судлалын үндэсний төв, Эрүүл мэндийн төвтэй хамтран 10 удаа зохион байгуулж, 486 эмчийг хамрууллаа. Эрүүл мэндийн төвийн салбар амбулаториуд, өрхийн эрүүл мэндийн төвүүд уртасгасан цагаар ажиллаж, хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагуудад чиглэсэн сурталчилгааны ажлыг албан ёсны пэйж хуудас болон фэйсбүүк хуудсаар явуулж, 21 төрлийн мэдээлэл, видео шторкийг 45 групп, 100 гаруй байгууллагын фэйсбүүк группт нийтэлж, эрүүл мэндийн байгууллагаас ирүүлсэн зөвлөмжийг холбогдох байгууллага, сургууль, цэцэрлэгт хүргүүлж, хэрэгжилтийг тайлагнан ажиллаж байна.Томуу, томуу төст өвчний дэгдэлт нэмэгдэж, буурахгүй байгаатай холбогдуулан 0-5 насны хүүхдийн гэрийн эргэлтийг нэмэгдүүлж, нийт давхардсан тоогоор 0-1 насны 6000 гаруй хүүхдийг	100%

						гэрээр үзэж, зөвлөгөө өгөөд байна. Өвчлөлийн байдал буурахгүй байгаатай холбогдуулан орны эргэлтийг нэмэгдүүлэх зорилгоор Хүүхдийн сэргээн засах “Эрүүл үрс” төвд нэмэлтээр 20 орыг ажиллуулж эмчилгээ, үйлчилгээг явуулж байна. Улиралын томуугийн эсрэг вакцинаар дархлаажуулах ажлыг 2022 оны 10 дугаар сарын 20-ны өдрөөс 10 хоногийн хугацаатай зохион байгуулж төрийн болон хувийн хэвшлийн 114 цэцэрлэгийн 1-5 насны 10509, ерөнхий боловсролын сургуулийн 6-11 насны 18,830, гэртээ байдаг 2787 хүүхэд, 228 жирэмсэн эмэгтэй, архаг хууч өвчтэй болон 65-аас дээш насны 11,585 иргэн, нийт 43,979 иргэнийг хамрууллаа. Мөн 870 эрүүл мэндийн ажилтаныг дархлаажуулсан.	
18	9.2.2. Дүүргийн нутаг дэвсгэрийн хүнс, худалдаа, үйлчилгээний байгууллага, аж ахуйн нэгжүүдэд халдвар, хамгааллын дэглэм мөрдүүлэх арга хэмжээ авах, хяналт тавих	2.0 Дүүргийн төсөв	Хяналт, шалгалтад хамрагдсах байгууллага, тоо	11175	11175	Дүүргийн Засаг даргын 2022 оны А/46 дугаар захирамжаар хороодод хуваарилалт хийж, зохион байгуулалтаар ханган, нутаг дэвсгэрийн хэмжээнд нийт 10255 худалдаа, үйлчилгээний байгууллагуудын 731353 м2 талбайд ариутгал халдваргүйжүүлэлт хийсэн. Ариутгал халдваргүйтгэл хийх хүсэлт ирүүлсэн 11 аж ахуйн нэгжийн ажлын байр, тоног төхөөрөмж, бодисын нөөцтэй ажлын байран дээр нь очиж танилцан, 2 удаагийн хурал зохион байгуулсан.	100%
19	9.2.3. Коронавируст халдвар (Ковид 19)-аас урьдчилан сэргийлэх мэдээлэл, сурталчилгааг цахимаар тогтмол явуулах, хороод, ӨЭМТ-ийг сургалтын гарын авлага, материалаар хангах ажлыг зохион байгуулах	5.0 Дүүргийн төсөв	Хамрагдах иргэн, тоо	100,000	200,000	Коронавируст халдвар (Ковид 19)-аас урьдчилан сэргийлэх мэдээлэл, сурталчилгааг тогтмол цахимаар хүргэн ажиллаж байна. Халдварын тохиолдол, томуу, томуу төст өвчний дэгдэлт нэмэгдсэнтэй холбогдуулан дүүргийн сайт, Эрүүл мэндийн төв, Нэгдсэн эмнэлэг, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн пэйж, фэйсбүүк группээр тогтмол мэдээлэл явуулж, 20 төрлийн мэдээлэл, 2 видео шторкийг 45 группээр түгээж давхардсан тоогоор 41,200 хүнд хүргэсэн байна. “Нэмэлт дархлаажуулалтад идэвхитэй хамрагдаарай” брошур 10,000 ширхэгийг хэвлэж, өрхийн эрүүл мэндийн төвүүдээр дамжуулан иргэдэд хүргэсэн. Олон улсын байгууллага, Онцгой байдлын хэлтэстэй хамтран цар тахал, гамшиг ослоос сэргийлэх зөвлөмж бүхий ном, сурталчилгааны материалыг 40 дүгээр хорооны 2300	100%

						өрхөд тарааж, мэдээлэл олгох ажлыг хийгээд байна. “Эрсдлийг бууруулж маскаа зүүцгээе” аяныг 1 сарын хугацаатай зохион байгуулж “Ковид-19” халдвараас сэргийлэх 5 төрлийн сургалтын материал, 2 төрлийн шторк, 5 төрлийн мэдээллийн постер боловсруулж 43 хороо, өрхийн эрүүл мэндийн төв, 143 аж ахуйн нэгж байгууллагад хүргэн давхардсан тоогоор 35,000 хүнд хүргээд байна.	
20	9.2.4. Төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран хүмүүнлэгийн ажлуудыг зохион байгуулах, иргэдэд чиглэсэн дэмжлэг, тусламжийг нэмэгдүүлэх	-	Хамрагдах иргэн, тоо	10,902	10,000	World share олон улсын байгууллагатай хамтран “Иргэдийн амьдрах орчинг сайжруулах, гал түймэр болон гамшгаас урьдчилан сэргийлэх” төслийг 40 дүгээр хороонд хэрэгжүүлж зорилтот бүлгийн орон гэргүй 30 өрхөд гэр олгож, 300 өрхөд хүнсний дэмжлэг үзүүлсэн. Уг төслийн хүрээнд гамшиг, осол, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааны материал 2300 өрхөд тараагдаад байна. Дүүргийн Улаан загалмай нийгэмлэгтэй хамтран коронавируст халдвар (Ковид 19)-т өртсөн 1894 өрхийн 7584 иргэнд хүнсний багц олголоо.	90%
<b>Хэсгийн дундаж хувь</b>							<b>97.5%</b>
<b>ЗОРИЛГО 10. ИРГЭДИЙГ БАЙНГЫН АЖЛЫН БАЙРААР ХАНГАН ТЭДНИЙ МЭРГЭЖИЛ, УР ЧАДВАРЫГ ДЭЭШЛҮҮЛЖ, ӨРХИЙН ОРЛОГЫГ НЭМЭГДҮҮЛЭН НИЙГМИЙН ХАМГААЛЛЫГ ҮЕ ШАТТАЙГААР САЙЖРУУЛНА.</b>							
<b>Зорилт 10.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, 40-өөс дээш насны 1000 иргэний ажлын байрыг нэмэгдүүлэн, иргэдийн амьдралын түвшинг дээшлүүлнэ.</b>							
21	10.1.1. 40-өөс дээш насны иргэдэд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд ажлын байрыг бий болгож, ажил хайгч болон ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэдийг байнгын болон түр ажлын байранд зуучлах үйлчилгээг үзүүлэх	-	Ажлын байр, тоо	512	680	Дүүргийн хэмжээнд 40-өөс дээш насны 41,914 иргэн байгаагийн 4520 иргэн ажил хөдөлмөр эрхлээгүй байна. Ажил идэвхтэй хайж буй 40-өөс дээш насны иргэдийг хүсэл сонирхол, мэргэжил, ур чадварыг нь харгалзан, хөдөлмөрийн зах зээлийн бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэлжүүлэн байнгын ажлын байранд зуучлан ажиллаж байна. Иргэдийг байнгын болон түр ажлын байранд зуучлах зорилгоор “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих өдөрлөг, арга хэмжээ”-г 3 удаа зохион байгуулж 40-өөс дээш насны 301 иргэнийг үйлдвэрийн болон худалдаа үйлчилгээний салбарын байнгын ажлын байранд зуучилсан. “Аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжих хөтөлбөр”, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний үйл ажиллагааг дэмжих хөтөлбөр”, “Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”, “Иргэнд санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээ”-нд хамрагдахаар	100%



						423 иргэн төсөл ирүүлсэнээс 179 иргэний төслийг шалгаруулж санхүүгийн дэмжлэг олгосноор 194 байнгын ажлын байр бий болоод байна. 2022 онд түр ажлын байранд нийт 544 иргэнийг хамруулсанаас 70 хувь нь буюу 381 нь 40-өөс дээш насны иргэд байна.	
22	10.1.2. “Эрэгтэйчүүдийн хөгжлийн төв”, “Эмэгтэйчүүдийн хөгжлийн төв”- үүдийн үйл ажиллагааг дэмжиж байнгын ажлын байрыг нэмэгдүүлэх	12.0 Дүүргийн төсөв	Ажлын байр, тоо	4	4	“Эрэгтэйчүүдийн хөгжлийн төв”, Эмэгтэйчүүдийн хөгжлийн төв”-үүдийн үйл ажиллагааг хөгжүүлэх, тогтмолжуулах, иргэдэд үйлчлэх үйлчилгээний чанарыг нэмэгдүүлэх, сайжруулах зорилгоор Засаг даргын 2022 оны Б/22 дугаар захирамжаар өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулах үүрэг бүхий 2 гэрээт ажилтныг томилсон ба тушаал болон хөдөлмөрийн гэрээг холбогдох хууль эрх зүйн хүрээнд боловсруулж, Засаг даргын Тамгын газрын даргын Б/255, Б/256 дугаар тушаалаар байнгын ажлын байранд томиллоо. Эрэгтэйчүүдийн хөгжлийн төв нь модон эдлэл, алт мөнгөний дархан, арьсан эдлэл, гар урлалын сургалт явуулж 300 иргэнийг хамруулсан бөгөөд үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг байнга борлуулахын зэрэгцээ сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, нийтийн бүжгийн үйлчилгээг үзүүлж байна. Дүүргийн Жижиг дунд үйлдвэрлэл, мэдээллийн сургалтын төвтэй хамтран “Сүлжмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн уулзалт”, “Арьсан эдлэлийн бүтээгдэхүүнийг хийх арга техник” зэрэг үзүүлэх сургалтыг 3 удаа зохион байгуулж нийт 150 иргэнийг чадавхжууллаа. Дүүргийн өсвөр үеийн хөвгүүдийн дунд цуврал “ЗӨВ ӨГЛӨӨ” уулзалтуудыг Эрэгтэйчүүдийн хөгжлийн төвийг түшиглэн 4 удаа зохион байгуулж “Эрүүл мэндийн боловсрол, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх”, “Мэргэжил сонголт ба өөрийгөө бүтээхүй”, “Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн боловсрол”, “Манлайлах ур чадвар олгох сургалт”-уудаар нийт 160 өсвөр насны хөвгүүд болон эрэгтэйчүүдэд мэдлэг олгосон. МҮХАҮТ-тай хамтран Эмэгтэйчүүдийн хөгжлийн төвийн 3 багшийг “Ахмад зөвлөх багш” зэрэгтэй болгож, 2022 оны 11-р сарын 11-ны өдөр үнэмлэхийг гардуулан өглөө. Эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн хөгжлийн төвүүдэд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны санхүүжилтээр	100%

						50 сая төгрөгийн оёдлын тоног төхөөрөмжийн дэмжлэгийг үзүүлээд байна.	
23	10.1.3. Оёдлын бизнес эрхлэгчдийн чуулган, уралдаан, тэмцээн зохион байгуулах	14.5 Дүүргийн төсөв 5.5 ХЭДС 7.0 ОУБ	Зохион байгуулах арга хэмжээ, тоо	0	1	<p>Дүүргийн гар урлаач иргэдийн бүтээлч үйл ажиллагааг дэмжих, үндэсний өв уламжлалаа түгээн дэлгэрүүлэх, төрийн болон хувийн хэвшлийн байгууллага, аж ахуйн нэгжийн үйлдвэрлэгчдийн уялдаа холбоог сайжруулан шинэ санаа, технологи нэвтрүүлж ур чадварыг нэмэгдүүлж, өрхийн орлого, амьдралын төвшинг сайжруулах зорилгоор “Гар урлаачдын уралдаан” болон “Оёдолчдын нэгдсэн чуулган”-ыг хамтатган зохион байгуулж, нийт 350 гаруй иргэнийг хамрууллаа. Чуулганаас хүний нөөц, ур чадвар зэрэг олон тулгамдаж буй асуудлыг оёдолчдын ур чадварын төвшинтэй хамт тодорхойлж, зөвлөмж гарган хэлэлцүүлэг зохион байгуулснаар оёдолчдын нэгдсэн цахим групптэй болж дараах үр дүнгүүд гарч байна.</p> <ul style="list-style-type: none"> <li>- Дундын харилцаа, түншлэлийн холбоо нэмэгдсэн;</li> <li>- Гар урлаачид, оёдлын үйлдвэрлэл эрхлэгчид туршлага солилцож эхэлсэн;</li> <li>- Соёлын өв тээгчдийг олон нийтэд алдаршуулж, сурталчилсан;</li> <li>- Бараа бүтээгдэхүүн борлуулдаг иргэд, худалдан авалт хийдэг иргэдийн хоорондын эрэлт нийлүүлэлтийн уялдаа холбоог сайжруулсан;</li> <li>- Оёмол бүтээгдэхүүний эрэлт ихтэй төрийн болон томоохон аж ахуйн нэгж байгууллагыг оёдлын үйлдвэрлэл эрхлэгчтэй холбож, дүүргийн томоохон худалдан авалтад оруулах боломжтой бүтээгдэхүүний нөөцийг тодорхойлж зах зээлийг тэлж өгсөн зэрэг болно.</li> </ul> <p>Уралдааны удирдамжийн дагуу 150 гаруй гар урлаач, оёдлын үйлдвэрлэл эрхлэгчдээс 500 гаруй нэр төрлийн бүтээл ирүүлснийг 6 төрлөөр шалгаруулж 24 иргэнийг шагнаж урамшуулсан.</p>	100%
24	10.1.4. “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл”-ийг боловсруулж	80.0 Дүүргийн төсөв	Батлуулах төсөл, тоо	0	1	<p>“Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл”-ийг 2022-2024 онд хэрэгжүүлэхээр боловсруулж, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар хэлэлцүүлж, 2022 оны 9/03 дугаар тогтоолоор батлуулан хэрэгжилтийг</p>	90%

	батлуулан хэрэгжүүлэх					ханган ажиллалаа. Төслийг 3 зорилт, 15 арга хэмжээтэйгээр төлөвлөсөн ба хэрэгжилтийн явц 95%-тай байна. Ажил олоход хүндрэлтэй 4000 гаруй иргэдийн суурь судалгааг гарган, хөдөлмөр эрхлэлтийн эрэлт хэрэгцээг тодорхойллоо. Мөн ажил олоход хүндрэлтэй иргэнд зөвлөгөө, мэдээлэл өгөх өдөрлөг, арга хэмжээг 4 удаа зохион байгуулж 1142 иргэнийг хамруулсан. Мэргэжил олгох 59 чиглэлийн сургалтад үсчин, гоо сайхан, гагнуур, гар утас засвар, машин механизм, оёдол эсгүүр, касс хатгамал, эсгий урлал, тогооч мэргэжлээр 71 иргэн суралцаж, “Чадамжийн гэрчилгээ” авсан. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр төслийн хүрээнд бичил бизнес эрхлэгч 165 иргэнд аж ахуй эрхлэлтийн сургалт зохион байгууллаа. Захиалгат болон мэргэжлийн ур чадвар олгох, хөгжүүлэх, туршлага судлах 47 удаагийн сургалтад танхимаар 861, цахимаар 90, нийт 951 үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчийг оролцуулж, чадавхжуулаад байна. “Иргэний нийгмийн байгууллага-26 консерциум”, Азийн хөгжлийн банк, Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам зэрэг төрийн болон олон улсын байгууллагын дэмжлэгтэйгээр 41 оёдлын үйлдвэр эрхлэгч 281,2 сая төгрөгийн буцалтгүй тусламжид хамрагдаад байна. Хөгжлийн төвүүдийг түшиглэн бизнес инкубацийн үйлчилгээг явуулж тогтмолжуулсан бөгөөд 407 иргэнд зөвлөн туслах үйлчилгээг үзүүлээд байна. “Хамтдаа хөдөлмөрлөе-хамтдаа хөгжье”, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний борлуулалтын дэмжлэгийн арга хэмжээ”, “Сонгинохайрхан гоёл 2022”, “Хөдөлмөрлөж хөгжсөн сонгинохайрханчууд” өдөрлөгүүдийг зохион байгуулж нийт 138 аж ахуй нэгж, 200 гаруй жижиг дунд үйлдвэрлэл эрхэлдэг иргэдийн үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг сурталчлах үзэсгэлэн, худалдаа гаргаж борлуулалтыг нь дэмжин ажиллалаа.	
25	10.1.5. Ажил, мэргэжилгүй хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэдийг мэргэжлийн ур чадвар олгох болон	-	Сургалтад хамрагдах иргэн, тоо	557	575	НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрийн “Хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь” төслийн хүрээнд хөдөлмөр эрхлэлтийн хэрэгцээг нь тодорхойлсон 4 хорооны хөдөлмөр эрхлээгүй 50 иргэнд “Технож инкубатор төв” ТББ-тай хамтран бизнес инкубацийн үйлчилгээ үзүүлж, аж ахуй эрхлэлтийн сургалтад хамрууллаа. Хөдөлмөр	100%

	бизнесээ хөгжүүлэх сургалтад хамруулан чадавхжуулж хөдөлмөр эрхлэхэд нь дэмжлэг үзүүлэх.					эрхлэлтийг дэмжих төслийн бичил бизнес эрхлэгчдийг дэмжих “Жижиг зээл олгох арга хэмжээ”-ний хүрээнд дүүргийн “Жижиг дунд үйлвэрийг дэмжих бизнес инкубатор төв”-тэй хамтран бичил бизнес эрхлэгчдэд нийт 22 удаагийн сургалтыг цахимаар болон танхимаар зохион байгуулж, нийт 593 бизнес эрхлэгчийг хамруулсан. Үйлдвэр эрхлэгчийн ажлын байран дээрх зөвлөх үйлчилгээг цахим, танхим хэлбэрээр явуулж нийт 432 үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдэд мэдээ мэдээлэл өгч зөвлөн туслах үйлчилгээг үзүүлсэн. Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч эмэгтэйчүүдийг чадавхжуулах, дэмжлэг үзүүлэх зорилготой “Сонгинохайрхан дүүргийн үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжих бичил төсөл”-ийн хүрээнд 2 удаагийн сургалтыг зохион байгуулаад байна. Эрэгтэйчүүдийн хөгжлийн төвд явагддаг мэргэжлийн ур чадвар олгох 5 төрлийн сургалтад (эсгий урлал, арьсан эдлэл, монгол гутал оёдол, мужаан гэх мэт) нийт 195 иргэн, “Эмэгтэйчүүдийн хөгжлийн төв”-д явагддаг 3 төрлийн сургалтад (эсгий урлал, модон эдлэл, оёдол) 114 иргэн суралцаж төгсөөд байна. “Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр”-ийн мэргэжил олгох 59 чиглэлийн сургалтад 43 хорооны 169 иргэний судалгааг нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газарт хүргүүлсэн ба үсчин, гоо сайхан, гагнуур, гар утас засвар, машин механизм, оёдол эсгүүр, касс хатгамал, эсгий урлал, тогооч мэргэжлээр 71 иргэн суралцаж байна. Мөн санхүүгийн дэмжлэгт хамрагдах хүсэлтэй 496 иргэнд зээлийн өмнөх “Аж ахуй эрхлэлтийн сургалт”-ыг “Сантайн сервис” ХХК, “Элит интернэйшнел” ХХК, “Эм Эс девилопмент” ХХК-тай хамтран зохион байгуулж 176 иргэнийг чадавхжууллаа.	
26	10.1.6. Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчид болон хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэд, аж ахуйн нэгж байгууллагын ажиллагсдад	2.0 Дүүргийн төсөв	Зохион байгуулах аян, тоо	Нийт 15,000 гаруй иргэн, ажиллагсдад хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хууль, тогтоомжийг	1	Дүүргийн Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн зөвлөл 2022 оны 3 дугаар сарын 28-ны өдөр хуралдан сарын аяны хугацаанд хийх ажлын төлөвлөгөөг хэлэлцэн баталж “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аян-2022” сарын аяныг дүүргийн Засаг даргын 2022 оны А/170 дугаар захирамжаар “Аюулгүй байдал, эрүүл мэндийн эерэг соёлыг хамтдаа төлөвшүүлэе” уриан дор 4 дүгээр сарын 01-ний өдрөөс 5 дугаар сарын	100%

	<p>хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн мэдлэг олгох, мэдээллээр хангах ажлын хүрээнд аяныг зохион байгуулах</p>			<p>сурталчлан, болзошгүй аюул эрсдлээс урьдчилан сэргийлэх мэдээллийг хүргэсэн.</p>		<p>01-ний өдрийг хүртэлх хугацаанд зохион байгууллаа. Зохистой хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн соёлыг төлөвшүүлэх, аж ахуйн нэгж байгууллагын хүний нөөцийн тогтвортой байдлыг хангах, хөдөлмөрийн харилцаанд тулгарч буй асуудлыг шийдвэрлэх, хөдөлмөрийн зах зээлийн бүртгэл мэдээллийг сайжруулахад төр, хувийн хэвшлийн түншлэлийг бэхжүүлж, хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор “Зохистой хөдөлмөр эрхлэлт” зөвлөгөөнийг зохион байгуулсан. Зөвлөгөөнд дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж буй 50 томоохон аж ахуйн нэгж байгууллагын төлөөлөл оролцлоо. Аяны хүрээнд дүүргийн 13 хороо, төрийн болон төрийн бус өмчит 38 цэцэрлэг, ерөнхий боловсролын 15 сургууль нэгдэж сургалт, өдөрлөг, үйл ажиллагаа зохион байгуулж тайлангаа ирүүлсэн. Хөдөлмөрийн тухай хууль, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомжийг сурталчлах 3 төрлийн 3000 ширхэг брошур хэвлүүлж, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, ажил олгогч, ажиллагсад түгээж, ШТОПК бэлтгэн иргэдийг мэдээллээр хангахын зэрэгцээ SBN телевизээр хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аяны талаар мэдээлэл хийж, сурталчлан ажиллалаа. Аж ахуйн нэгж байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтнуудад зориулсан “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн зэрэг соёлыг хамтдаа төлөвшүүлье” үзүүлэх сургалт зохион байгуулж, 45 ажилтан, албан хаагчийг чадавхжууллаа.</p> <p>Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн улсын үзлэгийг эрүүл мэндийн салбарт зохион байгуулж төрийн өмчит болон хувийн хэвшлийн 80 байгууллагыг хамруулж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, хуулийн хэрэгжилтийг хангах зөвлөгөө мэдээлэл өгч, “Эрүүл мэндийн байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал” сэдэвт сургалтыг зохион байгуулж эрүүл мэндийн байгууллагуудын хөдөлмөрийн аюулгүй байдлын 56 мэргэжилтнүүд, удирдлагуудыг хамруулсан.</p>	
--	---	--	--	---	--	---	--

27	10.1.7. Халамжаас хөдөлмөр бодлогын хүрээнд зорилтот өрхийг ОУБ-ын болон орон нутагт хэрэгжих төсөл хөтөлбөрт хамруулж, иргэдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн үйлчилгээг сурталчлах өдөрлөг, туршлага солилцох уулзалт зохион байгуулах	-	Хамрагдах зорилтот бүлгийн иргэн, тоо	260	300	“Халамжаас хөдөлмөрт” бодлогын хүрээнд залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих “Оролцоо төсөл”-д 450 иргэнийг бүртгэснээс 206 иргэн тэнцэж нийт 4 удаагийн 14 хоногийн вакумжуулсан сургалтад 109 иргэн хамрагдсан ба 87 суралцагч үйлдвэрлэлийн дадлага хийж, 65 иргэн байнгын ажлын байранд зуучлагдсан. НҮБ-ын хөгжлийн хөтөлбөр, “Ажил олгогч эздийн нэгдсэн холбоо”-той хамтран “Хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь” төслийн хүрээнд дүүргийн 43 хороонд зорилтот бүлгийн ажилгүй иргэдэд ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, тохирох ажлын байранд зуучлах “Ажлын шуурхай ярилцлага” өдөрлөгийг зохион байгууллаа. Өдөрлөгийн үеэр “Ажлын байранд дадлагажих хөтөлбөр”-т хамруулахаар 15 ажил олгогч, 70 иргэнд зөвлөгөө, мэдээлэл өгч, 32 аж ахуйн нэгж байгууллага 591 ажлын байранд иргэдийг сонгон шалгаруулж, 150 иргэн ажлын байранд зуучлагдан, 95 иргэн “Дадлагажигч хөтөлбөр”-т хамрагдлаа. Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам, Азийн хөгжлийн банк, Монголын улаан загалмайн нийгэмлэгээс хамтран хэрэгжүүлж буй “Төгсөлтийн аргачлалаар хэрэгжүүлэх туршилтын төсөл” хөтөлбөрийн хүрээнд дүүргийн хэмжээнд 16 хорооны 855 өрх хамрагдаж байна. Тус төсөлд хамрагдсан өрхийн гишүүдэд амьдралын итгэл үнэмшилтэй болгох, нөлөөлөх, санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх, хувиараа хөдөлмөр чадавхыг нэмэгдүүлэх сургалтуудыг зохион байгуулж байгаа бөгөөд тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлэхээр судлагдаж байна. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох төсөлд 38 бүлгийн 77 иргэнд 62.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон.	100%
28	10.1.8. Ахмад настны мэдлэг, ажлын дадлага туршлагыг хүүхэд залуучуудад өвлүүлэх, түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагааг дэмжих	3.5 Дүүргийн төсөв	Оролцох хүн, тоо	Ахмад настны хөгжил оролцоог дэмжих, ээлтэй орчин бүрдүүлэх зорилтын хүрээнд хийгдсэн ажил 98.3	110	Дүүргийн 43 хорооны ахмадын зөвлөлийн дарга нартай уулзалт зохион байгууллаа. Уулзалтаар байгууллагуудад ахмадын сан байгуулах, спорт хороотой хамтран ажиллах гэрээ байгуулж ахмад настнуудыг хөдөлгөөний дутагдалаас сэргийлэх, “Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс”-ээс зарлагддаг төсөл, хөтөлбөрт хамруулан тэдний ажлын дадлага, туршлагыг	100%

				хувьтай хэрэгжсэн	<p>хүүхэд залуучуудад өвлүүлэн түгээн дэлгэрүүлэх үйл ажиллгааг шат дараатай хэрэгжүүлэх асуудлуудыг хэлэлцсэн ба дүүргийн ерөнхий боловсролын сургуулиудын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд спорт заалыг ахмадуудад үнэ төлбөргүй ашиглуулах заалтыг тусган, “Биеийн тамир, спортын хороо”-той хамтран ажиллах гэрээ байгуулж ахмадын 5 төрөлт спорт наадмыг зохион байгуулсан. Наадам софт волейбол, шатар, 100 буудалт даам, дартс, шинээний теннис зэрэг 5 төрлөөр зохион байгуулагдаж 43 хорооны 600 гаруй ахмад настныг хамрууллаа.</p> <p>Ахмадуудын ажлын дадлага, туршлагыг хүүхэд залуучуудад өвлүүлэн түгээн, дэлгэрүүлэх ажлын хүрээнд соёлын биет бус өв тээгч нар 250 иргэнд бие биелгээгээ өвлүүлэн сургалаа. Мөн “Шилдэг ахмадын зөвлөл”-ийн үйл ажиллагааг сурталчлах, танилцуулах, харилцан туршлага судлах өдөрлөгийг 15 дугаар хороонд зохион байгуулж 43 хорооны ахмадын зөвлөлийн дарга, хөгжлийн нийгмийн ажилтан, хөдөлмөр, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн, нийт 82 ажилтныг хамруулсан. Мөн гэр бүлийн үнэ цэнэ, хосуудын халуун дулаан уур амьсгал, үр хүүхдээ зөв өсгөх туршлагаа хүүхэд залуучуудад өвлүүлэн уламжлуулах зорилгоор “Ахмадаас суралцах 3 үеийн уулзалт” арга хэмжээг 2022 оны 7 дугаар сард, “Аз жаргалтай гэр бүл” 3 үеийн уулзалтыг 09 дүгээр сард тус тус зохион байгуулж ахмад, дунд, залуу үе, иргэдийн төлөөлөл болох 420 гаруй иргэдийг хамрууллаа. Уулзалтад Монгол Улсын Ардын жүжигчин П.Цэрэндагва, гэр бүл судлаач Г.Наранбаатар, нар “Гэр бүлийн үнэ цэнэ” сэдэвт сургалт, хэлэлцүүлгийг зохион байгуулж, залуучуудад гэр бүлийн үнэ цэнэ, амьдрах ухааны арга барилаас суралцах, амьдралын баялаг туршлага, захиас сургамжуудыг залуу хойчдоо хүргэсэн. Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн “Зөвлөх үйлчилгээ” арга хэмжээний төсөл зарлагдаж 58 төслийг дэмжин, гэрээ байгуулж, урамшуулал олгож байна.</p>	
--	--	--	--	-------------------	--	--

29	10.1.9. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах, хөгжүүлэх чиглэлээр иргэн болон төрийн бус байгууллагуудын санаачилгыг дэмжиж ажиллах	15.0 Дүүргийн төсөв	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	Хөгжлийн бэрхшээлтэй 52 иргэнийг 168.0 сая төгрөгөөр дэмжин ажлын байрыг нэмэгдүүлсэн.	100	“Хөгжлийн бэрхшээлтэй иргэний зөвлөл”-ийг хороо тус бүрд 5 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулан, зөвлөлийн дарга нартай уулзалт зохион байгуулсан. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд илгээсэн ил захидлын санал болон зөвлөлийн дарга нартай хийсэн уулзалтаар дэвшүүлсэн асуудлуудыг нэгтгэн холбогдох дээд шатны байгууллагад хүргэгдээд байна. Дүүргийн хэмжээнд нийт 10 ширхэг дуут гэрлэн дохиотой бөгөөд 2022 онд “Таван шарын автобусны буудал”, “Цамбагаравын автобусны буудал” гэх 2 байршилд 4 ширхэг дуут дохиог шинээр байрлууллаа. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн суугаа волейболын тэмцээнд оролцох баг тамирчдын хувцасны зардалд 3.9 сая төгрөгийн дэмжлэгийг үзүүлсэн ба “Монголын бүх ард түмний XV спортын наадам”-ын суугаа волейболын төрөлд 2 дугаар байр эзэлж, мөнгөн медаль хүртсэн. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эх, асран хамгаалагчдын нийгмийн оролцоог нэмэгдүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй иргэний зөвлөлийн гишүүдийг чадавхжуулах сургалтыг 6 удаа зохион байгуулж нийт 650 иргэнийг хамруулсан. Сургалтуудад 43 хорооны “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн зөвлөл”-ийн гишүүд, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эх, асран хамгаалагчид хамрагдсан ба “World share” Олон Улсын байгууллагын дэмжлэгийг хүлээлгэн өглөө. Жижиг дунд үйлдвэрлэл эрхэлдэг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн борлуулалтыг дэмжих зорилгоор үзэсгэлэн худалдааг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэстэй хамтран зохион байгуулж 10 иргэнийг хамрууллаа. Засаг даргын нэг удаагийн буцалтгүй тусламжийн журмын дагуу хөгжлийн бэрхшээлтэй 34 иргэнд 17,0 сая төгрөгийн тусламж үзүүллээ. Харааны бэрхшээлтэй иргэдийн цахим мэдээллийн орчныг хүртээмжтэй болгох төрийн үйлчилгээ үзүүлдэг 8 байгууллагад “NVDA” буюу дэлгэц уншигч програмыг суурилууллаа.	100%
30	10.1.10. “Ахмадад ээлтэй төслийг хэрэгжүүлэх дүүрэг” батлуулж	115.0 Дүүргийн төсөв	Батлуулах төсөл, тоо	2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 4 зорилт, 16	1	2022-2024 онд хэрэгжүүлэх “Ахмадад ээлтэй төсөл”-ийг боловсруулж, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар хэлэлцүүлж, 2022 оны 9/02 дугаар тогтоолоор баталсан. Төслийн хүрээнд 3 зорилт 24 арга	90%



				заалттай, хөтөлбөрийг хэрэгжүүлсэн. Гүйцэтгэл 97.5 хувьтай		хэмжээг хэрэгжүүлж байна. Ахмад настны тухай хуулийн хэрэгжилтийг хангах, “Ахмадын сан байгуулах” чиглэлийг төрийн болон төрийн бус өмчийн ерөнхий боловсролын сургуулиуд, сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудын гүйцэтгэлийн гэрээнд тусгасан. Дүүргийн 34-р хороо, Буман өлзий хороололд байрлах 372.9 м/кв талбай бүхий “Ахмадын хөгжлийн ордон” нээлтээ хийж ашиглалтад орсон. "Ахмадын спортын IV наадам"-ыг Сонгинохайрхан дүүргийн Биеийн тамир спорт хороотой хамтран зохион байгуулсан. Энэхүү наадам спортын есөн төрлөөр хоёр үе шаттай зохион байгуулагдаж 43 хорооны 980 гаруй ахмадууд оролцон өрсөлдлөө. Монголын “Шугаман бүжгийн холбоо”-той хамтран “Ахмадын шугаман бүжиг” хичээлийг нийт 20 хорооны ахмадуудад явуулж 41 хорооны 400 гаруй ахмадын дунд шугаман бүжгийн аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулсан. Ахмадын бүтээлийн үзэсгэлэн худалдааг бүсчилэн зохион байгуулсан бөгөөд нийт 112 ахмадын урласан 184 бүтээлийг иргэдэд сурталчлан ажилласан. Мөн дүүргийн тэргүүний өрхүүдийг шалгаруулан, хүндэтгэл үзүүлэх арга хэмжээ зохион байгуулж 43 хорооны шилдэг өрхүүдэд хүндэтгэл үзүүлсэн бөгөөд уг арга хэмжээнд 150 иргэн оролцлоо. Хэвтрийн болон хөгжлийн бэрхшээлтэй ахмад настнуудын бүртгэл судалгааг шинэчлэн, эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, оношлогоо, шинжилгээ, өдрийн болон сэргээн засах үйлчилгээнд ахмад настнуудыг хамруулаад байна. Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд нийт 153 ахмадыг түр ажлын байраар ханган өрхийн орлогыг дэмжин ажилласан.	
31	10.1.11. Сайн дурын нийгмийн даатгалд даатгуулахын ач холбогдлыг таниулах цахим сургалт, сурталчилгааг зохион байгуулах, хамралтыг нэмэгдүүлэх	-	Сайн дурын даатгалд хамрагдах иргэн, тоо	2000	3000	Албан бус хөдөлмөр эрхлэгчдийг сайн дурын даатгалд хамруулах зорилгоор мэдээлэл олгох сургалтыг цахимаар 2 удаа зохион байгуулж нийт 16,400 иргэнийг хамруулсан ба давхардсан тоогоор 572 иргэний асуултад хуулийн дагуу зөвлөгөө өглөө. Зорилтын хүрээнд дүүргийн 1, 2, 3, 6, 8, 9, 10, 12, 17, 20, 21, 22, 23, 24, 25, 34, 31, 32, 35, 36 дугаар хороодын иргэний танхимд “Даатгуулагч танд туслан зөвлөө” өдөрлөг, “Даатгалтай	100%

						Ирээдүй” сэдэвт сургалтуудыг зохион байгуулсан бөгөөд дүүргийн Ерөнхий боловсролын 24 сургуулийн 2091 сурагч, Шинэ анагаах ухааны сургууль, ЭЗШУИС-ийн 518 оюутнууд хамрагдсан. Сайн дурын нийгмийн даатгалд 2022 оны онд 5523 иргэнийг хамруулсан ба сайн дураар даатгуулагч 612 эмэгтэй шинээр гэрээ үүсгэж, хүүхдээ харах хугацаандаа нийгмийн даатгалд хамрагдаж байна. Нийгмийн даатгалын систем үүсгэн байгуулагдсаны 80 жилийн ойг угтаж 8 ажлын зохион байгуулах ажлын хүрээнд алслагдсан 21, 6 дугаар хороодын иргэдэд Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэстэй хамтран “Иргэн танд хүрч үйлчлээ” ажлыг зохион байгуулж нийт 135 иргэнд сайн дурын даатгалын талаар мэдээлэл зөвлөгөөг хүргэлээ.	
<b>Хэсгийн дундаж хувь</b>							<b>98.1</b>
<b>Үнэлгээний дундаж хувь:</b>							<b>97.0</b>

### ГУРАВДУГААР ХЭСЭГ.

#### ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДҮРМЭЭР ХҮЛЭЭСЭН ҮНДСЭН ЧИГ ҮҮРГИЙН ХҮРЭЭНД: /Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ/

№	Дүүргийн Засаг даргын 2020-2024 оны ажиллагааны хөтөлбөр, 2021 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
<b>ЗОРИЛГО 11. ДҮҮРГИЙН ТӨРИЙН АЛБАН ХААГЧДЫГ АВИЛГААС АНГИД, МЭРГЭШСЭН, УР ЧАДВАРТАЙ, ТОГТВОРТОЙ АЖИЛЛАХ, НӨХЦӨЛИЙГ БҮРДҮҮЛЖ, ШАТЛАН ДЭВШҮҮЛЭХ, ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ ИРГЭДЭД ТҮРГЭН ШУУРХАЙ, ЧИРЭГДЭЛГҮЙ ХҮРГЭЖ, ТӨРИЙН АЛБАНЫ СТАНДАРТ БАРИМТЛАН МЭДЭЭЛЛИЙН ДЭВШИЛТЭТ ТЕХНОЛОГИЙГ НЭВТРҮҮЛНЭ.</b>							
<b>Зорилт 11.1 Хууль тогтоомж, Засгийн газар болон харьяалах дээд шатны Засаг даргын шийдвэрийн гүйцэтгэлийг хангах ажлын хүрээнд:</b>							
1	11.1.1. Дээд газраас ирүүлсэн тогтоол, шийдвэрийн	-	Үйл ажиллагаан	Гүйцэтгэл 92.2 хувь	90-ээс дээш хувьтай	Монгол Улсын Хууль-2, Ерөнхийлөгчийн зарлиг-2, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж-1, Засгийн газрын тогтоол-32, Ерөнхий сайдын захирамж-1,	100%

	биелэлтийг тооцож, хэрэгжилтийг хангах		ы хэрэгжилт, хувь, тоо		хэрэгжсэн байх	Засгийн газрын хуралдааны тэмдэглэл-6, Засгийн газрын албан даалгавар-1, Нийслэлийн Засаг даргын захирамж-28, Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралдааны тэмдэглэл-5 нийт 78 тогтоол шийдвэрийн 140 заалтыг хяналтад авч хэрэгжилтийг ханган ажиллаа. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-Шинжилгээ, үнэлгээний хэлтсээс ирүүлсэн чиглэлийн дагуу хяналтад авсан тогтоол шийдвэрийн заалт тус бүрд Засгийн газрын 206 дугаар тогтоолын дагуу төлөвлөгөө боловсруулан дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргаар батлуулж, төлөвлөгөөний биелэлтийг 2022 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр 03/2644 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. Хяналтанд авсан 78 тогтоол шийдвэрийн 140 заалтын хэрэгжилтэнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлгэхээр хүргүүлсэн.	
2	11.1.2. Дүүргийн удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөнийг зохион байгуулж, өгсөн үүрэг, даалгаврын хэрэгжилтийг хангаж ажиллах	-	Үүрэг даалгаврын тоо, хэрэгжилтийн хувь	49 удаа зохион байгуулагдаж, 344 үүрэг, даалгаврын хэрэгжилт 87,5 хувь	85-аас дээш хувьтай хэрэгжсэн байх	Дүүргийн удирдах ажилтнуудын 25 удаагийн шуурхай зөвлөгөөнийг зохион байгуулж, нийслэл, дүүргийн Засаг даргаас өгөгдсөн 215 үүрэг, даалгаврыг www.shd.mn цахим хуудас, мэдээллийн самбарт байршуулж, хэрэгжилтийг ханган ажиллалаа. Үүрэг даалгаврын биелэлтийг 14 хоног тутам Тамгын газрын холбогдох хэлтэс, тасаг, харьяа байгууллагуудаас авч нэгтгэн www.ulaanbaatar.mn цахим хуудасны Үүрэг даалгаврын жагсаалт цэсэнд байршуулсан. Үүрэг даалгаврын хэрэгжилт 88,9 хувьтай байна.	90%
3	11.1.3. Дүүргийн Засаг даргын Тамгын газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж баталгаажуулах, гүйцэтгэлийг тооцох.	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь, тоо	Гүйцэтгэл 86.5 хувь	85-аас дээш хувьтай хэрэгжсэн байх	Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалаар баталсан 4 дүгээр хавсралтын дагуу нийслэл, дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 2022 оны арга хэмжээний төлөвлөгөөтэй уялдуулж, Засаг даргын Тамгын газрын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 27 зорилтын хүрээнд 5 бүлэг, 174 заалттай боловсруулж батлуулж, гүйцэтгэлийг хагас бүтэн жилээр тооцон ажиллаж байна.	100%
4	11.1.4. Төрийн дээд одон медаль,	-	Иргэдийн тоо 400	Нэр дэвшсэн 700 иргэдийн	Холбогдох баримт	Монгол улсын төрийн дээд одон, медальд нэр дэвшсэн 1187 иргэний материалыг холбогдох журмын дагуу	100%

	нийслэл, дүүргийн шагналаар шагнуулахаар аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс ирүүлсэн материалыг хүлээн авч хянан, холбогдох байгууллагад уламжлах.			шагналын материалын бүрдлийг хангасан.	бичгийн бүрдэлт бүрэн хангагдсан байх	хүлээн авч дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар хэлэлцүүлэн тогтоолын хамт нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн. Тэмдэглэлт өдрүүдийг угтан Монгол Улсын Засгийн газрын болон салбар яамдын шагналаар 164, дүүргийн “Хүндэт тэмдэг”-ээр 241, Засаг даргын өргөмжлөлөөр 275, “Ардын хувьсгалын 100, 101” жилийн ой медалиар 4736, нийт 5416 иргэний шагнасан. “Эхийн алдар” нэг, хоёрдугаар зэргийн одонгоор шагнагдах эхчүүдийн материалыг журмын дагуу хүлээн авч холбогдох байгууллагад хүргүүлсэн. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2022 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн 69 дүгээр Зарлигаар “Эхийн алдар” нэгдүгээр зэргийн одонгоор 95, хоёрдугаар зэргийн одонгоор 1209, нийт 1304 эхийн одонгоор шагнагдсан.	
5	11.1.5. Төрийн анхан шатны нэгж, хороодыг цаг үеийн мэдээ мэдээллээр шуурхай ханган, албан хэрэг хөтлөлт, цаг ашиглалтанд хяналт тавьж, удирдлага, арга зүйгээр хангаж ажиллах	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	Шуурхай хуралдаан 35, 225 үүрэг, даалгавар. Хэрэгжилт 85.5	Иргэдэд төрийн үйлчилгээг шуурхай хүргэсэн байх	Хороодын Засаг дарга нарын шуурхай хуралдааныг 2022 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар нийт 23 удаа зохион байгуулж, 172 төрлийн үүрэг даалгавар өгөгдөж, 89,9 хувийн биелэлттэй үнэлэгдсэн байна. Хорооны албан хаагчдад цагийн үеийн шинжтэй 800 гаруй мэдээ мэдээллийг хүргэх ажлыг зохион байгуулж, удирдлага арга зүйгээр хангаж ажилласан. Хорооны албан хаагчдад баримт бичгийн бүрдэл, түүнд тавигдах шаардлага, стандартыг мөрдүүлэх чиглэлээр арга зүйн зөвлөгөө, мэдээлэл тогтмол өгч, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.	100%
6	11.1.6. Хэвлэл, мэдээллийн байгууллагуудтай хамтран дүүргийн төр, захиргааны байгууллагуудаас зохион байгуулсан үйл ажиллагааны мэдээллийг иргэд, олон нийтэд шуурхай хүргэх	-	Мэдээ, мэдээллийн тоо	871 мэдээ, мэдээлэл 12 ярилцлага, тодруулгыг бэлтгэн бэлтгэж сурталчилсан.	Олон нийтэд шуурхай хүргэх	Нийслэлийн Соёл, урлагийн газар бусад байгууллагуудаас гаргасан нөлөөллийн 3D контент, “Хот”, “Бидний тухай бид” бичил цуврал нэвтрүүлэг, хотын соёлыг төлөвшүүлэх нөлөөллийн зурагт пост, 500 ширхэг плакат, 4300 ширхэг стикерийг төр, хувийн хэвшлийн байгууллагуудын албан ёсны пэйж, фэйсбүүк хуудсуудад байршуулан иргэд, олон нийтийн хүртээл болголоо. Хотын соёлыг төлөвшүүлэх, түгээн дэлгэрүүлэхтэй холбоотой уриалга 28, видео контент 4, зурагт постерийг 6 удаа бэлтгэн нийтэлж, цаг үеийн холбогдолтой 16 мэдээ, мэдээллийг дүүргийн www.shd.mn цахим хуудсанд байршуулсан. Тамгын газар, нутгийн захиргааны байгууллагуудаас зохион байгуулсан	100%

						<p>“Зөв өглөө” уулзалт, “Электрон тамхины хэрэглээ” сургалт, “Зөвийг зөвлөө”, “Харилцан хүндэтгэе” аян, хороодын Нийгмийн ажилтнуудыг урлагийн сэтгэл заслын хөтөлбөрт хамруулах үйл ажиллагаа зэрэг 8 мэдээ, мэдээлэл 4 сурвалжлага, ярилцлага, тодруулгыг бэлтгэн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчилсан. Дүүрэг үүсэн байгуулагдсаны 30 жилийн ой угтсан “Хотын соёл-Соёлтой болгоё” аяныг зохион байгуулахаар удирдамж, хөтөлбөр боловсруулж бэлтгэл ажлыг хангасан. 2022 оны 11 дүгээр сарын 22-ны байдлаар Нийслэл, дүүргийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 2022 онд хэрэгжүүлэх Арга хэмжээний төлөвлөгөө, Нийслэлээс, дүүргээс дэвшүүлсэн зорилтын жилийн биелэлтийг ханган тухай бүрт нь мэдээ, ярилцлага, постер мэдээ, видео контентуудыг цувралаар бэлтгэн дүүргийн албан ёсны веб сайт <a href="http://www.SHD.mn">www.SHD.mn</a>, сошиал фэйсбүүк пэйж хаяг “Сонгинохайрхан дүүрэг, Сонгинохайрхан дүүргийн онцгой комисс”, дүүргийн Засаг дарга “Н.Алтаншагай” гэсэн пэйж хаягуудаар өдөр болгон олон нийтэд хүргэн ажилласан. Мөн Сонгинохайрхан дүүргийн 30 жилийн ойн хүрээнд дүүргийн брэндбүүкийг бүтээлгэж, хүүхдийн баярыг тохиолдуулан зохион байгуулсан “Хүүхдийн инээмсэглэл” арга хэмжээ болон “Бид юу сурав”, “Илүүдэл жингүй эртэч Монгол” аяны хаалт, Бумбатын рашаанд мод тарих, Түүх, нийгмийн ухааны багш нарын эрдэм шинжилгээний бага хурал, “Бүтээлч багш-Шилдэг бүтээл”, “Хүүхдийн инээмсэглэл” нэгдсэн арга хэмжээ, “Нүүдэлчин соёлын фестивал”, “Зөв өглөө” уулзалт, “Сонгинохайрхан гоёл” загварын шоу, шалгаруулах арга хэмжээ, хороо тус бүр дээр хийгдэж байгаа бүтээн байгуулалт, дүүргийн 30 жилийн ойн хүрээнд түүхэн баримтат кино, сэтгүүл, гэрэл зургийн үзэсгэлэн гэх мэт ЗДТГ-аас зохион байгуулсан бүх үйл ажиллагаанд оролцон олон нийтэд хэвлэл, мэдээллийн хэрэгслээр 720 гаруй мэдээг дамжуулан түгээсэн.</p>	
7	11.1.7. Мэдээллийн сан, компьютер техникийн засвар	-	Компьютер, тоног	51 компьютер, 29 принтер, тоног	Ажиллах нөхцөл	Засаг даргын Тамгын газар, хороодын интернэтийн сүлжээний хэвийн, аюулгүй байдлыг хангах, шилэн кабелийн эвдрэл гэмтэлийг тухай бүр тогтоож, засвар	100%

	үйлчилгээг хариуцаж ажиллах		төхөөрөмжийн тоо	төхөөрөмж засварласан.	хангагдсан байх	үйлчилгээг шуурхай хийж байна. Албан хаагчдын өдөр тутмын хэрэглээнд Teamviewer, Anydesk программ ашиглан интернэтээр 69 компьютер, 39 принтерийн driver, шаардлагатай программ хангамжийг суулгасан. Тоон гарын үсэгт холбогдох 18 албан хаагчид албаны имэйл домэйн хаяг нээж, холбогдох баримт бичгийг Үндэсний дата төвд хүргүүлсэн. “Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль”-ийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд дүүргийн Засаг даргын Тамгын газар, хороодын албан хаагчдын ажлын цаг бүртгэлийн ZKТесо. Ver-16.2.24 загварын 28 бүртгэлтэй төхөөрөмжийн мэдээллийг форматалж акталсан. Засгийн газрын 2013 оны 411 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Мэдээллийн ил тод байдлыг хангах нийтлэг журам"-д заасан мэдээллийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр Тамгын газрын хэлтэс, тасаг, хороодын 21 албан хаагчид заавар, зөвлөгөө өгсөн. Тамгын газар, хороодын албан хаагчдын 28 компьютерт windows 10 pro үйлдлийн систем суулган, мэдээллийг аюулгүй зөөвөрлөж, 36 принтерийн засвар үйлчилгээг хийж хэвийн үйл ажиллагаанд оруулсан.	
8	11.1.8. Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг хуульд заасан хугацаанд хүлээн авч, хяналт тавих, баталгаажуулах, заавар зөвлөгөө өгөх, тайлан мэдээг үнэн зөв гаргаж, холбогдох байгууллагад мэдээлэх	-	Мэдүүлэг гаргах албан тушаалтан, тоо	2021 онд 196 албан тушаалтны мэдүүлгийг баталгаажуул	2-р сарын 15	Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлд заасан төрийн байгууллагын хэрэгжүүлэх нийтлэг үүргийн хүрээнд дүүргийн Засаг даргын Тамгын газар, түүний харьяа байгууллагад 2021 оны шинэчилсэн мэдүүлэг гаргавал зохих 184, тухайн албан тушаалт томилогдсон өдрөөс хойш 30 хоногийн дотор мэдүүлэг гаргасан 57 албан хаагчийн мэдүүлгийг бүртгэж баталгаажуулсан. Түүнчлэн хөрөнгө орлогод нь их хэмжээний өөрчлөлт орсон 4, ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн 403, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг хянуулсан 54 албан тушаалтны мэдүүлгийг цахимд бүртгэж баталгаажуулсан.	100%
<b>Зорилт 11.2 Төрийн үйлчилгээний шат дамжлагыг бууруулж, мэдээллийн техник технологийг сайжруулан “Цахим дүүрэг” хөтөлбөрийг хэрэгжүүлж, мэдээллийг цахимаар солилцох боломжийг бүрдүүлнэ.</b>							

9	11.2.1. Засаг даргын Тамгын газарт ирсэн, явуулсан бичгийн бүртгэл шийдвэрлэлтэнд хяналт тавин, баримт бичгийн эргэлтийн мэдээг сар тутамд гаргаж танилцуулах	-	Ирсэн, явуулсан бичгийн тоо, шийдвэрлэлт	Засаг даргын Тамгын газарт ирсэн бичиг 7195, явсан бичиг 2607 тус тус байна	Зөрчлийн тоо буурсан байх	Засаг даргын Тамгын газарт 6800 албан бичиг ирснээс хугацаандаа шийдвэрлэсэн 6244, хариугүй албан бичиг 6378, шийдвэрлэх шатандаа 133 албан бичиг, УИХ, Ерөнхийлөгчийн Тамгын газар, Засгийн Газрын хэрэг эрхлэх газар болон холбогдох дээд шатны байгууллагууд, харьяа газар, агентлаг, хэлтэс, албадад 2385 албан бичиг явуулснаас хариутай 470, хариугүй 1915 албан бичиг тус тус байна. Жилийн эцсийн байдлаар Засаг даргын Тамгын газрын хэмжээнд явсан бичгийн шийдвэрлэлт 93,99 хувьтай байна. Систем дэх ирсэн бичгийн шийдвэрлэлт, зөрчлийн мэдээг Тамгын газрын хэлтэс, тасгийн дарга нарын шуурхайд 14 хоног тутам, дүүргийн удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнд улирал тутам 1 удаа танилцуулж, хэрэгжилтийг ханган ажиллалаа.	100%
10	11.2.2. Албан хэрэг хөтлөлтийн систем /Edoc.ub.gov.mn/-д бүртгэлтэй байгууллагуудын албан бичгийн шийдвэрлэлт, зөрчлийн байдалд хяналт тавьж ажиллах	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь, тоо	156 байгууллага нэвтэрч 58353 албан бичиг бүртгэгдсэн	Зөрчлийн тоо буурсан байх	Дүүргийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын /erp.ulaanbaatar.mn/ албан хэрэг хөтлөлтийн "Edoc" системд дүүргийн хэмжээнд 166 байгууллага нэвтэрсэн. 2022 оны жилийн эцсийн байдлаар Edoc системээр дүүргийн хэмжээнд нийт 60346 албан бичиг бүртгэгдсэнээс хариутай 11150, хариугүй 49196 бүртгэгдсэн. Бичгийн шийдвэрлэлтийн дундаж 99.8%, шийдвэрлэлтийн дундаж хоног 5 байна. Байгууллагуудын систем ашиглалт, албан бичгийн шийдвэрлэлт, зөрчлийн байдалд өдөр бүр хяналт тавьж зөрчил гаргасан байгууллагад 03/1852 дугаартай албан бичгээр үүрэг даалгавар өгч ажилласан. 2021 онтой харьцуулахад 2022 оны 11 сарын байдлаар 60346 албан бичиг бүртгэгдсэнээс зөрчил 68,2%-иар буурсан үзүүлэлттэй ажилласан. Байгууллагад ирсэн албан бичгийг хугацаанд нь бүртгэж, удирдлагын цохолтыг дэлгэрэнгүй хөтөлж, холбогдох албан тушаалтанд хугацаанд нь шилжүүлж, MNS 5140-2:2021 стандартын 5.23 дахь заалтын дагуу албан бичиг хүлээн авсан бүртгэл хийсэн.	100%
11	11.2.3. Засаг даргын Тамгын газрын байнга хадгалах баримтыг цахим	-	Цахим, тоон хэлбэрт шилжүүлсэн	1997-2019 оны 3185 баримт бичгийг цахим	Цахим сан хөмрөг бүрэн	Дүүргийн Засаг даргын захирамж 3122 хуудас, Тамгын газрын даргын тушаал 849 хуудас цаасан суурьтай баримтыг цахим хэлбэрт шилжүүлж, төрийн архивын нэгдсэн мэдээллийн санг баяжуулсан. Засаг даргын	100%

	хэлбэрт шилжүүлэх ажлыг үргэлжлүүлэх		баримтын тоо	тоон хэлбэрт шилжүүлсэн	үүссэн байх	Тамгын газрын даргын 2022 оны 02 дугаар сарын 09-нд баталсан “Засаг даргын Тамгын газрын хэлтэс, тасгийн ажилтнуудаас 2021 онд хөтлөгдөж дууссан баримтыг хүлээн авах хуваарь”-ийн дагуу 12 хэлтэс, тасгийн байнга хадгалах 77, түр хадгалах 837, 70 жил хадгалах 5, нийт 919 хадгаламжийн нэгжийг “Баримт хүлээлцсэн акт”-аар хүлээн авсан. Дүүргийн 151 байгууллагын архивын 306 хадгаламжийн нэгжийн 12509 баримтын 23883 хуудас албан бичгийг нягтлан үзэж, батлан шалгалтыг хийсэн. Засаг даргын Тамгын газрын архивын баримтад тоо бүртгэлийн үндсэн болон туслах баримт бичгийг зааврын дагуу хөтөлж эрдэм шинжилгээ, техник боловсруулалтын ажлыг хийсэн. Үүнд: <ul style="list-style-type: none"> <li>- Байнга хадгалах 2015-2021 оны 772 хадгаламжийн нэгж,</li> <li>- Байгууллага дээр байнга хадгалах 26 хадгаламжийн нэгж,</li> <li>- 70 жил хадгалах 1992-2021 оны 160 хадгаламжийн нэгж,</li> <li>- Түр хадгалах 2009-2021 оны 5353 хадгаламжийн нэгж,</li> <li>- Устгах баримтын жагсаалтын 2009-2021 оны 1865 хадгаламжийн нэгж нийт 8176 хадгаламжийн нэгжийн бүртгэлийг шинэчлэн боловсруулж батлуулах ажлыг хийж байна.</li> </ul> Нөхөн бүрдүүлэлт хийсэн 107 байгууллагын нийт 9323 хадгаламжийн нэгж Спорт хорооны Архив №1, Архив №2 сан хөмрөгд хадгалагдаж байна.	
12	11.2.4. Дүүрэг, хороодын Нэг цонхноос төрийн архивын лавлагаа, мэдээллээр үйлчлэх	-	Лавлагаа, мэдээлэл олгосон иргэдийн тоо	213 иргэнд лавлагаа, мэдээлэл олгосон.	250 иргэн	Архивд хадгалагдаж буй эх баримт, цахим мэдээллийн сангаас иргэн, хуулийн этгээдэд 295 баримтын лавлагаа олгосон. Архивын лавлагаа, хуулбар олгосон бүртгэлийг хавсралтын дагуу хөтөлсөн. Байгууллагын ажлын хэрэгцээнд 430 хадгаламжийн нэгжийг ашигласан. Архивын өрөө, тасалгаанд тавигдах шаардлагын дагуу хадгаламжийн сангийн чийг, дулааны горимыг 7 хоногт 1 удаа хэмжиж, чийгтэй цэвэрлэгээг 14 хоногт 1 удаа хяналт тавин цэвэрлүүлж, бүртгэл хөтөлж хэвшсэн.	100%
13	11.2.5. Дүүргийн удирдах албан тушаалтнуудын	-	Иргэдийн тоо	21 иргэний уулзалтын	12 удаагийн уулзалт	Нийслэлийн Засаг даргын 2018 оны А/1212 дугаар захирамжаар батлагдсан “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын удирдах албан	100%



	иргэдтэй хийх уулзалтыг тогтмолжуулах			хүсэлтийг хүлээн авсан	зохион байгуулах	тушаалтнуудын иргэдтэй хийх уулзалтыг зохион байгуулах журам"-ын хүрээнд дүүргийн удирдлага иргэдтэй хийх уулзалтын хуваарийг шинэчлэн батлуулж, нийт 15 удаагийн уулзалтаар 134 иргэдийг хүлээн авч асуудлыг газар дээр шийдвэрлэх, хариуг хуулийн дагуу өгөх арга хэмжээг зохион байгуулсан. Уулзалтыг хуваарийн дагуу тогтмол зохион байгуулж, тавьсан санал хүсэлтийн тэмдэглэлийг хөтлөн, хэлтсийн даргаар баталгаажуулж, хэрэгжилтийн явцыг удирдлагад танилцуулсан. Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг даргын Тамгын газрын хамтран зохион байгуулсан "Иргэн таныг сонсьё" уулзалтыг 2022 оны 10 дугаар сарын 17-ны өдрөөс 10 дугаар сарын 23-ны хооронд зохион байгуулсан. Уулзалтад 15 мянган орчим иргэд оролцож, иргэдээс гарсан 1200 гаруй саналыг 8 бүлэгт ангилж, нэгтгэн УИХ-ын гишүүд, Нийслэл, дүүргийн ИТХ-ын Төлөөлөгчид, холбогдох байгууллагад албан бичгээр хүргүүлсэн.	
14	11.2.6. Иргэд байгууллагаас албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг бүх талаас нь нягталж судлан, хууль зүйн үндэслэлтэй нэг мөр эцэслэн шийдвэрлэж, хуулийн хугацаанд нь хариу өгөх, шуурхай зохион байгуулах арга хэмжээ авч ажиллах.	-	Шийдвэрлэсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийн тоо	2021 онд 7 хоног 20 цаг 08 минут	Шийдвэрлэлтийн дундаж хугацааг багасгах	Дүүргийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний харьяа байгууллагууд, Засаг даргын Тамгын газрын хэлтэс тасгуудад иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг "UB ERP" системээр хүлээн авч шийдвэрлэж байна. 2022 оны 11 дүгээр сарын байдлаар нийт 5745 өргөдөл гомдол ирснээс 5642 буюу 98 хувийг хуулийн хугацаанд нь шийдвэрлэж, 103 буюу 1 хувь нь шийдвэрлэх шатандаа, 55 өргөдөл, гомдлыг хугацаа хэтэрч шийдвэрлэсэн. Өргөдөл, гомдлыг шийдвэрлэх хугацаанд нийт 2868 зөрчлийг дараах байгууллагууд гаргасан байна. Үүнд: Сургууль 605 зөрчил, Хороод 405 зөрчил, Нийгмийн даатгалын хэлтэс 383 зөрчил, Засаг даргын Тамгын газар 366 зөрчил, Цагдаагийн газар 210 зөрчил, Иргэдийн Төлөөлөгчдийн хурал 205 зөрчил, Эрүүл мэндийн байгууллага 111 зөрчил, Мэргэжлийн хяналтын хэлтэс 83 зөрчил, Татварын хэлтэс 77 зөрчил,	90%

					Цагдаагийн 1 дүгээр хэлтэс 74 зөрчил, Улсын бүртгэлийн хэлтэс 74 зөрчил, Албан бус-Насан туршийн боловсролын төв 72 зөрчил, Цагдаагийн 3 дугаар хэлтэс 66 зөрчил, Бусад байгууллага 137 зөрчил гаргаж шийдвэрлэсэн байна. Иргэдийн гаргасан өргөдөл, гомдолд шийдвэрлэх явцад дараах нийтлэг зөрчил, дутагдлыг гаргаж байна. Үүнд: Өдөрт нь багтаан хүлээж аваагүй 2303, явцын тэмдэглэл хөтлөөгүй 346, өдөрт нь багтаан шилжүүлээгүй 188, буцаалтыг 3 хоногт багтаан хүлээн аваагүй 27, Файл хавсаргаагүй 1, бусад 3 зөрчил тус тус бүртгэгдсэн байна. Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн байдал: Иргэний талд шийдвэрлэсэн -4278 Боломжгүй гэж хариу өгсөн-933 Бусад -396 өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн. Өргөдөл, гомдол албан бичгийн шийдвэрлэлтийн мэдээг долоо хоног бүр гаргаж, удирдлагад танилцуулан ажиллаж байна. Удирдлагын 7 удаагийн шуурхай хуралдаанд өргөдөл, гомдлыг анхаарч ажиллах талаар үүрэг өгч, өргөдөл, гомдол шийдвэрлэлтийг сайжруулахаар Тамгын газрын даргын 3 удаагийн чиглэл, заавар, арга зүйн зөвлөмжийг харьяа байгууллагад хүргэж ажилласан.		
15	11.2.7. 16, 40, 42 дугаар хороодын цогцолбор байрыг ашиглалтад оруулах, 39, 43 дугаар хорооны газрын асуудлыг шийдвэрлэж, барилгын ажлыг эхлүүлэх	2,300.6 Улсын төсөв 4,218.9 Нийслэлийн төсөв	Ашиглалтад орох барилга, тоо	16, 40, 42-р хорооны цогцолбор байрны ажлын гүйцэтгэл 30-80 хувьтай байна	3	Улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар дүүргийн 16, 40, 42 дугаар хорооны цогцолбор байруудын барилгын ажлыг гүйцэтгэж байна. 2022 оны 12 дугаар сарын байдлаар 16 дугаар хорооны цогцолбор байр 90%, 39 дүгээр хорооны цогцолбор байрын барилгын ажлын гүйцэтгэл 30%, 40 дүгээр хорооны цогцолбор байр 30%, 42 дугаар хорооны цогцолбор байр 65% -ийн гүйцэтгэлтэй байна. 43 дугаар хорооны цогцолбор байрыг барих тендер сонгон шалгаруулалтад “Алтайн шар говь” ХХК шалгарсан гэрээ байгуулж, газар чөлөөлөлт хийгдсэн.	50%
16	11.2.8. НЗДТГ-аас хэрэгжүүлж буй "Нэг тархи-Нэгдсэн систем-" төслийн	20.0 Дүүргийн төсөв	Батлуулах төсөл, тоо	"Хаан банк", "Кевико" ХХК, дүүргийн Нэгдсэн	1	УИХ-ын 2021 оны "Шинэ сэргэлтийн бодлого батлах тухай" 106 дугаар тогтоол, Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичиг "Алсын хараа-2050", Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2015 оны 30/24 дүгээр	30%

	хүрээнд "Цахим дүүрэг" төслийг боловсруулж, батлуулах			эмнэлэгийн серверийн өрөөний шийдлүүд, дотоод сүлжээний талаар судалгаа хийсэн.		тогтоол, дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, "Цахим үндэстэн" дунд хугацааны зорилтод хөтөлбөр, нийслэлийн Засаг даргын Тамгын газраас хэрэгжүүлж буй "Нэг тархи-Нэгдсэн систем" төслийн хүрээнд "Цахим дүүрэг" төслийг боловсруулж дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн барьсан.	
17	11.2.9. Авлигын эсрэг хууль тогтоомж, үндэсний хөтөлбөр болон АТГ-аас хэрэгжүүлж буй үйл ажиллагааг сурталчлах, ил тод байдлыг хангах, хэвлэмэл болон зурагт хуудас хэвлүүлэн тараах, мэдүүлэг гаргагч албан тушаалтанд арга зүйн зөвлөмж өгөх, сургалт зохион байгуулах	10.0 Дүүргийн төсөв	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	"Зөв зөвд, шударга зөв" аяны танилцуулах шторк болон бусад зурагт хуудсыг www.shd.mn, 5 хорооны фэйсбүүк хуудсанд байршуулж 17254 хүний хандалт авсан.	100	"Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр"-ийг дүүргийн хэмжээнд хэрэгжүүлэх 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 6 бүлэг, хэрэгжүүлэх 20 ажлын хүрээнд боловсруулан батлуулж дараах ажлуудыг зохион байгуулан ажилласан. Үүнд: Ёс зүйн зөрчилгүй хамт олон аяныг дүүргийн нутгийн захиргааны 158 байгууллагын дунд 1 сарын хугацаатай зарлаж, үр дүнг тооцон ажилласан; Төрийн албан хаагчийг авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, авлигыг үл тэвчих үзэл, авлигын эсрэг боловсролыг дээшлүүлэх зорилгоор сургалт, сурталчилгааны ажлуудыг зохион байгуулсан. 2022 онд Хууль зүй, дотоод хэргийн яам, Авлигатай тэмцэх газар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, дүүргийн Прокурорын газар, дүүргийн Цагдаагийн газар, төрийн бус байгууллагуудтай хамтран 4 удаагийн сургалтыг зохион байгуулсан. Сургалтад нийт 562 төрийн албан хаагч, хэсгийн ахлагч хамрагдсан. Авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, иргэдэд зөвлөгөө, мэдээлэл өгөх, сурталчлах зорилгоор АТГ-аас бэлтгэн гаргасан зураг хуудас, тараах материалыг иргэдэд хүргэж ажилласан. Энэ ажлын хүрээнд 15 төрлийн 2385 сурталчилгааны материалыг хувилж тараасан. "Авлигатай тэмцэх газар", "АТГ-Олон нийтийн төв" пэйж хуудсуудад төрийн өмчийн 159 байгууллагын төрийн албан хаагчид нэгдэж, мэдээ, мэдээллээр хангагдах боломжийг бүрдүүлсэн.	100%
18	11.2.10. Ажилд шинээр орсон албан хаагчдад зориулсан дасан зохицох, чиглүүлэх	30.0 Дүүргийн төсөв	Боловсруулах гарын авлага, сургалт, тоо	Авлигатай тэмцэх газартай хамтран авлигаас урьдчилан сэргийлэх тухай	3	Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагаанд Олон Улсын Чанарын Менежментийн Тогтолцоо ISO 9001:2015 стандартыг 2021 оноос нэвтрүүлж, Дотоод аудитын гэрчилгээ, Олон улсын баталгаажуулалтын гэрчилгээг 2022 онд авсан. Стандарт нэвтэрсэнтэй холбогдуулан	90%

	хөтөлбөрийг боловсруулж батлуулах, хөдөлмөр эрхлэлттэй холбоотой болон хууль эрх зүйн гарын авлага бэлтгэн тараах			онлайн сургалтыг шинээр томилогдсон 39 албан хаагчдад зохион байгуулсан		“Шинэ ажилтныг дадлагажуулах хөтөлбөр”-ийг 2022 оны 4 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжүүлж, төрийн захиргааны албан тушаалд шинээр томилогдсон 19, төрийн үйлчилгээний албан тушаалд томилогдсон 15, нийт 34 албан хаагчийг хөтөлбөрт хамруулсан.	
19	11.2.11. БНСУ-ын Сөнбук, Канбук дүүрэг, БНХАУ-ын Хөлөнбуйр аймгийн Хайлаар хоттой хамтын ажиллагааг бэхжүүлэх	50.0 Дүүргийн төсөв	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	Сөнбук дүүргийн Засаг даргаас ирүүлсэн хүсэлтийг хүлээн авч хариу илгээсэн. 3 улсын үзэсгэлэн худалдааны нээлтийн үйл ажиллагаанд онлайнаар оролцсон.	100	БНСУ-ын Сөүл хотын Канбук дүүргийн Засаг дарга Пак Кём Сү тэргүүтэй төлөөлөгч(11)-д 2022 оны 05 дугаар сард Сонгинохайрхан дүүрэгт албан ёсны айлчлал хийсэн. Айлчлалаар 2 дүүргийн хамтын ажиллагааг бэхжүүлэх, соёлын солилцооны хөтөлбөр хэрэгжүүлэх, эрүүл мэнд, боловсролын салбарын хамтын ажиллагааг өргөжүүлэх талаар санал солилцож, дүүргийн Нэгдсэн эмнэлгийн үйл ажиллагаатай танилцсан. БНХАУ-ын Хөлөнбуйр аймгийн Хайлаар хот, Сонгинохайрхан дүүрэг эгч дүүргийн харилцаа тогтоосны 10 жилийн ой 2022 онд тохиож байгаатай холбогдуулан 12 дугаар сард цахим уулзалтыг зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хангаж байна.	70%
20	11.2.12. Завхан, Дорноговь аймгийн Дэлгэрэх сумтай байгуулсан хамтын ажиллагааг бэхжүүлж, Хэнтий аймгийн ЗДТГ-тай "Санамж бичиг" байгуулж, туршлага судлах	5.0 Дүүргийн төсөв	Санамж бичиг, тоо	2021 оны 8-р сард "Хамтын ажиллагааны санамж бичиг"-ийг байгуулж, харилцан туршлага солилцсон.	3	Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын Засаг даргын Тамгын газар, Завхан аймгийн Их-Уул сумын Засаг даргын Тамгын газартай шинэ харилцаа тогтоох, харилцан сайн туршлагыг нэвтрүүлэх зорилгоор "Хамтын ажиллагааны санамж бичиг"-ийг 2021 онд байгуулсан. Энэхүү санамж бичгийн хүрээнд Завхан аймгийн Их-Уул сумын Засаг даргын Тамгын газрын дарга тэргүүтэй 44 албан хаагч 2022 оны 10 дугаар сарын 26, 27-ны өдрүүдэд Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газар, дүүргийн 15, 31 дүгээр хороо, өрхийн эрүүл мэндийн төв, Ерөнхий боловсролын 9, 154, 65 дугаар сургууль, 91, 101 дүгээр цэцэрлэгийн үйл ажиллагаатай танилцсан.	70%
<b>Хэсгийн дундаж хувь</b>							<b>89.5%</b>

**ДӨРӨВДҮГЭЭР ХЭСЭГ.**

**ХУУЛИАР ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ**

№	Дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 2021 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
<b>ЗОРИЛГО 12. ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ТАВЬЖ ОЛОН НИЙТЭД ТӨСӨВ, САНХҮҮГИЙН ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫГ ХАНГУУЛАХ</b>							
<b>Зорилт 12.1. Мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хангах чиглэлээр:</b>							
1	12.1.1. Төрийн болон орон нутгийн орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангаж ажиллах	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	Тендерийн зарыг <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> <a href="http://www.shd.mn">www.shd.mn</a> цахим хуудсанд 223 удаа, “Үндэсний шуудан” сонинд 97 удаа явцын мэдээ, үр дүнг нийтлэн байршуулж, ил тод байдлыг хангасан.	100 хувь цахим хэлбэрээр зохион байгуулж, ил тод нээлттэй байдлыг хангах	2022 онд Улсын төсвийн хөрөнгө, Нийслэлийн төсвийн хөрөнгө, Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө, Дүүргийн төсөв, Дүүргийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө, бусад эх үүсвэрээр нийт 87,984,067,500 төгрөгийн төсөвт өртөг бүхий 171 төсөл арга хэмжээнээс 150 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгууллан ажиллаж байна. <ul style="list-style-type: none"> <li>✓ Гэрээ хийгдсэн 94 төсөл арга хэмжээ;</li> <li>✓ Гэрээ байгуулах эрх олгосон 12 төсөл арга хэмжээ;</li> <li>✓ Тендерийн материал хүлээн авч байгаа 24 төсөл арга хэмжээ;</li> <li>✓ Үнэлгээ хийгдэж байгаа 1 төсөл арга хэмжээ;</li> <li>✓ Тендерийн материал боловсруулагдаж байгаа 2 төсөл арга хэмжээ;</li> <li>✓ Зураг төсөв, ажлын даалгавар ирээгүй, газрын асуудалтай 17 төсөл арга хэмжээ;</li> <li>✓ Захиалагчид албан бичгээр хүргүүлсэн 11</li> <li>✓ Шууд худалдан авалт зохион байгуулахаар захиалагчид хүргүүлсэн 4</li> </ul>	100%

					<p>✓ Захирамжаар хүчингүй болсон 6 төсөл арга хэмжээний хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p> <p>2022 оны төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг 100 хувь tender.gov.mn цахим системээр зохион байгуулан ажиллаж байна.</p> <p>Улс, нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа худалдан авах ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах зорилгоор тендерийн урилгыг <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> сайтад 291 удаа, Өглөөний сонин, Үндэсний шуудан сонингуудад 70 удаа, Дүүргийн <a href="http://www.shd.mn">www.shd.mn</a> сайтад 291 удаа тус тус байршуулан олон нийтэд мэдээлэн ажиллаж байна.</p> <p>Нийт 150 төсөл арга хэмжээг 291 удаа зарлаж, үр дүнг <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> сайтад, мөн гэрээ байгуулагдсан 94 төсөл арга хэмжээний гэрээг олон нийтэд ил тод нээлттэйгээр мэдээлэн ажилласан.</p>		
2	12.1.2. Төсөвт болон орон нутгийн өмчит байгууллагуудын санхүүгийн холбогдох мэдээллүүдийг цаг хугацаанд нь <a href="http://www.shilendans.gov.mn">www.shilendans.gov.mn</a> цахим хуудсанд байршуулах ажлыг зохион байгуулах.	-	Мэдээллийн тоо, хугацаа	109 байгууллага <a href="http://www.shilendans.gov.mn">www.shilendans.gov.mn</a> цахим хуудсанд 15 төрлийн мэдээ, мэдээлэл байршуулсан.	Мэдээллийг тогтсон хугацаанд нь байршуулсан байх	Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолын дагуу төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний болон харьяа 101 байгууллагууд /сургууль 27, цэцэрлэг 61, орон нутгийн болон бусад 13/ төсөв, санхүүгийн ил тод, нээлттэй байдлыг ханган шилэн дансны цахим системд мэдээллээ байршуулсан байна. Холбогдох хууль тогтоомжид заасны дагуу цахим системд байршуулах 15 төрлийн мэдээллийг 35 байгууллага хуулийн хугацаанд, 3 байгууллага хугацаа хоцроон байршуулсан байна	90%
3	12.1.3. Хүний нөөцийн ил тод байдлыг хангаж, сул орон тооны зарыг хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон дүүргийн <a href="http://www.shd.mn">www.shd.mn</a> цахим хуудсанд мэдээллийг тогтмол байршуулах	-	Байршуулсан мэдээллийн тоо	Хүний нөөцийн ил тод байдалтай холбогдолтой 19 мэдээ, мэдээллийг дүүргийн <a href="http://www.shd.mn">www.shd.mn</a> цахим хуудсанд байршуулсан.	24	Дүүргийн <a href="http://www.shd.mn">www.shd.mn</a> цахим хуудсанд төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан тушаалын сул орон тооны мэдээллийг 6, Засаг даргын Тамгын газар, хороодын албан хаагчдын пэйж хуудсаар 24 удаа байршуулан ажиллалаа. <p>Дүүргийн Засаг даргын Тамгын газраас 2022 онд төрийн захиргааны нийт 110 /давхардсан тоогоор/ сул орон тоо гарсныг 3 удаагийн захиалгаар Төрийн албаны зөвлөлийн Нийслэл дэх салбар зөвлөлд хүргүүлж, шалгалтад тэнцсэн 64 албан хаагчдыг Төрийн албаны зөвлөлийн Нийслэл дэх салбар зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн хуулийн дагуу томилон ажиллуулж байна.</p>	90%

						Мөн төрийн захиргааны албан тушаалаас гадна төрийн үйлчилгээний 14 /давхардсан тоогоор/ албан тушаалын зар мэдээллийг байршуулан иргэдийн судалж, шаардлага хангасан иргэнийг томилсон.	
<b>Зорилт 12.2. Гэмт хэрэг зөрчлийг бууруулахад иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, архи дан согтуурах, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, бууруулах ажлыг үе шаттай зохион байгуулна.</b>							
4	12.2.1. Архины хамааралтай, гэр оронгүй, тэнэмэл иргэдийн амь нас эрсдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор холбогдох байгууллагуудтай хамтран “Албадан эмчилгээ”, “Тэнэмэл” арга хэмжээг зохион байгуулж, иргэдэд зөвлөмж, мэдээлэл өгөх	8.0 Дүүргийн төсөв	Арга хэмжээнд хамрагдах иргэн, тоо	134	200	“Итгэл” төслийн хүрээнд зохион байгуулагдаж буй архины сайн дурын эмчилгээнд 164 иргэнийг сонгож, дүүргийн Нэгдсэн эмнэлэг, Наркологийн эмнэлгийн эмчийн үзлэгт оруулж, “Цагаан өргөө” сувиллын газарт хүргэж өгч, сэтгэц, нийгмийн нөхөн сэргээх эмчилгээнд хамруулсан. Бүлэг бөөгнөрөл үүсгэж архи дан согтуурдаг 18 иргэнийг “Зөв амьдрах ухаан” ТББ-тай хамтран эмчийн үзлэгт хамруулан, бүртгэл судалгаанд авч ажилласан. “Тэнэмэл” арга хэмжээг үе шаттайгаар 4 удаа зохион байгуулж Нийгмийн халамжийн төвд орон гэргүй нийт 80 иргэнийг хүлээлгэн өгч, 40 иргэнийг сүрьеэгийн эрт илрүүлэг оношлогоонд оруулж ажилласан. Ар гэртээ түгшүүр төрүүлдэг, удаа дараа согтуугаар зөрчил гаргасан 57 иргэнийг архины албадан эмчилгээнд хамруулсан. Дүүргийн Улаан загалмайн хороотой хамтран 78 иргэнийг НХТТ-д сүрьеэгийн үзлэг шинжилгээнд хамруулж, сүрьеэгээр өвчилсэн 1 иргэнийг “Энэрэл” эмнэлэгт хүргэж ажилласан.	100%
5	12.2.2. Дүүргийн нутаг дэвсгэрт гэр бүлийн хүчирхийлэл өртөх эрсдэлтэй гэр бүл, хүчирхийлэл үйлдэж болзошгүй хүмүүст тавих хяналтыг сайжруулах нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээ зохион байгуулах	12.0 Дүүргийн төсөв	Зохион байгуулах арга хэмжээ, тоо	2 удагийн өдөрлөгийн арга хэмжээ зохион байгуулж, 5 төрлийн 1500 ширхэг гарын авлага тараасан.	4	Гэр бүлийн хүчирхийллийн шинжтэй иргэдээс ирүүлсэн дуудлага, мэдээллийн удаа давтамжийн тооноос шалтгаалан 2736 дуудлага, мэдээллийн талаар албан бичгээр холбогдох газруудад мэдээлж, 1780 дуудлага, мэдээлэлд хариу үйлчилгээ үзүүлсэн. Энэ онд гэр бүлийн хүчирхийллийн эрсдэлтэй айл өрхийг илрүүлэх, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж болзошгүй этгээдүүдэд тавих хяналтыг сайжруулах, сангийн бүртгэлд баяжилт хийх, удаа дараагийн давтамжтай, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж буй хүмүүсийг шинээр хяналтын бүртгэлд авч, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах зорилгоор “Хяналтын бүртгэл” тусгай арга хэмжээг 4 удаа зохион байгуулж, гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн 332 иргэнд биечлэн болон цахимаар хяналт тавьж, ар гэрээр нь хяналт тавьж 3 төрлийн асуумжийг авч, хяналтын хувийн	90%

						хэрэгт баяжилт хийж ажилласан. Тус газарт гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг 6 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 57.1 хувиар буурсан үзүүлэлттэй.	
6	12.2.3. Дүүргийн нутаг дэвсгэрт Замын хөдөлгөөний аюулгүй байдлын журмын эсрэг гэмт хэрэг, ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор алслагдсан замуудад дугаар илрүүлэгч, хурд хэмжигч бүхий хяналтын камер суурилуулах	-	Суурилуулах камер, тоо	0	2	Дүүргийн нутаг дэвсгэрт Замын хөдөлгөөний аюулгүй байдлын журмын эсрэг гэмт хэрэг, ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр дүүргийн 20 дугаар хорооны нутаг дэвсгэр Товчооны замд тээврийн хэрэгслийн хурд хэмжигч болон дугаар илрүүлэгч хяналтын камер байрлуулах ажлын төсвийг дүүргийн Засаг даргын 2022 оны А/513 дугаар захирамжаар шийдвэрлэсэн. Тус ажлын дагуу Замын хөдөлгөөний удирдлагын төвийн Мэдээлэл технологи, техник ашиглалтын хэлтсээс хурд хэмжигч камерын техникийн тодорхойлолтыг гаргуулан тендер зарлаж, гүйцэтгэгчээр "Оргил Дельта Трейд" ХХК шалгарч гэрээ байгуулсан. 12 дугаар сарын 14-нд суурилуулж хүлээлгэн өгөх гэрээ байгуулсан.	70%
7	12.2.4. 4, 8, 9, 13, 17, 19, 23, 25, 34, 37 дугаар хороодын нутаг дэвсгэрт камержуулалт хийх	413.6 ДОНХС	Суурилуулах камер, тоо	28 хороонд 224 ширхэг камерын засвар шинэчлэлтийн ажлыг "Ат юор сервис" ХХК хийж гүйцэтгэж хүлээлгэн өгсөн.	100	Халаасны хулгайн гэмт хэрэг ихээр үйлдэгдэж буй 14 цэгийн судалгааг гарган, хяналтын камерыг хяналтад авах ажлыг аж ахуйн нэгж байгууллагуудтай хамтран зохион байгуулан ажилласан. Уг ажлын хүрээнд 4 байршлын хяналтын камерын чиглэлийг өөрчилж автобусны буудал руу харуулан байршуулсан. Дүүргийн 8 дугаар хорооны нутаг дэвсгэрт гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор гудамж талбайд 6 ширхэг, 12, 14, 16 дугаар хорооны автобусны буудлуудын ойр орчимд Саппоро, Цамбагарав үйлчилгээний төв, 19 дүгээр байрны автобусны буудлуудад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 9 ширхэг камерыг байршуулсан. Дүүргийн 17, 19, 23, 34 дүгээр хороодын хяналтын теле камерын бүртгэлийг шинэчлэн гаргаж, эвдрэлтэй болон нэмэлтээр хяналтын теле камер тавих цэгүүдийг тодорхойлж засварласан. Дүүргийн 4, 37, 40, 41, 42 дугаар хороодын нутаг дэвсгэрт байрлах эмзэг цэгүүдэд нийт 18 хяналтын камер шинээр байршуулахаар холбогдох газарт хүргүүлсэн.	70%
8	12.2.5. Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг томоохон зах,	20.0 Дүүргийн төсөв	Суурилуулах камер, тоо	0	30	Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг томоохон зах, худалдааны төв, үйлчилгээний газруудтай гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр байгуулсан "Түншлэлийн гэрээ"-ний хүрээнд 75 аж ахуй нэгж	100%



	худалдааны төв, үйлчилгээний газрын орчимд хяналтын камер байрлуулж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд ашиглах					байгууллага, 30 теле камер шинээр байршуулсан. Иргэд, аж ахуй нэгж байгууллагатай гэрээ байгуулан ойр орчмын 50-аас 100 метр орчим газрыг хянах чадвартай MNS6423:2019 стандартын камер 84 ширхэг сольж байршуулсан. Саппоро үйлчилгээний төвийг хянасан 2 камерыг байршуулж, хэсгийн байцаагчийн өрөөнөөс хянаж гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр ажиллаж байна. Драгон худалдааны төв болон Авто тээврийн нэгтгэлээс ойр орчмын гудамж талбайдаа 7 камер байрлуулсан.	
<b>Зорилт 12.3. Орон нутгийн санхүүгийн хараат байдлыг багасган бие даан хөгжих нөхцөлийг дээшлүүлж, татварын орлогыг нэмэгдүүлнэ.</b>							
9	12.3.1. Технологийн дэвшлийг ашиглан татвар төлөх, тайлагнах талаарх мэдлэг олгох сургалтыг татвар төлөгчдөд цахимаар болон танхимаар зохион байгуулж, цахим татвар төлөлтийн хувийг нэмэгдүүлэх	30.0 Дүүргийн төсөв	Цахим төлөлт, хувь	43	60	2022 оны төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг жигд ханган, орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх ажлыг шат дараатай зохион байгуулж, улсын төсөвт 34,3 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 34,5 тэрбум төгрөг буюу 100,9%, нийслэлийн төсөвт 13,0 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 15,0 тэрбум төгрөг буюу 115,4%, дүүргийн төсөвт 65,4 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 65,5 тэрбум төгрөг төвлөрүүлж 100%-ийн гүйцэтгэлтэй байна. “ХХОАТ-ын тайлан илгээх заавар, зөвлөгөө”, “ХХОАТ-ын хөнгөлөлт, чөлөөлөлтийн тайлан хэрхэн гаргах” тухай сургалтуудыг татвар төлөгчдөд тогтмол зохион байгуулж, дүүргийн нутаг дэвсгэрийн томоохон 21 зах, худалдааны төвүүдийн төлбөрийн баримт олголтын байдалд хяналт тавьж, төлбөрийн баримт хэвлэх болон тайлагналын талаар мэдээлэл зөвлөгөө өгч, и-баримт олголт хангалтгүй байгаа төвийн удирдлага, түрээслэгч нарт мэдэгдэх хуудас хүргүүллээ.Цахим төлбөрийн И баримт аппликейнаар 14,209 татвар төлөгчийн 66.7 сая төгрөг, GRAY аппликейнаар 28,996 татвар төлөгчийн 1.2 тэрбум төгрөг, Most Money аппликейнаар 4618 татвар төлөгчийн 3.5 тэрбум төгрөгийг дүүргийн төсөвт төвлөрүүлсэн.	100%
10	12.3.2. Газрын төлбөрийн нэхэмжлэхийг бүрэн үүсгэх, өмнөх онуудын нэхэмжлэхийг зөрчлийг арилгах	10.0 Дүүргийн төсөв	Төлөвлөгөөний биелэлт, хувь	61	90	Газрын төлбөрөөр 2022 оны жилийн эцсийн байдлаар 8.9 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 8.8 тэрбум төгрөгийг дүүргийн төсөвт төвлөрүүлж, 99.4%-ийн хүлээгдэж буй гүйцэтгэлтэй байна. 2022 онд газрын төлбөр татварын дундын мэдээллийн системд 70,126 хүчинтэй гэрээнээс 69,805 нэгж талбарт 9,112,600,400 төгрөгийн газрын төлбөр ногдуулж 61,725	70%

	замаар Газрын төлбөрийн орлогын төлөвлөгөөг биелүүлэх					иргэн, хуулийн этгээдэд 8,516,221,653 төгрөгийн нэхэмжлэл татварын системд үүсгэн ажиллаж байна. Нэхэмжлэх зөрүүтэй үүссэн 243 иргэн, 4 хуулийн этгээдийн бүртгэлийн зөрчлийг шийдвэрлүүлсэн. Газрын төлбөрөөр урьд оны болон тайлант онд өртэй иргэн, аж ахуйн нэгжид масс мессеж, мэдэгдэх хуудас, шаардах хуудас тогтмол хүргүүлж ажилласан.	
11	12.3.3. Үйлдвэр, үйлчилгээний зориулалттай үл хөдлөх эд хөрөнгийг бүртгэлжүүлж, татварт хамруулах ажлыг зохион байгуулах	10.0 Дүүргийн н төсөв	Төлөвлөгөөн ий биелэлт, хувь	60	80	Тус татварын төрлөөр дүүргийн төсөвт 4,6 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 3,1 тэрбум төгрөг төвлөрүүлж, 67%-ийн гүйцэтгэлтэй байна. Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварт бүртгэлгүй нийт 59 үл хөдлөх хөрөнгө бүртгэж, 144,6 сая төгрөгийн ногдол үүсгэж, нураагдсан барилга, орон сууцны зориулалттай байранд үйл ажиллагаа явуулж байгаад зогсоосон үл хөдлөх эд хөрөнгийн хасуулах хүсэлт өгсөн 17 иргэдийн материалыг шалган бүртгэлээс хасч, 36 иргэний үл хөдлөх хөрөнгийн мэдээллийг шилжүүлж, 351 үл хөдлөх хөрөнгийн ногдол дутуу үүссэнийг засварлан нийт 89,6 сая төгрөгийн ногдлыг нөхөж оруулсан. Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих ажлын хүрээнд дүүргийн Татварын хэлтсийн даргын 2022 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн А/58 дугаар тушаалаар дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа 20, 32 дугаар хорооны 30 иргэний 32 үл хөдлөх эд хөрөнгийг шинээр бүртгэлжүүлж, өмнөх 2019-2021 оны 53,1 сая төгрөг, 2022 оны 24,3 сая төгрөгийн ногдлыг нөхөн оруулсан. Тус татварын орлого нь нийслэлийн татварын дансанд төвлөрдөг байсныг дүүргийн дансанд төвлөрүүлдэг болсонтой холбоотойгоор татвар төлөлт удааширсан, мөн өмнөх оны өр төлбөртэй иргэд татвараа нийслэлийн татварын орлогын дансанд тушааж байгаатай холбоотой.	70%
12	12.3.4. Малын тоо толгойн албан татварын орлогын төлөвлөгөөг сар, улирал, жилээр жигд ханган биелүүлэх	5.0 Дүүргийн н төсөв	Төлөвлөгөөн ий биелэлт, хувь	0	90	Дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн “Малын тоо толгойн албан татварын хэмжээг тогтоох тухай” тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Статистикийн хэлтсээс гаргасан 2020 оны мал тооллогын дүнгээр нийт 80.712 толгой малаас 2022 онд малын тоо толгойн албан татвараар дүүргийн төсөвт 126,3 сая төгрөг төвлөрүүлэхээс 2022 оны жилийн эцсийн байдлаар 1582 малчин, мал бүхий этгээд,	50%

						аж ахуйн нэгж байгууллагаас 83,9 сая төгрөг төвлөрүүлж, 66,4 %-ийн гүйцэтгэлтэй байна. Малын тоо толгойн албан татвар хураах ажлыг эрчимжүүлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажиллах ажлын хүрээнд дүүргийн Татварын хэлтсийн даргын А/24 дүгээр тушаалаар ажлын хэсэг байгуулагдаж, дүүргийн 21, 32, 33, 34 дүгээр хорооны малын тоо толгой, малчин өрх, мал бүхий этгээдийг бүртгэлжүүлэх, QR код олгох, "Малын тоо толгойн албан татварын тухай хууль"-ийг сурталчлах, татвар төлөх, тайлагнах талаар 1064 гаруй малчин, мал бүхий этгээд, ААНБ-уудад нийт 32 удаагийн сургалт, сурталчилгааг хороодын Засаг дарга, хэсгийн ахлагч нартай хамтран зохион байгуулсан. Малын тоо толгойн албан татварын орлогын төлөвлөгөө тасарсан шалтгаан нь малын тоо толгойн албан татварын тухай хууль нь энэ онд шинээр хэрэгжиж эхэлсэн, малчид отор нүүдэл хийж, үндсэн хаяг дээрээ тогтвор суурьшилтай байдаггүй, мэдээ мэдээлэл аваагүй, уг татварын төрлийг цахимаар төлж эхлээгүй байгаатай холбоотой байна.	
13	12.3.5. Дүүргийн төсөв, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2022 онд хийгдэх ажлуудын хэрэгжилтийг зохион байгуулж, 2023 оны ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх ажлын санал асуулгыг зохион байгуулах	785.0 Дүүргийн төсөв 2,949.6 ДОНХС	Хэрэгжилтийг зохион байгуулах төсөл арга хэмжээ, тоо	2021 онд 21 төсөл арга хэмжээ	87	Дүүргийн Орон нутгийн төсвийн 785.0 сая төгрөг, орон нутгийн хөгжлийн сангийн 2.9 тэрбум төгрөгийн хөрөнгөөр нийт 106 төсөл арга хэмжээний бэлтгэл ажлыг ханган худалдан авах ажиллагааг зохион байгуулж байна. Үүнээс дууссан 86, ажил гүйцэтгэх шатанд 8, тендер зарласан 1, тендер зарлах шатанд 1, бусад 10 төсөл арга хэмжээ байна. Гүйцэтгэл 85 хувь. Дүүргийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2023 онд хэрэгжүүлэх ажлын саналыг 2022 оны 4 дүгээр сарын 15-аас 6 дугаар сарын 15-ны хооронд зохион байгуулж цаасаар 50,000, цахимаар 10,568 иргэний санал авсан.	90%
14	12.3.6. Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний болон харьяа байгууллагуудад Монгол Улсын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	98.5		Монгол улсын Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолын дагуу Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний болон харьяа 103 байгууллагууд /сургууль 28, цэцэрлэг 62, орон нутгийн болон бусад 13/ төсөв, санхүүгийн ил тод, нээлттэй байдлыг ханган, шилэн дансны цахим системд мэдээллээ байршуулсан. Шилэн дансны 4 дугаар улирлын нэгдсэн дүгнэлт 1 дүгээр сарын 15-нд гарна.3 дугаар улирлын байдлаар 61 мэдээлэл байршуулахаас 51 мэдээллийг	90%

	тавьж олон нийтэд төсөв, санхүүгийн ил тод, нээлттэй байдлыг хангуулах					хуулийн хугацаанд байршуулж, 3 мэдээллийг хугацаа хоцроож, 1 мэдээлэлд засвар оруулсан. 4 мэдээлэл хугацаа нь болоогүй байна. Мэдээллээ хугацаа хоцорч оруулсан ажилтнуудын үйл ажиллагааг сайжруулах, зөрчлийг цаашид давтан гаргахгүй байхад анхаарч, шаардлага тавьж ажилласан.	
15	12.3.7. Орлого, зарлага, хөрөнгө оруулалтын өдөр тутмын гүйлгээг төрийн сангийн нэгдсэн дансаар дамжуулан төрийн сангийн төлбөр тооцооны найдвартай байдлыг ханган гүйцэтгэх, төсвийн зарцуулалтад тавих хяналтыг тухай бүр хэрэгжүүлж ажиллах	-	Мөнгөн дүн, тэрбум төгрөг	232.3	234	Монгол улсын Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Засгийн газрын 2015 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн 24 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд төсвийн байгууллагуудын дансыг нээх, хаах, төсөвт байгууллагад мөрдөгдөх мөнгөн кассын үйл ажиллагааны, төрийн сангийн төлбөр тооцооны журмуудыг мөрдөн ажиллалаа. Төрийн сангийн нийт 214 байгууллагын 279 орлого, зарлагын дансаар төрийн сангийн үйлчилгээг үзүүлж, ямар нэгэн чирэгдэл гаргахгүй байхаар ажлыг зохион байгуулан ажиллалаа. Тайлант хугацаанд өдөрт дунджаар 185 төлбөр тооцооны гүйлгээ хийгдэж, хүлээгдэж буй гүйцэтгэлээр нийт гүйлгээний тоо 32188, үнийн дүн 248,5 тэрбум төгрөгт хүрсэн байна. Монгол улсын Үндсэн хууль, Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулиудын шинэчлэл, Монгол улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль батлагдсантай холбоотойгоор төрийн болон орон нутгийн өмчийн боловсрол, эрүүл мэнд, нийгэм, соёлын байгууллагын барилга байгууламж, хөдлөх хөрөнгийн ашиглалт, засвар, үйлчилгээ орон нутгаас санхүүжихтэй холбоотойгоор тухайн холбогдох байгууллагуудын байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, үйлчилгээний ажилчдын цалин, НДШ-ийг тооцоолон байгууллага тус бүрээр хуваарилан, төсвийн төлөвлөлтийн нэгдсэн системд татуулсан бөгөөд сар бүр тухайн байгууллагын зарцуулалтад хяналт тавин, өр авлагын мэдээн дээр ажиллаж байгаа болно. Төрийн албаны цалингийн нэгдсэн системээр нийт 107 байгууллага эрхийн бүртгэлийн санг ашиглан, цалингаа цахимаар илгээж, баталгаажуулсан.	100%
16	12.3.8. ОНӨААТҮГ, өөрийн орлого бүрдүүлэгч	-	Хамрагдах байгууллага, тоо	0	5	Усан спорт сургалтын төв, Амралт цогцолборын газруудын үнэ тарифыг дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны 2 дугаар сарын 16-ны өдрийн ээлжит бус 2	100%

	байгууллагуудын тариф, үйлчилгээний үнэ, бүтэц орон тоог шинэчлэх					дугаар хуралдаанаар шинэчлэн тогтоолгож, 2022 оны 3 дугаар сарын 01-ны өдрөөс эхлэн шинэчилсэн тарифаар үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна. Захиалагчийн ажлын албанаас Бохир соруулах, тээвэрлэх, ахуйн шавж, мэрэгч устгах, ариутгах, халдваргүйтгэлийн үнийн тарифыг зах зээлийн үнийн судалгааг хийж, 2022 оны 5 дугаар сарын 09-ний өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, 04 дүгээр тогтоолоор үнэ, тарифийг шинэчлэн тогтоосон. Дүүргийн Засаг даргын 2022 оны 3 дугаар сарын 09-ний өдрийн А/109 дүгээр захирамжаар Усан спорт сургалтын төв, 2022 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн А/190 дүгээр захирамжаар Амралт цогцолборын газруудын бүтэц орон тоог шинэчлэн ажилласан.	
<b>Зорилт 12.4. Дүүргийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, шаардлагатай тохиолдолд холбогдох бусад байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх, илэрсэн дутагдлыг арилгуулах, үр дүнг тооцно.</b>							
17	12.4.1. Дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 2021 оны арга хэмжээний төлөвлөгөөний хагас, бүтэн жилийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	Үйл ажиллагааны хөтөлбөрийн явц 22,2, арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт 83,3 хувьтай хэрэгжсэн.	90-ээс дээш хувьтай хэрэгжсэн байх	Дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 2022 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтэд явцын хяналт-шинжилгээг 2 удаа хийж, Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулсан. Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д заасан аргачлалын хүрээнд Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны 83 заалттай хөтөлбөрийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд 78%-тай, хөтөлбөрийг 2022 онд хэрэгжүүлэх арга хэмжээний 206 заалттай төлөвлөгөөний хэрэгжилт 89 хувьтай байна.	100%
18	12.4.2. Дээд газрын тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	Тогтоол шийдвэрийн хэрэгжилт 87.5 хувь	90-ээс дээш хувьтай хэрэгжсэн байх	Дээд газраас ирсэн 78 тогтоол, шийдвэрийн 140 заалтын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж ажиллалаа. Дээд газрын тогтоол, шийдвэрийн 2022 оны жилийн эцсийн хэрэгжилтийг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын хавсралт “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх” нийтлэг журмын хүрээнд гүйцэтгэлийг тооцоход 94,8 хувьтай байна.	100%
<b>Зорилт 12.5 Батлан хамгаалах хууль тогтоомжийг орон нутагт сурталчлах, хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулж биелэлтэд хяналт тавин, иргэдэд төрийн батлан хамгаалах үйлчилгээг хүртээмжтэй, чирэгдэлгүй хүргэнэ.</b>							

19	12.5.1. Иргэн Монгол Улсын үндсэн хуулиар хүлээсэн цэргийн алба хаах үүргийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах	30.8 Дүүргийн төсөв	Цэргийн бүртгэл, цэрэг татлагад хамрагдалт, хувь	Цахим хэлбэрээр 96.1 хувьтай зохион байгуулсан.	96	2022 оны цэргийн бүртгэлийг нийслэлийн Засаг даргын 2021 оны А/980, дүүргийн Засаг даргын 2021 оны А/723 дугаар захирамжийн дагуу 2022 оны 01 дүгээр сарын 05-наас 21-ий өдрүүдэд зохион байгуулж бүртгэлийн ажил дүүргийн хэмжээнд 95 хувьтай явагдсан. Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/512, дүүргийн Засаг даргын 2022 оны А/188 дугаар захирамжийн дагуу 2022 оны нэг, хоёрдугаар ээлжийн цэрэг татах ажлыг зохион байгуулав. Нэгдүгээр ээлжийн цэргийн жинхэнэ албанд иргэдийг татах ажлыг 05 дугаар сарын 06-аас 08-ны өдрүүдэд хоёрдугаар ээлжийн цэргийн жинхэнэ албанд иргэдийг татах ажлыг 10 дугаар сарын 20-23 ны өдрүүдэд зохион байгуулж, нийслэлийн Засаг даргаас өгөгдсөн тоон даалгаврыг бүрэн биелүүлсэн.	100%
20	12.5.2. Дайчилгааны бэлэн байдлыг хангаж, хуулиар хүлээсэн бүх төрлийн сургалтыг зохион байгуулж, дадлага олгох материаллаг баазыг бэхжүүлэх	10.0 Дүүргийн төсөв	Зохион байгуулах сургалт, тоо	“Бэлтгэл офицерын дамжаа”-нд 4 иргэнийг хамруулж, сургалтын хөтөлбөрийн дагуу 168 цагийн хичээл орсон.	6	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын даргын 2022 оны н/02 дугаар тушаал, дүүргийн Засаг даргын 2022 оны н/03 дугаар тушаалын дагуу дайчилгаагаар нөхөн хангагдах Зэвсэгт хүчний анги, командуудад оногдуулан бүртгэсэн хүн, техникийн тодотголыг хийж, дайчилгааны даалгавартай ангиудтай тодотголыг дүүргийн Засаг даргын захирамжид заагдсан хугацаанд нь бүрэн хийж тодотгол хийсэн. “Дайчилгааны бэлтгэл нөөц чухал мэргэжил бүхий офицер бэлтгэх сургалт”-ыг 2022 оны 08 дугаар сарын 01-ний өдрөөс 30-ны өдрүүдэд зайн сургалтын хэлбэрээр зохион байгуулсан. Бэлтгэл офицерын дамжаанд 4 цэргийн үүрэгтэн хамрагдаж амжилттай төгссөн. Зэвсэгт хүчний 011 (25 иргэн), 013 (10 иргэн), 017 (25 иргэн), 119 (20 иргэн), 311 (10 иргэн) дүгээр ангиудад нийт 90 цэргийн нэгдүгээр зэргийн бэлтгэл үүрэгтнийг тоон даалгаврын дагуу давтан бэлтгэх сургалтыг явуулсан. Дайчилгааны нэгдүгээр зэргийн бэлтгэл үүрэгтний цэргийн болон цэрэг-техникийн бэлтгэлийг дээшлүүлэх, тэдний эх-оронч үзлийг төлөвшүүлэх зорилгоор дээрх ангиудын материаллаг баазыг түшиглэн цэрэгт бүртгэлтэй шаардлагатай мэргэжлээр хамрагдах хилийн болон дотоодын цэрэгт алба хаасан цэрэг-түрүүч нарын давтан бэлтгэх сургалтыг 2022 оны 05, 06, 08, 09 дүгээр саруудад 5 хоногийн хугацаатай сургалтын хөтөлбөр төлөвлөгөөний	100%

						дагуу онол, дадлагын хэлбэрээр чанартай зохион байгуулсан. Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/303, дүүргийн Засаг даргын А/96 дугаар захирамжаар “Оюутан цэрэг”-т цэргийн мэргэжил олгох сургалт явуулах тухай төсөв, хөрөнгийг батлуулан бэлтгэл ажлыг ханган дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг “Ач” анагаах ухааны их сургууль, “Эм Зүйн” Шинжлэх ухааны их сургууль, Шинэ анагаах ухааны их сургуулиудаас “E-Mongolia цахим системд хүсэлт гарган бүртгэлийн шалгуур үзүүлэлтэд тэнцсэн 4 оюутан танхимын болон хээрийн сургалтад бүрэн хамрагдаж төгссөн.	
21	12.5.3. Орон нутагт батлан хамгаалах хууль тогтоомж, Монгол цэргийн өдөр, Зэвсэгт хүчний үйл ажиллагааг сурталчилж, залуучуудад цэрэг эх оронч үзлийг төлөвшүүлэх	10.0 Дүүргийн төсөв	Зохион байгуулах арга хэмжээ, тоо	6 аж ахуй нэгж байгууллагын 600 гаруй цэргийн насны эрэгтэйчүүдийн цэргийн үүрэгтний үнэмлэхэнд үзлэг, шалгалтыг хийж гарын авлага тараах ажлыг зохион байгуулав.	6	Монгол Улсын "Батлан хамгаалах тухай" хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1 дэх заалтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын даргын баталсан аж ахуйн нэгж, байгууллага шалгах нэрийн жагсаалт, дүүргийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжийн хүний нөөцийн мэргэжилтнүүдэд “Батлан хамгаалах тухай хууль тогтоомж, иргэний цэргийн үүргээ биелүүлэхтэй холбоотой хууль тогтоомж, зааварчилгаа” олгох сургалтыг 02 дугаар сарын 17-ны өдөр зохион байгуулсан. Батлан хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилт, 18-50 насны эрэгтэйчүүдийн цэргийн үүргийн биелэлтийг шалган туслах ажлыг хуваарийн дагуу Газар зохион байгуулалтын алба, дүүргийн 20 дугаар хороо, Үндэсний дата Төв, “Хаан хүнс” ХХК, “Цахиур”ХХК, “Эм Жи Эл Акуа” ХХК-д хийсэн. шалган туслах ажилд нийт 195 цэргийн үүрэгтэн хамрагдсанаас цэргийн бүртгэлд хамрагдаагүй 22, цэргийн үүрэгтний үнэмлэхгүй 22, шилжилт хөдөлгөөн хийгдээгүй 21, цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах 46 иргэнийг тогтоон мөнгөн төлбөрийн тооцооны хуудсыг өгч нийт 5,322,639 төгрөгийг нийслэлийн Төрийн санд төвлөрүүлсэн. Монгол цэргийн өдөр, Зэвсэгт хүчний 101 жилийн ойн төлөвлөгөөний дагуу дүүргийн ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд “Би эх орны хүү” богино видео бичлэгийн, “Иргэний цэргийн үүрэг-Цэргийн штаб” сэдэвт зохион бичлэгийн	100%

						<p>уралдаануудыг зохион байгуулж нийт Ерөнхий боловсролын 12 сургуулийн 120 гаруй сурагч хамрагдсан. Засаг даргын Тамгын газар болон 43 хорооны алба хаагчдын дунд бэлтгэл хурандаа Р.Нэргүйн нэрэмжит "Цэргийн алдар" тэмцээнийг 03 дугаар сарын 10-ны өдөр дүүргийн Биеийн тамир спортын хороонд "Мөрдэс нэгт цэргийн андууд" сэдэвт уулзалт, урлаг соёлын баярын арга хэмжээг 03 дугаар сарын 14-ний өдөр Дотоодын Цэргийн 05 дугаар ангийн байрлалд зохион байгуулж нийт 70 гаруй алба хаагч 100 гаруй сурагч хамрагдсан. Сонгинохайрхан дүүрэг үүсгэн байгуулагдсаны 30 жилийн ойг угтан "Иргэн-цэргийн харилцааны өдөрлөгийн арга хэмжээний хүрээнд "Үндэсний бөхийн барилдааныг өсвөр үедээ уламжлуулъя" сэдэвт өсвөр үеийн бөхийн барилдаан, бөхийн цол дуудах тэмцээнийг 03 дугаар сарын 15-ны өдөр дүүргийн Биеийн тамир, спортын хороонд зохион байгуулж тэмцээнд дүүргийн ерөнхий боловсролын 18 сургуулийн 90 гаруй хүүхэд 5 насны ангиллаар барилдаж авхаалж самбаагаа сорьлоо. Дүүргийн Засаг даргын нэрэмжит цэрэг спортын "Дөл" цогцолбор тэмцээнийг 4 дүгээр сарын 23, 24-ны өдрүүдэд зохион байгуулж нийт ерөнхий боловсролын 20 сургуулийн 300 гаран сурагч авхаалж самбаагаа сорьлоо Мөн энхийг сахиулагчдын өдрийг тохиолдуулан 04 дүгээр сарын 24-ны өдөр Зэвсэгт хүчний 017 дугаар ангид Ерөнхий боловсролын 13 сургуулийн 130 сурагчдыг хамруулан "Энхийг сахиулагч -20" жил уулзалт танилцах аяллыг зохион байгуулж явууллаа. Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч Ухнаагийн Хүрэлсүхийн санаачилгаар зохион байгуулагдаж буй "Бидний бахархал" төслийг Хил хамгаалах ерөнхий газартай хамтран зохион байгуулсан. Тус арга хэмжээнд нийт 1300 гаруй оюутан, сурагчид хамрагдсан.</p>	
<b>Зорилт 12.6 Эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, малын үүлдэр угсааг сайжруулж, бүртгэлжүүлэх ажлыг зохион байгуулна.</b>							
22	12.6.1. Мал амьтны тооллого, ээмэгжүүлэлт, бүртгэлжүүлэлтийг зохион байгуулж,	20.0 Дүүргийн төсөв	Ээмэгжүүлж, бүртгэлжүүлэх мал, тоо, /Хээлтэгч, тоо/	6278, /297/	8278, /497/	Дүүргийн Засаг даргын 2021 оны мал, тэжээвэр амьтдын тооллого явуулах тухай А/698 дугаар захирамжийн хүрээнд мал бүхий хороодод 2021 оны 12 дугаар сарын 07-17-ны хооронд 43 чиглэлд, 96 албан хаагч ажилласан. Мал тооллогын үед баримтлах заавар зөвлөмжийг	90%



	зохиомол хээлтүүлэг хийх					танилцуулан, Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газар болон статистикийн хэлтэстэй хамтран 21, 32, 33, 34 дүгээр хороодын тоологч нарт сургалт мэдээлэл өгч ажилласан. Малын тоо 2022 оны 01 дүгээр сарын 20-нд мал тооллогын программд бүрэн шивэгдэж эцсийн байдлаар 82358 толгой мал тоологдсон. Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын А/72 дугаар тушаалаар малыг ялган тэмдэглэж, бүртгэлжүүлэх, бүртгэл мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх арга хэмжээний хүрээнд дүүргийн Засаг даргын 2022 оны А/607 дүгээр захирамжийн дагуу мал бүхий 21, 32 дугаар хороодод намрын технологит хугацаанд 2000 өсвөр сүүний үхрийг /хээлтэгч/ ээмэгжүүлж, бүртгэлжүүлэх ажлын удирдамж, төлөвлөгөөг боловсруулан гаргаж, “Хатан хангай хайрхан” ТББ-тай ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан. Ээмэгжүүлэлт 80%-ийн гүйцэтгэлтэй байна.	
23	12.6.2. Дүүргийн өвс, тэжээлийн фонд байгуулах, нөөц бүрдүүлэх	80.0 Дүүргийн төсөв	Өвс, тэжээл, тн	2021 онд 20 тн тэжээл	10 тн өвс, 10 тн тэжээл	Дүүргийн 32 дугаар хорооны нутаг дэвсгэр 369-ийн гарамд дүүргийн өвс, тэжээлийн фонд байгуулах газрын асуудлыг 2022 оны 3-р сард шийдвэрлэсэн. 2022-2023 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах ажлын хүрээнд 32-р хороо 369 дүгээр гарамд байрлах дүүргийн Өвс, тэжээлийн фондны хашааг сунган, эвдрэлтэй хэсгүүдийг засварлан, хаалгыг шинээр сольсон. Мөн өвс, тэжээл хадгалах чингэлэгийг худалдан авч, дүүргийн өвс, тэжээлийн фондны хашаанд буулгаж хүлээн авсан. Дүүргийн Засаг даргын 2022 оны А/630 дугаар захирамжийн дагуу 10 тн тэжээлийг “Алтан тариа” ХХК-тай гэрээ байгуулан хуваарийн дагуу авч тэжээлийн нөөц бүрдүүлсэн. Мал бүхий 21, 32 дугаар хороодод өвөлжилт, хаваржилт хүндэрсэн нөхцөлд тэжээл нийлүүлэх зорилгоор Алтан тариа ХХК-тай 165 тн тэжээл худалдан авах гэрээ хийсэн. Малчдын түвшинд өвс-5358 тн, ногоон тэжээл-4528 тн, тэжээл-2451 тн, дарш-24тн, хужир-324тн тус тус бэлтгэсэн	90%
24	12.6.3. Мал, амьтныг гоц халдварт, халдварт, шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх	20.0 Дүүргийн төсөв	Вакцинжуулах мал, тоо, /Ариутгал хийх талбай, м2/	264358 /давхардсан тоогоор/ 630192	260000 /давхардсан тоогоор/ 630192	Дүүргийн Засаг даргын 2022 оны А/04, А/608 дугаар захирамжийн дагуу Мал бүхий 21, 32, 33, 34 дүгээр хороодын шүлхий өвчинд мэдрэмтгий Мал, амьтныг урьдчилан сэргийлэн вакцинжуулалтад Сонгинохайрхан дүүрэг дэх Мал эмнэлгийн үйлчилгээний нэгж Буян-хөхий	90%

	<p>вакцинжуулалтад хамруулж, ариутгал халдваргүйжүүлэлт хийх, мал амьтны, сэг зэм устгалын ажлыг зохион байгуулах</p>				<p>ХХК, Рез ХХК, Бамбуу ХХК-ууд 2022 оны 01 дүгээр сарын 10-ны өдрөөс, 02 дүгээр сарын 20-ны хооронд мал бүхий 1320 өрхийн 23767 толгой үхэр, 20607 толгой хонь, 21643 толгой ямаа, 5049 гахай нийт 71066 толгой мал, амьтан, 2 ээлж 09 дүгээр сарын 30-аас 10 дугаар сарын 25-ны хооронд 1219 өрхийн 27285 үхэр, 5389 гахай нийт 32674 толгой мал, амьтанд нийт хийж гүйцэтгэсэн. Нийт малчин, мал бүхий /давхардсан тоогоор/ 2539 өрхийн 51052 толгой үхэр, 20607 толгой хонь, 21643 толгой ямаа, 10438 толгой гахай нийт 76567 толгой мал, амьтан хамрагдахаас 103740 толгой мал, амьтан хамруулж 100% гүйцэтгэсэн. Дүүргийн Засаг даргын 2022 оны Мал, амьтны гоц халдварт, халдварт шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний тухай А/205 дугаар захирамжийн хүрээнд Гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтад 94024 толгой мал, амьтан хамрагдахаас 93067 толгой мал хамрагдаж 100%, Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтад 55206 толгой мал, амьтан хамрагдахаас 44018 толгой мал, амьтан хамрагдаж 80%, шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 75700 толгой мал, амьтан хамрагдахаас 43812 толгой мал, амьтан хамрагдаж 57,8%-тай хийгдсэн. Нийт 301500 толгой мал, амьтан хамруулахаас 284637 толгой мал, амьтан хамруулсан.</p> <p>Дүүргийн Засаг даргын 2022 оны А/266 21, 32 дугаар хороодын нутаг дэвсгэрт байгаа Мал, амьтны сэг зэм устгах, ариутгал, халдваргүйтгэл хийх ажлыг 2022 оны 05 дүгээр сарын 09-өөс, 05 дугаар сарын 25-ны хооронд 21, 32 дугаар хороо, Сонгинохайрхан дүүрэг дэх Мал эмнэлгийн тасаг, Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүд, “Улаанбаатар шинэчлэл” ХХК-тай хамтран зохион байгуулан нийтдээ 430 сэг зэмийг тээвэрлэн, Тусгалт хогийн цэгт буулган дарж булшлан, устгалын болон голомтын цэгийн ариутгал, халдваргүйтгэл болон үүсмэл болон төвлөрсөн хогийн цэг, худаг, уст цэг, бэлчээрийн нийт 181849 м<sup>2</sup> талбай, Түүхий эд, бүтээгдэхүүн хадгалах цэг, зoorь, малын хашаа хороо, тоног хэрэгсэлийн 413081м<sup>2</sup> талбай, нийт 594930м<sup>2</sup> талбайд ариутгал, халдваргүйтгэл хийсэн.</p>	
--	---	--	--	--	--	--

25	12.6.4. Газар тариалан эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжийг дэмжиж, бүтээгдэхүүн борлуулалтад дэмжлэг үзүүлж ажиллах	2.0 Дүүргийн төсөв	Хамрагдах иргэн, ААН, тоо	2021 онд хөнгөлөлттэй зээлд 27 иргэн, 6 чингэлэгт 53 иргэн гэрээ байгуулсан.	50	2022 онд газар тариалан эрхлэгч нарт Засгийн газраас 2 жилийн хугацаатай жилийн 3%-ийн хүүтэй зээл олгохоор шийдвэрлэсэний дагуу дүүргийн нутаг дэвсгэрт болон бусад орон нутагт тариалан эрхлэдэг 533 иргэн, 47 аж ахуй нэгжийн мэдээллийг ХХААХҮЯ-аар дамжуулан, “Монгол банк”-ны мэдээллийн санд оруулж зээл авах жагсаалтад бүртгүүлсэн. 2022 оны хаврын тариалалтад зориулан 80% хөнгөлөлттэй үнээр 11 нэр төрлийн 320,7 кг үрийг 304 өрхийн тариалан эрхлэгчдэд хороодоор дамжуулан тараасан. Хүнс, хөдөө аж ахуйг дэмжих сангаас 3 иргэнд хөнгөлөлттэй нөхцөлөөр нийлэг хальсан хүлэмж олгох хүсэлтийг уламжилж шийдвэрлүүлсэн. “Аптан намар-2022” үзэсгэлэн худалдаанд шинэ ургацын төмс, хүнсний ногооны худалдаагаар 6 байршилд 48 ногоочин 08 дугаар сарын 01-ээс, 10 дугаар сарын 20-н хүртэл батлагдсан байршилд гарч үзэсгэлэн худалдаанд оролцсон. Дүүргийн Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэстэй хамтран үзэсгэлэн худалдаанд оролцож байгаа ногоочидтой гэрээ байгуулан, Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн А/138 дугаар тушаалыг танилцуулан заавар, зөвлөмж өгч ажилласан. Үзэсгэлэн худалдаанд 18 нэр төрлийн 127,8 тн төмс, хүнсний ногоо худалдан борлуулж, 333,9 сая төгрөгийн борлуулалт хийгдсэн. Дүүргийн хэмжээнд 47 аж ахуй нэгж, 533 иргэн 1033 га-д тариалалт хийж 6536,84 тн ургац хураан авсан.	100%
<b>Зорилт 12.7 Авто замуудыг сайжруулж, нийтийн тээврийн хүртээмжийг нэмэгдүүлэн гэр хорооллыг орон сууцжуулах, байгальд ээлтэй, эрчим хүчний хэмнэлттэй дэвшилтэт технологи шингэсэн хувийн сууцны болон орон сууцны хороолол болгон хөгжүүлнэ.</b>							
26	12.7.1. 24 дүгээр хороонд инженерийн шугам сүлжээний ажлыг эхлүүлэх	2,000.0 Нийслэлийн төсөв	Ажлын явц, хувь	“Толгойт дэд төв”-ийн үерийн далангийн газар чөлөөлөлтийн нөлөөллийн суурин судалгааг боловсруулсан.	40 хувьд хүргэх	Нийслэлийн төсвийн 3.0 тэрбум төгрөгийн хөрөнгөөр 24 дүгээр хороонд хийгдэх инженерийн шугам сүлжээний ажлын гүйцэтгэгчээр “Есөн талст оргил констракшн” ХХК шалгарсан. Ажил гүйцэтгэх шатанд	30%
27	12.7.2. Үерийн хамгаалалтын далан, ус зайлуулах суваг	1,115.0 Улсын төсөв,	Далан, сувгийн ажлын явц, км	Үерийн хамгаалалтын далан, ус зайлуулах суваг	1.3	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2021-2022 онд он дамжин хийгдэж байгаа дүүргийн 10, 28 дугаар хорооны нутаг дэвсгэрт үерийн хамгаалалтын далан, ус зайлуулах суваг барих ажлын гүйцэтгэгчээр “Мэлч анд” ХХК шалгарч	30%

	барих /10, 11, 28 дугаар хороо/	120.0 НОНХС		барих ажил тендер зарлагдаж, зураг төсөл хийгдэх шатандаа байна.		ажил гүйцэтгэн дуусч, 2022 оны 12 дугаар сард багтаан байнгын ашиглалтад хүлээж авахаар ажиллаж байна. Дүүргийн 8, 40 дүгээр хорооны нутаг дэвсгэрт хийгдэх үерийн хамгаалалтын далан барих ажлын гэрээ, зураг төсөл батлагдаж магадлалаар орж гүйцэтгэгчээр "Тэмээн" ХХК шалгарсан.	
28	12.7.3. Баянголын амны баруун талаас 22-н товчооны баруун талын гарц хүртэлх авто замын ажлыг эхлүүлэх	7,392.0 Нийслэлийн төсөв	Авто замын ажлын явц, хувь	0	70	Нийслэлийн төсвийн хөрөнгө 7,392,0 сая төгрөгний хөрөнгө оруулалтын санхүүжилтээр Баянголын амны баруун талаас 22-н товчооны баруун талын гарц хүртэлх авто замын ажлын гүйцэтгэгчээр Түм-Арвижих ХХК шалгарч, ажил гүйцэтгэж байна.	50%
29	12.7.4. Гэр хорооллын гудамж дундах хатуу хучилттай авто замуудын ажлыг дуусгах /5, 6, 7, 8, 10, 11, 25, 30, 31, 32 дугаар хороо/	2,982.3 Улсын төсөв, 5,619.0 Нийслэлийн төсөв	Ашиглалтад оруулах авто зам, км	22.7	17.5	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар дүүргийн 5, 6, 7, 8, 10, 11, 25, 30, 31, 32 дугаар хороодын гудамж дундах хатуу хучилттай авто замуудын ажил үргэлжлэн хийгдэж эхэлсэн. Үүнд: -6 дугаар хорооны Тоосгоны 20 дугаар гудамжнаас Хангай зах хүртэлх 1,500,0 сая төгрөгийн санхүүжилттэй хатуу хучилттай авто замын гүйцэтгэгчээр "Баян өлзийт зам" ХХК шалгарч ажил бүрэн дуусч, комисс ажиллуулах саналыг хүргүүлсэн. -6 дугаар хороо Ханын материал орчмын орон сууцын хороолол доторх 1,800,0 сая төгрөгний санхүүжилттэй авто замын ажил 5 байршилд газар чөлөөлөлтийн асуудалтай байгаа тул, Нийслэлийн газар чөлөөлөлтийн хэлтэс болон Нийслэлийн Замын хөгжлийн газартай зөвшилцөн ажлыг эхлүүлсэн. -30, 31 дүгээр хороодын дундах хатуу хучилттай 3.6 км авто замыг 110,1 сая төгрөгөөр "Их харгуйн зам" ХХК гэрээний дагуу ажил үргэлжлэн хийгдэж байна. -Дүүргийн соёлын төв дагуух 1098,2 сая төгрөгийн санхүүжилттэй хатуу хучилттай авто замын гүйцэтгэгчээр "Баян өлзийт зам" ХХК шалгарч ажил гүйцэтгэх явцад газар чөлөөлөлтийн асуудлаас болж ажил удааширсан. -32 дугаар хороо Эмээлт Шонхор худалдааны төвөөс Хурганы хэсэг хүртэлх 1,200,0 сая төгрөгний санхүүжилттэй хатуу хучилттай авто замын ажлын гүйцэтгэгчээр "Энигма констракшн" ХХК шалгарч, ажил гүйцэтгэх гэрээ сунгагдсан.	90%

						-Хувьсгалчдын гудамжнаас 105 дугаар сургууль, Гүнжийн нуурыг дайраад 7 дугаар хорооны авто зам хүртэлх 2,400,0 сая төгрөгийн санхүүжилттэй авто замын ажлыг "Дэд бүтэц" ХХК хийж гүйцэтгэсэн. Тухайн замын үргэлжлэлийн замын ажлын тендер Нийслэлийн Замын хөгжлийн газар, Зам тээврийн хөгжлийн яаманд тендер зарлагдаж гүйцэтгэгч шалгарах шатандаа байна. Нийслэлийн замын сангийн 2,395,1 сая төгрөгөөр 31 дүгээр хорооноос эгц хойшоо гадна тойруу хүртэлх авто замын гүйцэтгэгчээр "МАЗ" ХХК 2021 онд шалгарч, 2022 оны 09 дүгээр сард замын ажил бүрэн дуусч, байнгын ашиглалтад оруулсан. 10 дугаар хороо Баянхошууны эцсийн буудлаас хойш үргэлжлэх 2,419,0 төгрөгийн санхүүжилттэй 3.0 км авто зам, гүүрийн эхний ээлжийн ажлын гүйцэтгэгчээр "Алтай рөүд" ХХК шалгарч ажил гүйцэтгэж байна.Нийслэлийн төсвийн 2,133,1 сая төгрөгний хөрөнгө оруулалтаар Хайгуулчдын гудамж болон Хүнсчдийн гудамжны дагуу шинээр барих болон шинэчлэх авто замын ажлын гүйцэтгэгчээр Тэмүүн Холдинг ХХК гүйцэтгэгч компани шалгарч, авто замын урсгалыг нээж, улсын комисст хүлээлгэн өгсөн.	
30	12.7.5. Эрчим хүчний гудамжнаас Монос фарм трейд ХХК хүртэлх Таван толгой түлш ХХК-ийн зүүн талаар, Хайгуулчдын гудамж болон Хүнсчдийн гудамжны дагуу авто замын ажлыг шинээр барих болон шинэчлэх	5,024.0 Нийслэлийн төсөв	Авто замын ажлын явц, хувь	0	70	Нийслэлийн төсвийн 2,869,0 сая төгрөгний хөрөнгө оруулалтаар 20 дугаар хорооны Эрчим хүчний гудамжнаас "Монос фарм трейд" ХХК хүртэлх авто замын ажлын гүйцэтгэгчээр Экспресс зам ХХК шалгарч, гэрээ байгуулагдсан. Нийслэлийн төсвийн 2,133,1 сая төгрөгний хөрөнгө оруулалтаар Хайгуулчдын гудамж болон Хүнсчдийн гудамжны дагуу шинээр барих болон шинэчлэх авто замын ажлын гүйцэтгэгчээр Тэмүүн Холдинг ХХК гүйцэтгэгч компани шалгарч, авто замын ажил бүрэн дууссан.	90%
31	12.7.6. 1 дүгээр хорооллын арын холбоос авто зам, замын байгууламжийн ажлыг эхлүүлэх	4,000.0 Нийслэлийн төсөв	Авто замын ажлын явц, хувь	0	70	Дүүргийн 1 дүгээр хорооллын арын холбоос авто зам, замын байгууламж нь Толгойтын авто замыг Ард аюушийн өргөн чөлөөтэй холбох 3.6 км авто замын ажил хийгдэхээр төлөвлөгдсөн. Авто замын трасст 6, 23, 30, 31, 37, 43 дугаар хорооны нийт 324 нэгж талбар нөлөөлөлд өртсөн. Үүнээс 43 нэгж талбарыг нөлөөллөөс гаргаж, 281 нэгж талбараас 197 нэгж талбартай зөвшилцөн газар	30%

						чөлөөлөлтийн ажлыг гүйцэтгэж байна. 84 нэгж талбарын айл өрх, аж ахуйн нэгж байгууллагатай газар чөлөөлөлтийн талаар зөвшилцөх ажил хийгдэж байна.	
32	12.7.7. Баянхошуу дэд төвийн бүтээн байгуулалтын ажлыг бүрэн дуусгах	-	Ажлын гүйцэтгэл, хувь	90	100	Баянхошуу дэд төвийн бүтээн байгуулалтын II үе шатны ажил дүүргийн 40 дүгээр хороо, барилга байгууламжуудыг хангах, дулааны шугам, УДДТ-ийн барилга байгууламжийн угсралтын ажлыг хийж гүйцэтгэхээр “Эс энд Эй Трэйд” ХХК шалгарсан. Дулааны шугамын трасст өртсөн гэрэлтүүлгийн шонг шилжүүлэх ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран шийдвэрлэсэн.	70%
33	12.7.8. Толгойт дэд төвийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх	-	Ажлын гүйцэтгэл, хувь	5	15	Нийслэлийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2020 оны 125 дугаар тогтоолоор дэд төвүүдийн байршил талбайн хэмжээг дүүргийн 1, 2, 3, 34, 35 дугаар хорооны нутаг дэвсгэр дэх “Толгойт дэд төвийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, 736.9 га талбайд” хийгдэхээр төлөвлөгдсөн. 1, 2 дугаар хороонд байршилтай дэд төвийн гадна шугам сүлжээний ажлын зураг төслийг “Пи Си Ди Пи” ХХК нь гүйцэтгэсэн. 1 дүгээр хорооны Толгойтын 51 дүгээр гудамжны үерийн хамгаалалтын барилга байгууламжийн гүйцэтгэгчээр “Монгол менежмент” ХХК шалгарсан. Үерийн барилга байгууламжийн нөлөөлөлд өртсөн 66 ширхэг гэрэлтүүлгийг нүүлгэн шилжүүлэх ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулан, “Нэмэх гэрэл” ХХК-тай гэрээ байгуулсан. Зураг төслийн ажлын явц 55,78%, газар чөлөөлөлт нүүлгэн шилжүүлэлтийн ажлын явц 27%-тай байна.	70%
34	12.7.9. Хилчин хотхоны инженерийн шугам сүлжээний ажлыг дуусгах /30 дугаар хороо/	2,800.0 Улсын төсөв	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	70	100	Улсын төсвийн 2,754,8 сая төгрөгний санхүүжилтээр 30 дугаар хороо Хилчин хотхоны инженерийн шугам сүлжээний ажлын дулаан шугам барих ажлын гүйцэтгэгчээр “И Жи Өү” ХХК шалгарч бүрэн дуусч, цэвэр бохир усны шугам барих ажлын гүйцэтгэгчээр “Монгол дайван” ХХК шалгарч, ажил гүйцэтгэх шатандаа байна.	70%
35	12.7.10. Дүүргийн 1, 2, 6, 19, 21, 24, 26, 36, 37, 41 дүгээр хороодын гудамж талбайн гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх	200.0 НОНСХ 551.8 сая ДОНХС	Ашиглалтад оруулах гэрэлтүүлэг, тоо	0	350	Дүүргийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө 552.2 сая төгрөгөөр 1, 2, 6, 19, 21, 24, 26, 36, 37, 41 дүгээр хороодод 245 ширхэг гэрэлтүүлэг хийгдэхээр зураг төсөв хийгдэж, гүйцэтгэгч компаниуд шалгарсан. Нийслэлийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө 600.0 сая төгрөгөөр 24, 41, 42 дугаар хороодод 300 ширхэг гэрэлтүүлгийг түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй	90%

						<p>хийхээр тендер зарлагдсан. 23, 29, 38, 39 дүгээр хороодод шинээр хийгдэх гэрэлтүүлгийн тооцоо судалгааг гаргаж, цахилгаан эрчим хүчинд холбох техникийн нөхцөлийн хүсэлтийг УБЦТС ТӨХК-д хүргүүлсэн. Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 1 дүгээр хороонд Инерци ХХК 77,6 сая, 2 дугаар хороонд Ингүүмэл эрчим ХХК- 54,1 сая, 6 дугаар хороонд Насака ХХК 24,1 сая, 19 дүгээр хороонд Кон Арч ХХК 44,3 сая, 21 дүгээр хороонд Эволво ХХК 45,3 сая, 24 дүгээр хороонд Кон Арч ХХК 57,8 сая, 26 дугаар хороонд Инерци ХХК-79,1 сая, 36 дугаар хороонд Инерци ХХК 38,5 сая, 37 дугаар хороонд Ингүүмэл эрчим ХХК 19,7 сая, 41 дүгээр хороонд Эволво ХХК 84,3 сая төгрөгөөр нийт 245 гэрэлтүүлэг угсралтын ажлыг хийж гүйцэтгэн бүрэн хүлээлгэн өгсөн. Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 40 дүгээр хороонд Эволво ХХК 59,6 сая, 24 дүгээр хороонд ДМТМ трейд ХХК 197,2 сая, 42 дугаар хороонд Энержи комплекс ХХК 192,2 сая төгрөгөөр 250 гэрэлтүүлэг угсралтын ажлыг хийж гүйцэтгэн хүлээлгэн өгсөн.</p> <p>-23, 29, 38, 39 дүгээр хороодод 273,5 сая төгрөгөөр нийт 105 ширхэг гэрэлтүүлэг хийгдэх зураг төсөв батлагдаж, гүйцэтгэгчээр “Холбоо трейд” ХХК шалгарсан. 1, 2, 22 дугаар хороодод 300,0 сая төгрөгөөр 125 гэрэлтүүлэг хийгдэхээр зургийг “Оргилт од” ХХК гүйцэтгэн батлуулсан. 10 дугаар хороонд 96,0 сая төгрөгөөр 60 гэрэлтүүлэг хийгдэхээр “Энержи сет” ХХК шалгарсан боловч гэрээний хугацаандаа ажлаа гүйцэтгээгүй тул гэрээ цуцлагдсан. 1 дүгээр хороонд 90,0 сая төгрөгөөр 40 гэрэлтүүлэг хийгдэхээр техникийн нөхцөлийг УБЦТС ТӨХК-иар гаргуулсан. Зураг боловсруулагдах шатандаа. 1, 10 дугаар хорооны гэрэлтүүлгийн ажлыг он дамжуулан хэрэгжүүлэхээр саналыг холбогдох байгууллагад хүргүүлсэн.</p>	
36	12.7.11. Нийтийн эзэмшлийн орон сууцны гадна фасадны засварын ажлыг хийх	617.2 Улсын төсөв	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	0	100	<p>2022 онд улсын төсвийн хөрөнгө 617,2 сая төгрөгийн санхүүжилтээр дүүргийн 12, 13, 14, 15, 16, 17, 18, 19, 27, 29-р хороодын орон сууцны гадна фасад засварын ажлын тендер зарлагдсан. Улсын төсвийн хөрөнгө 1,600,0 сая төгрөгөөр 7 дугаар хороо Хилчин хотхоны гадна фасад, дээвэр засварын ажлын тендэрт Цагаан толгойн нуур ХХК</p>	90%

						шалгарч, 5 байрны фасад хийхээс 3 байрны фасадны ажил 70% гүйцэтгэлтэй, 7 байрны дээвэр засвар ажлыг хийж гүйцэтгэхээс 3 байрны дээврийн засварын ажил 90% гүйцэтгэлтэй хийгдсэн. Гэрээг 2023 оны 08 дугаар сард дүгнэнэ.	
37	12.7.12. 42 дугаар сургуулийн 2, 3 дугаар байрны барилгын дулаан алдагдлыг бууруулах, эрчим хүчний үр ашгийг нэмэгдүүлэх засвар, шинэчлэлтийн ажлыг хэрэгжүүлэх	316.2 Нийслэлийн төсөв	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	40	100	Герман Монголын хамтарсан “Эрчим хүчний дулаан алдагдлыг бууруулах” төслийн хүрээнд 2021 онд 42 дугаар сургуулийн 2 дугаар байрны гадна фасадны их засвар ажлыг “Мөнх хархираа” ХХК, цонх дээврийн дулаалгын ажлыг “Антик” ХХК хийж гүйцэтгэсэн. Энэ ажилд нийт 640.0 сая төгрөг зарцуулсан. 2022 онд Нийслэлийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө 316.2 сая төгрөгөөр 3 дугаар байрны засварын ажлыг Антик ХХК хийж гүйцэтгэсэн.	100%
38	12.7.13. Орон сууцны байрны дээвэр засварын ажлыг хийж гүйцэтгэх /20, 27, 29, 38 дугаар хороо/	400.0 Улсын төсөв 216.7 НОНХС	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	0	100	Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт 216.7 сая төгрөгөөр 20 дугаар хорооны 7-р байр, 1-30, 27 дугаар хорооны 2б, 3а байр, 29 дүгээр хорооны грашийн дээвэр засварын ажлын тендер зарлагдсан. “Эй уан констракшн дизайн” ХХК нь 20, 27, 29, 38 дугаар хорооны 6 байрны 2681м2 дээвэр засварын ажлыг гүйцэтгэсэн. Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө 69,0 сая төгрөгийн өртөгтэй, түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй 19 дүгээр хорооны 1-58 дугаар байрны дээврийн засварын ажлын гүйцэтгэгчээр “Цаст оргил констракшн” ХХК шалгаран хийж гүйцэтгэсэн. Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө 69,5 сая төгрөгийн өртөгтэй, түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй 19 дүгээр хорооны 8-58 дугаар байрны дээврийн засварын ажлын гүйцэтгэгчээр “Саусгоби брэндс” ХХК шалгарч, зураг төсөв магадлалаар баталгаажсан. 27 дугаар хорооны 2б, 3а байрны дээврийн засварын ажлыг 148,2 сая төгрөгөөр хийж гүйцэтгэхээр Джихангар ХХК шалгарсан.	100%
39	12.7.14. Орон сууцны байрнуудад газар хөдлөлтийн тэсвэрлэлтийн үнэлгээ хийлгэх	40.0 Дүүргийн төсөв	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	0	100	Дүүргийн 19 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах ашиглалтын шаардлага хангахгүй 1-48, 2-48, 4-48, 3-20 дугаар байруудад дүүргийн төсвийн хөрөнгө 20.0 сая төгрөгөөр эд хөрөнгийн үнэлгээг хийлгүүлсэн. Цаашид дээвэр, фасадны засвар үйлчилгээ хийлгэх санал	70%



						ирүүлсэн байрнуудын тэсвэржилтийн үнэлгээг хийлгэх хүсэлтийг Хот байгуулалт, хөгжлийн газар хүргүүлсэн.	
<b>Хэсгийн дундаж хувь</b>							<b>82%</b>
<b>Гүйцэтгэлийн хувь:</b>							<b>89.2%</b>

**СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**